

ӨӨРЧЛӨГДӨН ШИНЭЧЛЭГДЭХ НЬ

Гуравдугаар дэвтэр:

Христ дотор шинэчлэгдсэн амьдралаар амьдрах нь

Билл Ловлесс

Христ бол амьдрал үйлчлэл

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН МЭДЭЭЛЭЛ

Copyright © 2011 by Bill Loveless

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ номыг арилжааны зорилгоор хувиран олшруулж ашиг олохыг хориглоно. Хувийн болон бүлгийн хэрэгцээнд ашиглахыг зөвшөөрнө.

Бүх библийн ишлэлүүдийг Ариун Библийн, New International Version® хувилбараас авсан болно, copyright © 1973, 1978, 1984 International Bible Society. Used by permission of Zondervan. Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Библийн ишлэлүүдийг Ариун Библийн, New Living Translation, copyright © хувилбараас авсан болно. 1996 by Tyndale Charitable Trust. Used by permission of Tyndale House Publishers.

Библийн ишлэлүүдийг Ариун Библийн, New American Standard Bible®, copyright © хувилбараас авсан болно. 1960, 1962, 1963, 1968, 1971, 1972, 1973, 1975, 1977, 1995 by The Lockman Foundation. Used by permission.

Библийн ишлэлүүдийг Ариун Библийн, the New King James Version, copyright © 1982 by Thomas Nelson, Inc. Used by permission. All rights reserved.

Библийн ишлэлүүдийг Ариун Библийн, (GNT) are from the Good News Translation in Today's English Version—Second Edition, copyright ©1992 by American Bible Society. Used by permission



Христ бол амьдрал үйлчлэл

Website: www.christislifeministries.com

Email: bill@christislifeministries.com

Өөрчлөгдөн шинэчлэгдэх нь

ГАРЧИГ

<i>1-р хичээл: Ариусгал гэж юу вэ?</i>	<i>5</i>
<i>Оюун бодлын шинэчлэл</i>	
<i>2-р хичээл : Оюун бодол дахь тулаан</i>	<i>23</i>
<i>3-р хичээл : Бодлын орчин дахь Сатаны нөлөө</i>	<i>38</i>
<i>4-р хичээл : Сэтгэл хөдлөлөө ойлгох нь</i>	<i>48</i>
<i>5-р хичээл : Шархалсан зүрхний эдгэрэл</i>	<i>57</i>
<i>6-р хичээл : Хүсэл зоригийн шинэчлэл</i>	<i>70</i>
<i>Эмтэрсэн байдал – Дүгнэлт</i>	

Хичээлийг судлах аргачлал

Энэхүү судлалыг сонгосонд талархал илэрхийлье. Энэ судлал Христитгэгч бүрийн ойлголтонд чухал үүрэгтэй гэдэгт би итгэдэг. Бурхан энэ үнэнээр дамжуулан миний амьдралд эргэшгүй өөрчлөлт шинэчлэлийг авчирсан билээ. Тиймээс би таныг зөвхөн энэ үнэний талаар мэдээд өнгөрөх биш харин амьдралдаа хувьчлан хэрэгжүүлээсэй хэмээн хүсч байна. Таныг эхлэхээс өмнө энэхүү номыг хэрхэн судлах талаар багахан тайлбар хийе.

Энэхүү номонд зургаан хичээл байгаа бөгөөд хичээл тус бүр 5 дэд хичээл буюу 5 өдөр уншиж судлах материалтай болно. Хичээл тус бүрт холбогдох **асуултууд, чимээгүй цаг гарган бодох ишлэлүүд, мөн Бурхантай харилцах нь** гэсэн хэсгүүд байгаа.

Бурхантай харилцах нь:

Энэ хэсэг нь та уншиж судалсан зүйлийнхээ төлөө ойлголт, илчлэлт, хэрхэн амьдралдаа хэрэгжүүлж болохоо Ариун Сүнснээс асуухад зориулагдсан цаг юм. Таны эндээс шинээр суралцаж буй зүйлс урьд нь таны итгэж явсан ойлголтуудтай зөрчилдөж эхлэхэд Ариун Сүнсний туслалцаа маш чухал. Энэ л үедээ та Бурханы үнэнийг эрж хайхгүй бол та өөрийн итгэж буй зарим нэг худал хуурмаг ойлголтуудыг ялган салгаж таних боломжгүй байдаг.

“Бясалгал” хэмээх үг:

Бясалгах гэдэг үгийн бусад шашинд хэрэглэгддэг утгаас болоод зарим хүмүүс хэрэглэхдээ эргэлздэг. Гэвч энэ нь библийн дагуух үг тул хэрэглэхээс зайлсхийх хэрэггүй бөгөөд гол түлхүүр нь ЮУГ болон ХЭНИЙ ТУХАЙ бясалгаж байна вэ гэдэгт л байгаа юм. Бидний бясалгалын утга учир нь Бурхан болон Бурханы үнэн дээр байх ёстой. Хэрэв танд “бясалгал” гэдэг үгийг хүлээж авахад хүндрэлтэй байвал “тунгаан бодох” гэдэг үгээр орлуулж болно.

Илчлэлт:

Энэ номд илчлэлт гэсэн үг олон удаа давтагдан гарна. Илчлэлт гэдэг нь Бурхан Өөрийн үнэнийг **ер бусын** аргаар миний амьдралын нөхцөлд тааруулан надад хувьчлан ойлгуулахыг хэлнэ. Илчлэлт таны ухамсар дахь ойлголтыг Бурханы үнэн болох сүнслэг ойлголт уруу шилжүүлж өгдөг.

ТА ЮУНД ИТГЭДЭГ ВЭ?

Та энэхүү судлалын туршид дараахь суурь үнэнийг санаарай.

Та өөрийн итгэж байгаагаас илүү гарч амьдарч чадахгүй.

Энэ яагаад чухал вэ гэвэл Христитгэлийн талаар танд худал, хуурмаг итгэл үнэмшил байгаа бол та тэр худал хуурмагаар л сонголт хийх болно. Учир нь таны юунд итгэж байгаа тань таны бодол, зан үйл, болон хийх сонголтуудад шууд нөлөөлдөг юм. Бурханы нэг хараа зорилго бол өөрийнхөө талаар, Христитгэлийн талаар, Бурханы талаар худал хуурмаг ойлголтуудыг танд илчлэн харуулах явдал юм. Улмаар худал хуурмаг ойлголтуудыг тань үнэнээр шинэчлэхийг хүсдэг. Энэхүү судлалыг хийж буй таныг “худал хуурмаг үнэмшлээс Бурхан таныг чөлөөлж, оюун санаанд тань шинэчлэл авчрахын төлөө залбирахыг урамшуулмаар байна.

Нэгдүгээр Хичээл

Ариусгал гэж юу вэ?

Оюун бодлын шинэчлэл

НЭГ ДЭХ ӨДӨР

“Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн.

Харин зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж....”

Ром 12:2а

Яагаад энэ судлалыг сонгох хэрэгтэй гэж?

Энэ бүлгийг эхлэхээс өмнө энэхүү судлал нь Христ дотор амьдарч сурах дараагийн алхам гэдэгт би яагаад итгэдэг гэдгээ тайлбарлая. Үүний тулд өмнөх хоёр дэвтрийн агуулгаас сурсан зүйлээ эргэн санацгаая. Нэгдүгээр дэвтэрт, Христ бидний Эх сурвалж болж бид Христээс эхтэй амьдрах нь юу болох тухай суурийг тавьсан.

Хоёрдугаар дэвтэрт, Христ доторх бидний шинэ мөн чанарын талаар суралцсан. (Үнэн мөн чанараар таны оюун бодлыг өөрчлөн шинэчилсээр байхыг Ариун Сүнсэнд зөвшөөрч өөрийгөө нээж өгч байгаа гэж найдаж байна) Энэхүү судлалаар бид сэтгэл санаа болон хүний сүнсний ялгааг олж мэдсэнийг санаж байгаа буй заа. Хүний сүнс (төгс, бүрэн дүүрэн г.м) ба сэтгэл санааны нөхцөл байдлын ялгааг ойлгох нь яагаад чухал болох талаар илчлэлийг Эзэн танд өгсөн гэж итгэж байна.

Тийм ч учраас энэхүү судлал нь бидний сэтгэл санааны нөхцөл байдлыг Бурхан хэрхэн өөрчлөн шинэчилдэгийг илүү гүнзгийрүүлж судлах тул бидний аялалын дараагийн алхам болох юм. Бид бодол, сэтгэл хөдлөл, сонголттойгоо нягт хамааралтай амьдардаг тул эдгээр бүх талбарт Христ биднийг өөрчлөн шинэчлэхэд өөрсдийгөө нээж сурах нь чухал юм.

Судлалыг илүү тодорхой болгох үүднээс хэлэлцэх сэдвийг доор дурдая:

- **Ариусгалын утга учир - сэтгэл санаанд хийх Бурханы өөрчлөлтийн үйл явц**
- **Таны бодлын орчин ба “үнэн”-ий шүүлтүүр бий болгох Бурханы үйл явц**
- **Оюун бодлын тулааны үнэн дүр төрх ба тулалдах арга зам**
- **Сэтгэл санаан дахь Сатан / чөтгөрийн нөлөө ба сүнслэг тулаан**
- **Гэмтсэн сэтгэл хөдлөлийн эдгэрэл ба шарх**
- **Бидний хүсэл зоригийн өөрчлөлт ба эмтэрсэн байдал**
- **Ариусгалын талаарх хүлээлтүүд**

Таны амьдралд гүн гүнзгий өөрчлөлт амсуулахын тулд Эзэн энэхүү судлалын үнэнийг ашиглана гэдэгт би итгэж байна. Бүгдээрээ “ариусгал”-ын теологийн ухагдахууныг ойлгохоос эхэлцгээе.

Ариусгал гэж юу вэ?

“Ариусгал “ гэдэг үгийг ойлгохоос эхлэх нь зүйтэй гэж би бодлоо. Бурханы өөрчлөн шинэчлэх үйл явцын библийн ухагдахуунуудын нэг нь ариусгал юм. Доорх ишлэлд “ариусгал “-ыг Паул иш татжээ.

“Харин одоо нүглээс чөлөөлөгдсөн ... ариусгалд хүрэх үр жимс авдаг...” Ром 6:22

“Харин та нар Түүнээс болж Христ Есүс дотор байгаа юм. Христ Есүс нь бидний хувьд Бурханаас ирсэн мэргэн ухаан, зөвт байдал, ариусгал ба золилт болсон юм.” 1 Коринт 1:30

Ариусгалын тодорхойлолт нь юу вэ?

АРИУСГАЛ

гэдэг нь “сэтгэл санаагаа шинэчилснээр дотроосоо цэвэрлэгдэх” гэсэн утгатай.

Энэхүү тодорхойлолтод орсон хоёр түлхүүр үг бол “сэтгэл санаа” ба “цэвэрлэх” юм. Ариусгалаар дамжуулан Бурхан бидний сэтгэл санааг өөрчлөн шинэчилж, цэвэрлэхийг хүсдэг бөгөөд ингэснээр бидний оюун бодол, хүсэл зориг, сэтгэл хөдлөл, үнэнтэй мөр зэрэгцдэг.

Хуучин гэрээны Дуулал 23:3 дээр Давид сэтгэл санааны шинэчлэл, сэргэлтийн хэрэгцээг дурьдсаныг харж болно.

“Тэр миний сэтгэлийг сэргээдэг...”

Бидний сэтгэл сэргэх нь яагаад чухал гэж? Ингэж байж л бидний бодол, сэтгэл хөдлөл, сонголтууд Христийнхтэй нийцнэ. Ром 8:29-ийн “Христийн дүртэй адилхан болгогдох” гэдэг нь Христтэй адил бодож, итгэж, сонгож, үйлддэг байхаар өөрчлөгдөхийг хэлж байгааг санаж байгаа байх.

Сэтгэл санааны ариусгалын үр дүнд бид Христтэй адил бодож, мэдэрч, сонгодог болсноор Христийн дүр төрхөөр шинэчлэгдэх юм.

Бясалгал: Сэтгэл санаагаа Ариун Сүнсээр ариусгуулахгүй байхын үр дагавар нь юу вэ?

Асуулт: Яагаад зөвхөн сэтгэл санаа л ариусгагдах хэрэгцээтэй вэ?

Бурхантай харилцах нь: Та өөрийн сэтгэл санааг Түүгээр цэвэрлүүлж, сэргээлгэж, ариусгуулах агуу их хүслийг өгөхийг Бурханаас гуйгаарай.

Авралын үе дэх бидний сэтгэл санаа болон сүнсний нөхцөл байдлын талаар эргэн нэг санацгаая.

Хүний сүнс болон сэтгэл санааны нөхцөл байдал:

Өмнөх дэвтэрт Бурхантай нэгдмэл болсон бидний сүнс төгс, бүрэн дүүрэн болдгийг үзсэн. Авралын үед бидний сүнс бүрэн амилуулагддаг. Тэгвэл бидний сэтгэл санаа яадаг вэ? Яг үнэнийг хэлэхэд авралын үед Бурхан бидний сэтгэл санааг өөрчлөн шинэчлэх тал дээр юуг ч хийж эхлээгүй байдаг. Тиймээс өөрчлөн шинэчлэгдэх хэрэгцээтэй байдаг талбар бол бидний сэтгэл санаа юм. Яагаад?

Сэтгэл санаа шинэчлэгдэх хэрэгэй. Учир нь:

- **ОЮУН БОДОЛ** худал хуурмаг итгэл үнэмшлээр дүүрсэн байдаг
- Худал хуурмаг итгэл үнэмшил нь сөрөг, шархалсан **СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙГ** бий болгодог
- Тиймээс бидний **ХҮСЭЛ ЗОРИГ** нь ихэнхидээ Бурханы хүсэл зоригоор бус Бурханаас салангид бие даан амьдрахыг илүүд үздэг.
- Өнгөрсөнд тохиолдсон хүчирхийлэл, гологдол, гэнэтийн цочрол зэрэг нь бидний сэтгэл санааг **ШАР-ХЛУУЛСАН** байдаг.
- Бидэнд чөлөөлөгдөх хэрэгтэй **ХҮЛЭЭС** (байнга ялагддаг гэм нүглийн зуршил) байдаг.

Дараахь диаграмаас аврагдах мөчид хүний сүнс болон сэтгэл санааны нөхцөл байдал хэр ялгаатай байдгийг харцгаая.



Ариусгалын үйл явцаар дамжуулан Бурхан юуг амладаг вэ?

Ариусгалаар дамжуулан Бурхан таны сэтгэл санаанд юуг гүйцэлдүүлэхийг хүсдэг вэ?

ОЮУН БОДОЛ - Таныг худал хуурмаг итгэл үнэмшлээс чинь чөлөөлөхийн тулд Өөрийнхөө үнэнээр оюун бодлыг тань шинэчлэхийг хүсдэг. Ром 12:2, Иохан 8:32

СЭТГЭЛ ХӨДЛӨЛ - Худал хуурмаг итгэл үнэмшлээс үүдэлтэй гэмтсэн, сөрөг сэтгэл хөдлөлийг тань эмчилж үнэнтэй нийцүүлэхийг хүсдэг. Дуулал 147:3


ХҮСЭЛ ЗОРИГ - Бурханаас хамааралгүй байх хүслийг тань Түүнээс хамаарч, Түүнд итгэж, Түүнд дуулгаварлаж, Түүнд бууж өгч, Түүнийг дагах хүслээр шинэчлэхийг хүсдэг. Марк 14:36, Филиппой 2:13

ШАРХ - Бурхан таныг өнгөрсөн болон одоогийн шархнаас эдгээхийг хүсдэг.

ХҮЛЭЭС - Бурхан таныг байнга ялагддаг гэм нүглийн зуршлаас чөлөөлөхийг хүсдэг.

Дараагийн диаграм ариусгалын үр дүнг илэрхийлж байна.

Таны сэтгэл санаа өөрчлөгдөн шинэчлэгдсэнээр



Асуулт: Оюун бодлыг тань ямар тодорхой үнэнээр Бурхан шинэчлээсэй хэмээн та хүсч байна вэ? Эдгэрэх хэрэгцээ бүхий өнгөрснөөс улбаатай гэмтсэн сэтгэл хөдлөл танд байгаа юу? Хэрэв байгаа бол тэдгээр нь юу вэ? Бурханд дуулгаварлаж, бууж өгөхийг хүсэхгүй байгаа амьдралын тань талбарууд юу вэ? Ялалтанд хүрэхийг хүсч байгаа ч дарамтлуулсаар байдаг гэм нүглийн зуршлууд тань юу вэ?


Бурхантай харилцах нь: Дээр дурдагдсан талбаруудад таны сэтгэл санааг шинэчилж өгөхийг Бурханаас гуйх итгэлийн алхам хийж эхлээрэй.

ХОЁР ДАХЬ ӨДӨР

“Шугам” ба ариусгал

Бурханы ариусгалын үйл явцыг илэрхийлэхийн тулд “шугам”-н аналогийг ашиглая. Бид итгэлийн алхам хийх үед Бурхан бидний сэтгэл санааг өөрчлөхүйц АМЬ ба ХҮЧИЙГ цутгадаг. Энэхүү үйл явцыг дүрсэлсэн доорх “шугам”-н илэрхийлэмжийг үзнэ үү.

Итгэл нь Бурханы амь ба хүчийг таны сэтгэл санаанд цутгадаг



ОЮУН БОДОЛ: Оюун бодлыг үнэнд итгэдэг болгож шинэчлэдэг

СЭТГЭЛ ХӨДЛӨЛ: Гэмтсэн сэтгэл хөдлөлийн эдгээдэг

ХҮСЭЛ ЗОРИГ: Хүсэл зоригийг хамааралтай, хүсэлтэй болгож шилжүүлдэг

ХҮЛЭЭС: Ялагдмал гэм нүглийн зуршлаас чөлөөлдөг

ШАРХ: Өнгөрсөн, одоогийн шархнаас эдгээдэг

Оюун бодлыг шинэчлэхтэй холбоотой үнэнийг илүү гүнзгийрүүлэн үзэцгээе.

Оюун Бодлын Шинэчлэл

“Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн. Харин зурх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж Бурханы хүсэл юу болохыг, тухайлбал сайн, тааламжит, төгс төгөлдөр хүслийг батлагтун.” Ром 12:2

Мөн чанараа таньж мэдэх судлалаас сурснаар бол өөрчлөлт оюун бодолд эхэлдэг. Бурхан бидний оюун бодлыг үнэнээр шинэчлэхийг хүсдэг бөгөөд ингэснээр бид цаашид худал хуурмаг итгэл үнэмшлээрээ амьдрах шаардлагагүй болохыг харсан. Бид илүү гүнзгий судлахын өмнө таны тархи болон оюун бодлын ялгааг эхлээд харцгаая.

Таны тархи болон оюун бодол

Таны тархи – “Хатуу диск”

Таны тархи компьютерийн хатуу диск л гэсэн үг. Энэ нь өгөгдөл, үйл явдал, зураглал гэх мэт зүйлсийг хадгалдаг. Та хэзээ нэг цагт “уучлаад март” гэсэн хэлц үг сонссон л байх. Гэвч үнэндээ та уучилж болох ч тархинд тань үйл явдлын талаарх бүх мэдээлэл суулгагдаад үлдчихсэн тул хэзээ ч мартаггүй байж магад. Цаашдын хичээлдүүдээрээ энэ талаар дэлгэрэнгүй хэлэлцэх болно.

Таны оюун бодол – “Дүгнэгч”

Эсрэгээрээ оюун бодол таны тархинд байгаа үйл явдалд **үнэлэлт, дүгнэлт** өгч тэрхүү дүгнэлттэй холбоотой **итгэл үнэмшлийг** бүрэлдүүлдэг.

Жишээлбэл, хүчирхийлэлтэй холбоотой нэг удаагийн эсвэл олон давтамжтай үйл явдал боллоо гэхэд таны тархи бүгдийг нь бүртгэж авна. Гэвч, тэрхүү үйл явдлын талаар үнэлэлт дүгнэлт өгч, тэрхүү үйл явдлын талаарх итгэл үнэмшлийг бүрэлдүүлдэг нь таны оюун бодол юм. Өөрийн эцэгт олон удаа хүчиндүүлсэн нэгэн эмэгтэй байдаг. Тэр эмэгтэйн тархи тухайн үйл явдлыг яг одоо болж буй мэт сэргээн санаж чаддаг байсан юм. Эдгээр үйл явдлын талаарх үнэлэлт дүгнэлт нь эмэгтэй өөрийгөө “бохир, үнэ цэнэгүй” гэдэг худал хуурмаг итгэл үнэмшил рүү хөтөлсөн байсан юм.

ХУДАЛ ХУУРМАГ итгэл үнэмшил гэдэг нь Бурханы үнэнтэй НИЙЦЭХГҮЙ бүх төрлийн үнэмшлийг хэлдэг гэдгийг санаарай.

Худал хуурмаг итгэл үнэмшлийн зарим нэг төрлүүдээс харвал:

- Христитгэлийн амьдралын талаарх худал хуурмаг итгэл үнэмшил
- Бурханы талаарх худал хуурмаг итгэл үнэмшил
- Өөрийн мөн чанарын талаарх худал хуурмаг итгэл үнэмшил
- Гэрлэлтийн талаарх худал хуурмаг итгэл үнэмшил

Асуулт: Дээр дурдсан худал хуурмаг итгэл үнэмшлийн жишээг 22-р хуудаснаас харна уу. Худал хуурмаг итгэл үнэмшлийн төрлүүдээс танд хамааралтай ямар нэг зүйл байна уу? Хэрэв тийм бол доор бичнэ үү.

Худал хуурмаг итгэл үнэмшил хэрхэн бүрэлддэг вэ?



Бүх худал хуурмаг итгэл үнэмшил нэг удаагийн бодлоос л эхэлдэг. Хэрэв та тэрхүү бодолд автаж, үргэлжлүүлэн төстэй бодлуудыг тээсээр байвал тэр нь яваандаа дүгнэлт болж уг дүгнэлт нь дахин дахин сөхөгдсөөр худал хуурмаг итгэл үнэмшил болж тогтдог.

Худал хуурмаг итгэл үнэмшил бүрэлдэх нь тоосго өрөхтэй л адил зүйл. Нэг бодол дээр нөгөө бодлыг тоосго өрж буй мэт нэмж өрсөөр нэг л мэдэхэд худал хуурмаг итгэл үнэмшил болон бүрэлдсэн байдаг.

Надад гологдсон гэдэг бодол байлаа гэж төсөөлье л дөө:

Хэрэв “**Би гологдсон**” гэдэг бодлыг **ТУСГАЖ АВААД**

Тэрхүү тусгаж авсан “**Би гологдсон**” гэдэг бодлоо **ҮРГЭЛЖЛҮҮЛЭН** тээх юм бол

Энэ нь “**Би гологдсон**” гэдэг **ДҮГНЭЛТ** болж тогтоно.

Үүний үр дүнд “**Би гологдсон**” гэдэгт **ИТГЭХ** болно.

Нэгэнт итгэл үнэмшил бүрэлдсэн бол тухайн бодол орж ирэх бүрт өнөөх итгэл үнэмшил өдөөгддөг. Хэрэв тэдгээр худал хуурмаг итгэл үнэмшил урт удаан хугацаанд өдөөгдсөөр байх юм бол хүлээс болдог. Хүлээсийг энгийнээр тодорхойлбол:

ХҮЛЭЭС

Өдөөгдсөн худал хуурмаг итгэл үнэмшил оюун бодолд салиггүй бэхжих

Дараа дараагийн хичээлүүдэд хүлээсний талаар гүнзгийрүүлэн ярилцах болно. Санаж байх хэрэгтэй түлхүүр санаа бол бодлуудаа үргэлжлүүлэн тээсээр тэдгээр нь өдөөгдөж худал хуурмаг итгэл үнэмшил болон бүрэлдэхдээ худал хуурмаг итгэл үнэмшлээ цаашид тэтгэдэг.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

Та өөрийн итгэж байгаагаас илүү гарч амьдарч чадахгүй.

“Та өөрийн итгэж байгаагаас илүү гарч амьдарч чадахгүй.” гэж хэлдэг миний үгийг та олон удаа сонссон байх. Энэ зүйлийг санаж байх нь дараахь чухал учир шалтгаантай холбоотой:


Хэрэв итгэж байгаа зүйл тань худал хуурмаг зүйл бол та худал хуурмаг итгэл үнэмшилээс үүдсэн сонголтуудыг хийж амьдрах болно.

Худал хуурмаг итгэл үнэмшил дотроос хийгдсэн сонголтуудын үр дүн нь:

- Бурханаас тусгаар амьдралаа авч явахыг оролдох байдал
- Махан биеийн зан авир


Доорх диаграмд үүнийг дүрслэн үзүүлнэ. (Тархи болон оюун бодол нь ялгаатай гэж ярьсан боловч оюун бодлыг дүрслэхийн тулд тархины зургийг ашигласан болно)

Сонголтууд нь таны худал хуурмаг итгэл үнэмшилээс гарах үед



Сонголт ба махан биеийн зан авир


Бүх зүйл таны хяналтанд байдаг гэсэн худал хуурмаг итгэл үнэмшилтэй байлаа гэж бодъё. (Бид бүгдээрээ санаатай болон санамсаргүйгээр яг энэ зүйлтэй зөрчилддөг гэж бодож байна) Энэ худал хуурмаг итгэл үнэмшил дээр үндэслэн таны хүсэл зориг сонголтуудыг хийх бөгөөд энэ нь хянан захирах, өөрийнхөөрөө зүтгэх, уур бухимдал гэх мэт махан биеийн зан авирт хөтөлдөг. Яг энэ санааг доор диаграмаар харуулья.



Худал хуурмаг итгэл үнэмшилд өөр өөрийн хүч байдаг

Өөр нэг мэдэж байх хэрэгтэй гол санаа бол худал хуурмаг итгэл үнэмшил таны оюун бодол дотор өөр өөр төрлийн хэм хэмжээтэй орон зайг эзэлсэн байдаг. Энэ санаагаа доорх диаграмаар зураглаж харуулья. Диаграмд өөрсдийнхөө талаар үүсгэсэн худал хуурмаг итгэл үнэмшилүүдийн жишээг ашиглая. Энэ диаграмд гарч буй хүний хамгийн гүн гүнзгий суугдсан худал хуурмаг итгэл үнэмшил бол бүх зүйл миний хяналтанд байгаа гэдэг үзэл бөгөөд энэ нь 1-100 гэсэн онооны 90 оноог эзлэн оршдог. Би хангалттай биш гэдэг худал хуурмаг итгэл үнэмшил хамгийн сул суугдсан буюу 30 оноотой. Үүнийг ойлгох нь яагаад чухал болохыг тун удахгүй хэлэлцнэ. Маш сайн ойлгож байх хэрэгтэй зүйл бол худал хуурмаг итгэл үнэмшилүүд өөр хоорондоо ялгаатай орон зайг таны оюун бодолд эзлэн суусан байдаг.

ХУДАЛ ХУУРМАГ ИТГЭЛ ҮНЭМШИЛД ӨӨР ӨӨРИЙН ЯЛГААТАЙ ХҮЧ БАЙДАГ



Асуулт: Танд байдаг худал хуурмаг итгэл үнэмшлүүд өөр хоорондоо ялгаатай орон зайг эзлэн оршдог гэдгийг ойлгох нь яагаад чухал вэ?

Бурхантай харилцах нь: Таны дотор аль худал хуурмаг итгэл үнэмшил илүү гүн гүнзгийг суугдсан болохыг илчилж өгөхийг Бурханаас гуйгаарай.

Тэгвэл энэ махан биеийн зан авир хэрхэн өөрчлөгдөх боломжтой вэ?

**Таны оюун бодлыг үнэнээр шинэчлэгч Ариун Сүнсэнд найдах үед л ГАГЦХҮҮ
махан биеийн зан авир өөрчлөгдөх боломжтой.**

Бурхан яагаад таны оюун бодлыг шинэчлэх хэрэгтэй болдог вэ?

Яг энэ мөчид ямар ч худал хуурмаг итгэл үнэмшилтэй бай тэр нь махан биеийн зан авирыг бий болгодог бөгөөд энэ нь зөвхөн танд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй эргэн тойронд чинь ч нөлөөлдөг. Тиймээс Бурхан таны оюун бодлыг шинэчлэхийг хүсдэг бөгөөд ингэснээр:

1. Та худал хуурмаг итгэл үнэмшлийнхээ ХҮЛЭЭСЭНД үргэлжлүүлэн амьдрах шаардлагагүй болно.
2. Та махан биеийн зан авираараа ҮРГЭЛЖЛҮҮЛЭН АМЬДРАХ шаардлагагүй болно.
3. Тэр худал хуурмаг итгэл үнэмшлийг үнэнээр СОЛБЖ чадах бөгөөд таныг чөлөөлнө.

Бурхан таны оюун бодлыг шинэчлэх үйл явцыг харцгаая.

Бурхан таны оюун бодлыг шинэчлэх үйл явц?

Би оюун бодолдоо шинэчлэгдэх алхмыг танд заагаагүй гэдгийг санаарай. Харин оронд нь шинэчлэгдсэн оюун бодолд хөтлөх үнэнийг ярьж байгаа юм шүү. Үлдсэн хичээлээрээ хэлэлцэх дөрвөн үндсэн үнэнийг харцгаая.

- Бурханы үнэний ИЛЧЛЭЛИЙГ эрэн хайж, СУРАЛЦ
- Үнэнийг өөртөө САНУУЛЖ, тэр талаар БОДОЖ эхэл
- Таны оюун бодлыг үнэнээр ШИНЭЧЛЭХ Ариун Сүнстэй ХАРИЛЦАХ итгэлийн алхам хий
- Тэр таны оюун бодлыг шинэчлэх үйл явцыг эхлүүлсэн хэмээн итгэлээр Бурханд ТАЛАРХ, МАГТ

а. Бурханы үнэний ИЛЧЛЭЛИЙГ эрэн хайж, СУРАЛЦ

“Энэ нь бидний Аврагч Бурхан, Тэрээр бүх хүмүүсийг аврагдаасай, үнэний мэдлэг уруу ирээсэй гэж хүсдэг.” 1 Тимот 2:36, 4



Оюун бодлоо үнэнээр шинэчлүүлэхийн тулд эхлээд үнэнийг мэдэх хэрэгтэй. Гэхдээ энэхүү танин мэдэхүйн мэдлэг нь оюун бодлыг шинэчлэхэд хөтөлдөггүй гэдгийг санаарай. Харин таны сурч буй үнэнийг илчилж өгөх Ариун Сүнсийг эрэн хайх нь нэн чухал юм. Тэрхүү илчлэл л таны оюун бодлыг үнэн рүү хөтөлнө.

Энэ ойлголтыг бүх зүйл миний хяналтанд бий гэдэг худал хуурмаг итгэл үнэмшлийн жишээн дээр хэрэгжүүлж үзье. Үнэн юу гэвэл: Бүх зүйлийг хяналтандаа байлгадаг цорын ганц Нэгэн бол Христ Өөрөө юм.

Энэ үнэнийг Филиппой 3:20,21-с харж болно:

“Аврагч Эзэн Есүс Христ..., бүх юмсыг Өөртөө захируулж чадах хүчээрээ бидний дорд биеийг Өөрийнхөө цог жавхланта биетэй адил болгон өөрчилнө.”

Хэрэв Христ л бүх юмсыг захирдаг Нэгэн юм бол хяналтандаа бүхнийг байлгаж чадахгүй нэгэн нь хэн бэ? Хэдийгээр бичээсээс Христ л бүх юмсыг захирдаг Нэгэн гэдгийг олж мэдсэн ч энэ үнэнийг илчилж өгөхийг Ариун Сүнснээс гуйх нь нэн чухал юм.

Бурхантай харилцах нь: Өөрт байгаа худал хуурмаг итгэл үнэмшлээс нэгийг нь сонгож аваад энэ асуултыг өөртөө тавиарай. “Энэ худал хуурмаг итгэл үнэмшлийн талаарх библийн үнэн нь юу вэ?”

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

б. Үнэнийг өөртөө САНУУЛЖ, тэр талаар БОДОЖ эхэл

“Учир нь **Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөлгийг салтал нэвтрэн ордог бөгөөд зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм.**” Еврей 4:12

Өмнөх хичээлүүдэд “зорилготойгоор” гэдэг үгийг би олон удаа ашигласан. Оюун бодолдоо шинэчлэгдэх үйл явцын эхэнд худал хуурмаг итгэл үнэмшлийг чинь засах тодорхой ишлэлүүдийг **зорилготойгоор** бодож байх нь нэн чухал юм.

Жишээн дээр энэ үнэнийг хэрэгжүүлж үзвэл: “Эзэн, Таны Үг, “Эзэн Есүс Христ бүх юмсыг өөртөө захируулдаг”. Тиймээс энэ үнэнийг үргэлжлүүлэн сануулсаар байхыг Таниас гуйя.”

с. Таны оюун бодлыг үнэнээр ШИНЭЧЛЭХ Ариун Сүнстэй ХАРИЛЦАХ итгэлийн алхам хий

Таны оюун бодлыг үнэнээр шинэчлэх Ариун Сүнстэй харилцах итгэлийн алхам хийж эхэл. Бодит байдалд энэ нь нэг иймэрхүү харагдах болно:


“Эзэн, Та бол цорын ганц бүх юмсыг захирдаг Нэгэн гэдэг үнэнээр оюун бодлыг минь өөрчлөхийг таниас гуйж байна (гэдэгт тань итгэж байна). Бүх юм миний хяналтанд байдаг гэсэн худал хуурмаг итгэл үнэмшлийг маань Өөрийнхөө үнэнээр сольж өгөөч.”

Таны оюун бодлыг шинэчлэхийг Ариун Сүнснээс асууж эхлэх үед:

1. Бурхан таны худал хуурмаг итгэл үнэмшлийг ҮНЭНЭЭР ШИНЭЧИЛЖ эхлэх болно.

Та үнэний талаар бодож, оюун бодлоо шинэчлүүлэхээр Ариун Сүнсийг эрж хайж эхлэх үед Тэрээр таны худал хуурмаг итгэл үнэмшлийг үнэнээр сольж эхлэх үйл явцыг доор диаграмд дүрсэлжээ.


Ариун Сүнс худал хуурмаг итгэл үнэмшлийг үнэнээр сольж ЭХЭЛДЭГ



2. Ариун Сүнс таны оюун бодлыг үнэнээр шинэчилснээр худал хуурмаг итгэл үнэмшлүүд арай илүү БАГА орон зайг эзэлж эхэлдэг

Эзэн таны худал хуурмаг итгэл үнэмшлийг үнэнээр солих үйл явцыг эхлүүлснээр худал хуурмагийн эзлэх орон зай багасч, бодол, сонголтонд нөлөөлөх хүч саардаг. Худал хуурмагийн эзлэх орон зайны талаар харуулсан диаграмаа дахин ашиглая. Энэ диаграмд, бүх зүйлийг хянах оролдлого 90, өөртөө итгэлтэй байдал 75, үнэ цэнэгүй байдал 45, хангалтгүй байдал 30 байсан.

ХУДАЛ ХУУРМАГ ИТГЭЛ ҮНЭМШИЛД ӨӨР ӨӨРИЙН ЯЛГААТАЙ ХҮЧ БАЙДАГ



Таны оюун бодлыг шинэчилж, уур хилэн, өөртөө итгэлтэй байдал, үнэ цэнэ, хангалтгүй байдлын талаарх худал хуурмаг итгэл үнэмшлээс чөлөөлж өгөхийг итгэмжтэйгээр үргэлжлүүлэн Бурханаас гуйх үед эдгээр худал хуурмагийн “хүч” нь сулрах болно. Дараахь диаграмд хяналтдаа байлгах 90-ээс 70, өөртөө итгэлтэй байдал 75-аас 50 болж тус тус буурсан байгааг харж болно.

БУРХАН ТАНЫ ХУДАЛ ХУУРМАГ ИТГЭЛ ҮНЭМШЛИЙГ ҮНЭНЭЭР СОЛИХ ҮЕД ХУДАЛ ХУУРМАГИЙН ХҮЧ СУЛАРДАГ




Оюун бодлыг тань үнэнээр шинэчлэхийг Бурханаас тасралтгүй гуйсаар байвал таны худал хуурмаг итгэл үнэмшлийн НӨЛӨӨЛӨЛ багассаар байгааг мэдэрч эхлэх болно.

Мэдээж энэ нь Бурханы хийж байгаа зүйлийн ердөө л дүрслэл нь. Харамсалтай нь Бурхан бидэнд хөгжил дэвшлийг тоолж болохуйц хувиар харуулдаггүй. (Яг үнэндээ Бурхан биднийг ололт амжилтаа хэмжээсэй гэж хүсдэггүй. Тиймээс та өөрийгөө хэмжих хэмжүүрээ хойш нь тавьсан нь дээр байх) Доор санаж явах хэрэгтэй түлхүүр үнэнийг хэлжээ:

3. Таны оюун бодол шинэчлэгдсэнээр Ариун Сүнс махан биеийн зан авирыг тань ХРИСТТЭЙ АДИЛ зан чанараар ӨӨРЧИЛЖ эхлэх болно.

Таны худал хуурмаг итгэл үнэмшлийн нөлөөлөл болон хүч нь сулрахын зэрэгцээ махан биеийн зан авир тань Христтэй адил зан чанараар өөрчлөгдөж эхлэх болно. Доорх диаграмд, уур хилэнгийн оронд баяр хөөр, бардам зангийн оронд даруу байдал болж өөрчлөгдөж байгааг харуулсан байна.



Бид итгэлээр Бурхантай харилцах үед Тэр ер бусын арга замаар бидний дотор гүйцэтгэдэг зүйл учраас та дээрх зүйлээр урамшсан гэж найдаж байна.

Дасгал: Доор бичигдсэн жагсаалтыг хараад Христтэй адил зан чанаруудаас өөр дээрээ амсаж мэдрэхийг хүсч буй 2-3 зан чанарыг сонгоно уу.

- | | | |
|----------------|--------------------|------------------|
| Нөхцөлгүй хайр | Золиос гаргадаг | Нинжин сэтгэл |
| Аюулгүй байдал | Эрх чөлөө | Ялгах чадвар |
| Уучлал | Баяр хөөр | Баяр талархалтай |
| Энэрэл | Үнэ цэнэтэй байдал | Зөвт байдал |
| Хангалттай | Хүлээн зөвшөөрөл | Ялалт |
| | | Амар тайван |

Даруу зан
Тэвчээр

Айдасгүй
Мэргэн
Христэд итгэлтэй

Хувиа хичээдэггүй
Хүчирхэг
Сайн сайхан


Бурхантай харилцах нь: Таны махан биеийн зан авируудаас Христтэй адил зан чанараар өөрчлөгдсөн байхыг хамгийн их хүсч буй зан авираа Бурханд дуулгаж Түүнд залбираарай.

Оюун бодлыг тань үнэнээр шинэчлэхийг Бурханаас тасралтгүй гуйсаар байвал таны худал хуурмаг итгэл үнэмшлийн НӨЛӨӨЛӨЛ багассаар байгааг мэдэрч эхлэх болно.

4. Ариун Сүнс “СҮНСЛЭГ” шүүлтүүрийг бий болгож эхэлдэг.

Таны худал хуурмаг итгэл үнэмшил үнэнээр өөрчлөгдөөд зогсохгүй Ариун Сүнс “сүнслэг” шүүлтүүрийг хөгжүүлж өгдөг. Сүнслэг шүүлтүүр нь таны мэддэг библийн үнэн төдийхөн бус түүнд итгэх итгэл юм.

“СҮНСЛЭГ” ШҮҮЛТҮҮР БҮРЭЛДЭЖ ЭХЭЛДЭГ



Сүнслэг шүүлтүүр бүрэлдэх нь яагаад тийм чухал байдаг вэ?

ТАВ ДАХЬ ӨДӨР

5. “Сүнслэг” шүүлтүүр ХӨГЖИХ тусам худал хуурмаг бодолд ЦААШИД автахаа больж ШҮҮЛТҮҮРТ-ЭЙ хандаж эхлэх болно.

“Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн мөн. “Иохан 17:17



Та бүхнээс асуулт асууя. Та өөрийн бодол бүртээ автах шаардлагатай юу? “Автах” гэдгээр оюун бодолд орж ирсэн бодол бүрийг тусгаж авах гэдгийг илэрхийлж байгаа юм. Энэ асуултыг асуухаар ихэнхи хүмүүс бодлоо тусгаж авалгүй яахав дээ гэж боддог.

Яг үүнтэй холбоотой нэг дүрслэлийг бодоцгооё. Танай гэр урдаа хаалгатай гэж бодъё. Тэр хаалганы цоожны завсараар нүх байдаг бөгөөд хаалган дээр хэн ирснийг завсраар нь харж болдог гэж төсөөлөө. Хэрэв та гэмт хэрэг их гардаг дүүрэгт амьдардаг бол ха-

алганы цоож чинь найдвартай эсэхийг сайтар шалгаж хаалган дээр ирсэн хүнийг цоожны нүхээр харах гэж оролдох болно. Харин хаалгаа нугасаар нь салгаж аваад гараштаа тавьчихлаа гэж бодё л доо. Тэгвэл ямар ч аюулгүйн баталгаа байхгүй болж сайн, муу янз бүрийн хүн зоргоороо танай үүдээр нэвтрэх болно. Яг үүнтэй адил бидний олонхи нь оюун бодлынхоо хаалгыг аваад хаячихсан байдаг бөгөөд оюун бодолдоо орж ирсэн бодол болгоныг нэвтрүүлж байдаг.

Христитгэгч биш байхдаа та бодлын шүүлтүүргүй л байсан. Үүний үр дүн нь ямар ч сонголтгүйгээр бодол болгондоо автдаг байсан гэсэн үг.

Жишээ хэлье. Та ажлаасаа халагдсан тул янз бүрийн бодлууд толгойд чинь эргэлдэх болж. Жишээлбэл, “Тэд намайг яаж халж чадаж байна аа. Тэдэнд байсан хамгийн сайн ажилтан нь би шүү дээ. Би тэдэнд хариуг нь өгнө өө”. Хэрэв та Христитгэгч биш бол эдгээр бодлуудад үүд хаалгаа шууд нээж өгөөд автоматаар энэ бодолд автах болно. Сүнслэг шүүлтүүр байхгүй бол үүдээр чинь орж ирсэн бодол болгоныг л та урих болно.


Гэвч, оюун бодолдоо шинэчлэгдэх үйл явцын нэг хэсэг нь Ариун Сүнс таны дотор “сүнслэг” шүүлтүүрийг бий болгохоор Бурханы үнэнийг бүрэлдүүлж худал хуурмаг бодолдоо автахгүй болгох болно.

Үнэн юу гэвэл бид худал хуурмаг ЯМАРВАА бодлыг тээх шаардлага БАЙХГҮЙ.

Таны сүнслэг шүүлтүүр хөгжихийн хирээр таныг хэлбэржүүлэхэд нөлөөлсөн худал хуурмаг бодлуудад хаалт тавьж, цааш түлхэж худал хуурмаг итгэл үнэмшлийг чинь өөрчилнө. Жишээлбэл:

Та гологдсон хүн гэж өөрийгөө боддог худал хуурмаг итгэл үнэмшилтэй гэж төсөөлөө. Та үнэнд суралцаж Ариун Сүнтэй оюун бодлыг тань шинэчлэх тал дээр харилцаатай байснаар Тэр гологдмол мэдрэмжийг тань Христ дотор бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн гэсэн үнэнээр өөрчлөх болно. (Та өөрийн үнэн мөн чанарыг санаж байна уу?) Таны оюун бодол шинэчлэгдсэнээр сүнслэг шүүлтүүр бүрэлдэж гологдмол гэдэг бодлууд орж ирэх гэж оролдмогц шүүлтүүр ажиллаж хаалт тавих болно. Дараагийн хичээлээр энэ үйл явцыг дэлгэрүүлэн ярилцах болно.

ТА БОДЛОО ШҮҮЛТҮҮРДЭЖ ЭХЛЭХ БОЛНО



Бурхантай харилцах нь: Оюун бодлыг тань шинэчилж өгөхийг Бурханаас гуйхдаа автчихдаг байсан боловч одоо хаалт тавьж чадаж байгаа худал хуурмаг бодлуудаа олж харахад туслахыг гуйгаарай.

г. Тэр таны оюун бодлыг шинэчлэх үйл явцыг эхлүүлсэн хэмээн итгэлээр Бурханд ТАЛАРХ, МАГТ

“Би Бурханы нэрийг дуугаар магтаж, Түүнийг талархлаар өргөмжилнө.” Дуулал 69:30

“Би ЭЗЭНийг цаг үргэлж магтана. Түүнийг магтах нь миний аманд үргэлж байх болно.” Дуулал 34:1

Түүний дотор байж, Бурхан ажилладаг гэдэгт итгэж итгэлээр алхахын тулд Түүний хийж буй зүйлд талархах хэрэгтэй. Тэр таны дотор байж оюун бодлыг тань үнэнээр шинэчилж байгаагийн төлөө таларх. Таны итгэл үнэмшилд өөрчлөлт гарч байгааг хараахан мэдрэхгүй байгаа ч гэсэн итгэлээр **өөрчлөлт явагдаж байгаа** гэдэгт итгэн таларх. Дуулал 34 дээр Давид хэлсэн шиг “Түүнийг магтах нь таны уруулд үргэлж байг”

Итгэлийн алхам: “Эзэн минь, хэдийгээр би ямарч өөрчлөлт мэдрэхгүй байгаа боловч Та миний оюун бодлыг шинэчилж, эрх чөлөөтэй болгож байгаа гэдэгт итгэн талархаж байна”

Бурхантай харилцах нь: Өөрчлөн шинэчлэлтийн үйл явцын үед үр дүнг нь хараахан мэдрээгүй байлаа ч талархал, магтаалтай байх нь итгэлээр алхаж байгаагийн баталгаа гэдэг үнэнийг мэдэх нь чухал юм.

Оюун бодлын шинэчлэлийн үед санаж байх хэрэгтэй түлхүүр үнэнүүд:

1. **ЗӨВХӨН** Бурхан л таны оюун бодлыг үнэнээр шинэчилж чадна. Та өөрийн оюун бодлыг шинэчлэх чадамжгүй.
2. Шинэчлэлийн үйл явц Бурхан таны оюун бодлыг шинэчилж, өөрчилж чадна гэдэгт итгэх итгэлийн АЛХАМ хийснээр эхэлдэг.
3. Ихэнх тохиолдолд Бурхан таны худал хуурмаг итгэл үнэмшлийг үнэнээр сольж байгааг тухайн мөчид АМСАЖ, МЭДРЭХГҮЙ байх болно гэдгийг санаарай.
4. Гэвч, шинэчлэлтийн үйл явцын үед та худал хуурмаг итгэл үнэмшлийн чинь үр дүнд бий болсон махан биеийн зан авираараа амьдрахаа БАГА БАГААР больж байгааг олж харах болно.
5. Худал хуурмаг итгэл үнэмшлээрээ амьдрах хүсэл тань БУУРЧ, үнэнээр (Христэй адил хандлага) амьдрах хүсэл тань ӨСӨХ болно.
6. Бурханы өөрчлөлтийн үйл явц таны оюун бодолд ТУЛААНЫГ бий болгоно.

Бясалгал: Дээрх үнэнээр бясалгаарай.


Бурхантай харилцах нь: Итгэлээр алхах явцад эдгээр үнэнийг сануулж байхыг Ариун Сүнснээс асуугаарай.

Оюун бодлыг шинэчлэх тал дээр ойлгох хэрэгтэй хамгийн сүүлийн чухал ойлголт бол Бурханы шинэчлэлтийн үйл явц эсэргүүцэлтэй тулгарах болно. Энэхүү эсэргүүцэл нь оюун бодолд тулааныг өрнүүлдэг. Дараагийн хичээлээр тэрхүү тулааны талаар хэлэлцэх болно.

Бурханы оюун бодлыг шинэчлэх үйл явц ба “шугам”

Бүх зүйл миний хяналтанд байдаг гэсэн худал хуурмаг итгэл үнэмшил оюун бодлын шинэчлэлд орох үед болох үйл явцыг шугаман зураглалаас харцгаая. “Шугам”-н диаграмд бүх зүйл миний хяналтанд байдаг гэсэн худал хуурмаг итгэл үнэмшлээс Христ бүх юмсыг захирдаг гэлэг үнэнээр өөрчлөгдөж байгаа үйл явцыг харуулсан болно. Ариун Сүнс зөвхөн Тэр ганцаараа захирдаг гэдгийг илчлэх болно. Таны оюун бодлыг шинэчилж “би биш харин Бурхан захирдаг Нэгэн” гэдэгт оюун бодлыг тань үнэхээр итгүүлэх тэр цэгт авчрах болно.

ОЮУН БОДЛОО БУРХАНЫ ҮНЭНЭЭР ШИНЭЧЛҮҮЛЭХ



Шинэчлэгдсэн оюун бодлын баталгаа нь юу байх вэ?

Таны оюун бодлыг Бурхан шинэчилснээр:

- Та худал хуурмаг итгэл үнэмшлийнхээ оронд Бурханы ҮНЭНИЙГ бодох болно.
- Худал хуурмагын оронд үнэнийг бодох, ялгах чадвар тань ӨСӨХ болно.
- Үнэн дотор алхаж байхдаа худал хуурмаг итгэл үнэмшил чинь эргэн санагдах үед ХУРДАН ялгаж мэдэх болно.
- Бурхан таны оюун бодлыг шинэчилж байгааг АМСАЖ МЭДРЭХ бөгөөд цаашид итгэлээр үргэлжлүүлэн алхах хүсэл чинь нэмэгдэх болно.
- Худал хуурмаг итгэл үнэмшлийн оронд үнэн дээр суурилсан СОНГОЛТУУДЫГ хийх болно.
- Бурханы өөрчлөн шинэчлэлтийг амссанаар ХРИСТЭД ИТГЭХ ИТГЭЛ чинь өсөх болно.

Оюун бодлоо шинэчлэх нь үйл явц юм! Цаг хугацаа орох магадлалтай! Яагаад?

“Тэнгэрийн доорх бүх зүйлд тогтоогдсон цаг, бүх явдалд хугацаа буй.” Номлогчийн үгс 3:1

“Оюун бодлыг шинэчлэгч” үйл явцад Бурханы товлосон цаг хэзээ болохыг бид өөрсдөөсөө асуухдаа “эдгээр худал хуурмаг миний дотор аль хэр удаан оршин тогтносон бэ? Миний амьдралыг хэр удаан хүлээстэй байлгасан бэ?” гэж асуудаг. Харин бид Бурхан ямар ч худал хуурмаг болон хүлээсийг хормын дотор зайлуулж чадна гэдгийг мэддэг. Гэвч Тэр хормын дотор хийдэггүй шалтгаан нь таны итгэлийг “өсгөх”-ийн тулд юм.

Өөрчлөлт шинэчлэлтийн үйл явц бол Түүний үнэнээр таны оюун бодлыг шинэчилснээр Түүнд итгэх итгэлийг тань барьж байгуулахын тулд юм. Тиймээс Тэр таны дотор, таниар дамжуулан ажилласнаар Түүний шинэчлэлтийн цагийн хуваарийг хүлээх тэвчээрийг өсгөх болтугай. Түүний товлосон цаг үргэлж төгс байдаг. Харин Бурханы товлосон цагт тэвчээргүйтэж, бухимдах үеүүддээ та юуг хийх хэрэгтэй вэ? Хийх хэрэгтэй зүйлс бол Түүний тэвчээр, Түүний туйлбартай байдал, Түүний амар тайван юм.

***Үйл явцыг Бурхан хурдан өрнүүлэхийг та хүсэх боловч ХҮЛЭЭЛТИйн явцад
Тэр танд итгэлийг сургаж байгааг санаарай.***

Энэ ЭРХ ЧӨЛӨӨ биш гэж үү?

*Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг **чөлөөлнө** гэв.
Иохан 8:32*

Энэ хичээлээр хэлэлцсэн бүх зүйлсийг Бурхан гүйцэтгэж байгаа юм бол энэ эрх чөлөө биш гэж үү. Энэ бүх-
энтэй таныг санал нийлнэ гэж би итгэж байна. Тэрхүү эрх чөлөө нь нэг иймэрхүү харагдана:

- Худал хуурмаг итгэл үнэмшлийн оронд үнэнд итгэж түүгээр амьдарна.
- Худал хуурмаг бодлыг хаах сүнслэг шүүлтүүрийг хөгжүүлнэ.
- Махан биеийн зан авирууд Христтэй адил зан чанараар солигдоно.

Тиймээс таны оюун бодлыг шинэчилж амьдралыг тань өөрчлөн, эрх чөлөөтэй болгох Бурхантай илүү зорил-
готой харилцах болно гэдэгт найдаж байна.

ХУДАЛ ХУУРМАГ ИТГЭЛ ҮНЭМШИЛ

Өөрийн мөн чанарын талаарх худал хуурмаг итгэл үнэмшил:

Би өөрийнхөө талаар ингэж мэдэрч итгэдэг:

Үнэ цэнэгүй	Өөрөөрөө аюулгүй	Хүлээн зөвшөөрөгддөггүй
Өөртөө итгэлтэй	Гологдмол	Өөртөө ханасан
Бүтэлгүй	Амжилттай	Бухимдалтай
Өөртөө найдсан	Хангалтгүй	Хянагч
Сул дорой	Өөрийгөө үнэлсэн	Ялагдмал
Чадамгай	Хамгаалалтгүй	Айдасгүй
Айдастай	Өөрөөрөө хүчирхэг	

Бурханы талаарх худал хуурмаг итгэл үнэмшил

Бурхан ийм гэж би итгэдэг:

Эсвэл, өнгөрсөнд маш дарамттай нөхцөл байдалд Бурханы талаар би ингэж боддог байсан:

Ууртай	Шүүмжлэмтгий	Хайрладаггүй
Хүйтэн хөндий	Буруутгагч	Чадамжгүй
Анзааргагүй	Шийтгэгч	Хүсэл зориггүй
Ерөнхийдөө захирдаггүй	Халамжгүй	Энэрэлгүй
Зөвхөн нөхцөлтэй хайрладаг	Гүйцэтгэл хүлээдэг	Гүйцэтгэлийн машин

Гэрлэлтийн талаархи худал хуурмаг итгэл үнэмшил

Хань маань миний бүх хэрэгцээнд хүрэх үүрэгтэй.

Миний хань намайг нөхцөлгүй хайрлах ёстой.

Миний хань хүлээлтэнд минь хүрэх ёстой.

Ханийнхаа махан биеийг захирах эрх надад байдаг.

Христ итгэлт амьдралын талаарх худал хуурмаг итгэл үнэмшил

1. Дараахь зүйлсийг олж авахын тулд Бурханд ямар нэг юм хийж өгөх ёстой :
 - a) Түүний хайрыг олж авах
 - b) Бурханыг баярлуулах
 - c) Түүний хүлээн зөвшөөрлийг олж авах
 - d) Түүний буруутгалаас зугтаах
 - e) Өөрийнхөө талаархи сайхан мэдрэмжийг авах
 - f) Бусдад таалагдах
2. Бурханы тусламжтай өөрийн ухамсар болон чадамжийг ашиглан дараахь зүйлийг хийх нь надаас шалтгаална :
 - a) Түүний тушаалыг сахих
 - b) Түүний амлалтыг амьдралдаа хүлээж авах
 - c) Өөрийгөө өөрчлөх
 - d) Аз жаргалтай болох
 - e) Амжилттай болох

Хоёрдугаар Хичээл

Оюун бодол дахь тулаан

Гэвч эрхтнүүдэд минь өөр хүч байдаг бөгөөд тэр нь миний оюун бодолтой дайтаж, тэр хүч миний дотор нүглийн хоригдол болгодог юм байна гэдгийг би харж байна. Ром 7:23 (Өөрийнхөөрөө болгож бичсэн)

НЭГ ДЭХ ӨДӨР

Яагаад тулаан болдог вэ?

Та өөрийн оюун бодлыг үнэнээр шинэчлүүлэхээр Ариун Сүнстэй харилцаж эхлэх мөчид оюун бодлын тулаан болдог. Энэ үйл явц эхэлмэгц л махан биеийн бодол санаа Ариун Сүнсний ажлыг эсэргүүцэж эхэлдэг. Эсэргүүцэл эхэлмэгц тулаан эхэллээ гэсэн үг. Бидний дотор үргэлж өрнөж байдаг тулааны талаар Паул дүрслэн хэлэхдээ:

“Би өөрийн хүсдэг сайныг хийдэггүй, харин хүсдэггүй бузар муугаа хэрэгжүүлдэг.”
Ром 7:19

Паултай адил зүйл мэдрээгүй хүн гэж нэг ч байхгүй биз ээ. Одоо бид Христитгэгчид учир Ариун Сүнсээр оюун бодлоо шинэчлүүлэх хүсэлтэй болсон байгаа. Гэвч, Бурханаар оюун бодлоо шинэчлүүлэхийг хүссэн ч Бурханы үнэний эсрэг худал хуурмаг итгэл үнэмшлийг бодолд маань тавих тулаан өрнөдөг.

Энэ тулааны талаар мэдэж байх хэрэгтэй үнэн нь юу вэ?

1. Биднийг захирах гэж оролдох оюун бодлын тулаан ТАСРАЛТГҮЙ амьдралын туршид үргэлжлэх болно
2. Энэхүү тулаанд бидни нүдэнд ҮЗЭГДЭХГҮЙ дайсан ажиллаж байгаа.
3. Дайсан биднийг худал хуурмаг итгэл үнэмшил, махан биеийн зан авирын ХҮЛЭЭСЭНД байлгахыг эрмэлздэг.
4. Ариун Сүнснээс салангид оюун бодол дотор өрнөж байгаа энэ тулаанд бид өөрсдөө ЯЛАХ боломжгүй.
5. Энэ тулаанд ХЭН ялах нь өөрчлөгдсөн амьдралыг АМСАЖ МЭДРЭХ эсэхийг шийднэ.

Судлалын туршид бид эдгээр үнэнийг илүү гүнзгийрүүлэн илрүүлэх болно. Бид өөрсдөөсөө асуух хэрэгтэй дараагийн асуулт бол: “Энэ тулааны талаар бид хэр их мэдлэгтэй байна вэ?”

Хэрэв оюун бодол дахь тулааны талаар үнэний мэдлэггүй бол тулаанд ХЭЗЭЭ Ч ялахгүй.

Бурхантай харилцах нь: Эдгээр үнэний талаарх гүн гүнзгий илчлэл өгч, оюун бодлын тулаанд ороход соргог байлгахад бэлтгэхийг Бурханаас гуйгаарай.

Та тулаанд хэр соргог байна вэ?

“Гэвч миний эрхтнүүдэд өөр хууль байдаг бөгөөд тэр нь миний оюун ухааны хуультай дайтаж, ... гэж би харж байна” Ром 7:23

Паулын хэлсэн “би харж байна” гэдэг үг нь оюун бодол дотор өрнөж байдаг тулааны талаар соргогоор мэдэрч байсныг хэлж байна. Би харж байна гэдэг зүйл бол олонхи Христитгэгчдийн хараахан анзаардаггүй зүйл юм. Хэрэв бид тулааныг анзаарахгүй өнгөрвөл бидэнд олон төрлийн аюул учирна:

- Бид Сатан/чөтгөрийн хүч, гэм нүглийн ноёрхол, махан биеийн стратегид өртөмтгий байх болно.
- Ариун Сүнсэнд олзлуулах хэрэгтэй сөрөг бодлууддаа автсаар байх болно
- Худал хуурмаг бодлууддаа автсаар байх нь худал хуурмаг итгэл үнэмшлийг өдөөдөг

- Тэдгээр өдөөгдсөн худал хуурмаг итгэл үнэмшил нь махан биеийн хандлага зан авируудыг өрвөлүүлнэ.

Бурхантай харилцах нь: Оюун бодлыг тань эзэлж буй тулааны өргөн, өндөр, гүн гүнзгийг соргоогоор мэдрэх нүдийг өгөхийг Ариун Сүнснээс гуйгаарай.

Тэр тулаан нь чухам юу вэ?

“Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой.” Ром 8:6

Тулаан нь БУРХАНЫ ҮНЭНтэй нийцдэг бодол бүрийн эсрэг Бурханы үнэнтэй СӨРГӨЛДДӨГ бодол бүрийн хооронд өрнөдөг.

Оюун бодлын тулаан нь Бурханы юмыг бодохын эсрэг дайсны тарьсан буруутгагч, уруу татагч, хууран мэхлэгч, худал хуурмаг махан биеийн юмсыг бодох бодлуудын хооронд өрнөдөг. Цааш нь гүнзгийрүүлэн харцгаая.

Махан биеийн, худал хуурмаг, хууран мэхлэгч, уруу татагч, буруутгагч бодлууд

Махан биеийн бодлууд - Махан биеийн зан авир, сонголтуудад хөтлөгч бодлууд

Махан бие гэдэг нь “Бурханаас салангид аз жаргалтай байж, өөрийнхөө амьдралыг удирдаж асуудлуудаа шийдвэрлэн амьдарч чадна” гэж хэлдэг амьдралын хандлага эсвэл стратеги юм. Махан биеэс махан биеийн зан авир урсан гардаг. Махан биеийн зан авир нь махан биеийн бодлын үр дүн юм.

Худал хуурмаг бодлууд - Бурханы үнэний эсрэг бодлууд

Худал хуурмаг бодлууд нь үндсэндээ Христ итгэлийн талаархи, Бурханы талаархи, өөрийнхөө төлөөрхи худал хуурмаг итгэл үнэмшлээс хамааралтай байдаг.

Хууран мэхлэгч бодлууд - Бурханы үнэн дотор итгэлээр алхахаас сарниулдаг, биднийг хууран мэхлэх зорилготой миний бодол мэт илэрдэг бодлууд

Хууран мэхлэгч бодлууд нь үндсэндээ Сатан болон түүний бузар муугийн хүчнээс гаралтай байдаг. Тэдгээр бодлууд нь бидний оюун бодолд өөрийн бодол мэт орж ирдэг. Хууран мэхлэгч бодлууд нь айдас, санаа зоволт, бухимдал зэрэг сөрөг бодлын жимээр хөтөлдөг.

Уруу татагч бодлууд - Үнэнээр амьдрахаас зайлсхийлгэдэг уруу татагч бодлууд


Уруу татагч бодлууд нь бидний байнга ялагддаг гэм нүглийн зуршил болон худал хуурмаг итгэл үнэмшилтэй холбоотой байдаг. Бид эдгээр хоёр талбарт хамгийн эмзэг, өртөмтгий байдаг тул уруу татагч бодлууд тэнд байраа эзэлсэн байдаг.

Буруутгагч бодлууд - Өөрийгөө яллах, буруутгах, ичгүүрийг төрүүлэгч бодлууд

Эдгээр бодлууд нь мөн адил миний бодлууд мэт илэрдэг. Тэдгээр нь алдаа зөрчлийг минь буруутгаж, бүтэлгүйтэн гэм нүгэлд унах үед өөрийгөө яллахыг ятгадаг.

Дараахь диаграм дээр Бурханы үнэн болон тэрхүү үнэнтэй сөргөлддөг бодлуудын тулааныг илэрхийлж үзүүлээ.

ТУЛААНЫ ТАЛБАР



Энэхүү тулаанд оюун бодол дахь дайсан чинь хэн бэ?

“.....Намайг бүсэлсэн хөнөөлт дайснуудаас” Дуулал 17:9-б

Дайны хамгийн анхны дүрэм бол дайснаа таних юм. Христитгэгчдийн хувьд нэгээс илүү дайсан байдаг билээ. Дуулал 17:9 дээр Давид хэдийгээр хүнийг дайсан хэмээн илэрхийлсэн боловч Христитгэгч бид итгэлийн амьдралыг минь хулгайлж, хөнөөж, устгахаар эрэлхийлэгч үл үзэгдэгч “ХӨНӨӨЛТ” дайснуудаар хүрээлэгдсэн байдаг. Бид тэдгээр таван дайснуудын талаар хэлэлцэх болно:

1. Махан бие
2. Гэм нүглийн ноёрхол
3. Сатан болон бузар муугийн хүч
4. Ертөнц
5. Өдөр тутмын аар саар бодлууд

ХОЁР ДАХЬ ӨДӨР

Одоо тус бүрд нь дэлгэрүүлэн харцгаая.

Дайсан #1 – Махан бие

“Махан биеийн бодол санаа бол үхэл юм” Ром 8:6

Махан биеийн талаарх дараахь түлхүүр үнэн бидний бодолд тод байгаа байх аа.

ТҮЛХҮҮР ҮНЭН

Махан бие “Би ямар ч асуудал, нөхцөл байдлыг ӨӨРИЙН УХАМСАР, ЧАДВАРААР даван туулж, шийдвэрлэж, зохицуулж чадна” гэсэн бодлыг БАЙНГА үйлдвэрлэдэг.

Хандлагын хувьд махан бие байнгын махан биеийн бодлуудыг боддог бөгөөд махан биеийн зан авирт хөтөлдөг. Гэвч, яг адилхан хөнөөлтэй зүйл нь махан бие Бурханаас хамааралтай байхын эсрэг өөрийн хязгаарлагдмал чадвар, ухамсраас эхтэй бодлоор амьдрахыг ятгадаг. Жишээлбэл, та хүнд бэрх шийдвэр гаргахаар зөрчилдөж байна гэж бодъё. Тэгвэл махан бие “Чи өөрөө энэ шийдвэрийг гаргаж чадна. Юу хийх талаараа бодож

олох хангалттай цаг гаргачих” гэдэг бодлыг бидэнд төрүүлдэг. Хэдийгээр ингэж бодох нь ердийн зүйл ч гэлээ Бурхан энэхүү шийдвэр гаргах үйл явцын аль хэсэгт нь үүрэг гүйцэтгэх вэ? Тэр таны хязгаарлагдмал бодлын оронд Өөрийнх нь мэргэн ухаан, ялгах чадварт найдахыг хүсэхгүй гэж үү?

Махан бие бидний төрөлх дасч, дадсан нөхцөл байдал тул хэрэгцээндээ хүрч, асуудлуудаа шийдвэрлэхэд өөрийн хязгаарлагдмал чадвар, нөөц бололцоогоо ашиглахаар махан биедээ автах зуршилтай байх нь аргагүй юм.

Бурхантай харилцах нь: Танд “үхлийг” тарьж буй махан биеийн бодлууд чинь юу болохыг илчилж өгөхийг Бурханаас асуугаарай.

Дайсан#2 - ГЭМ НҮГЛИЙН НОЁРХОЛ бидний бодлын амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ?

*“Хэрэв би өөрийн хүсдэггүй зүйлээ хийж байгаа бол цаашид би биш, харин миний дотор оршин байгч **нүгэл** (гэмийн эрх мэдэл) нь үүнийг үйлддэг.” Ром 7:20 (хаалтанд байгаа нь миний тайлбар)*

ГЭМ НҮГЛИЙН НОЁРХОЛ:

Бурханаас САЛГАЖ, гэм нүгэлд УРУУ ТАТАХЫГ эрмэлзэгч амьдралын БАЙНГЫН, ДОТООД ноёрхогч

Урьд нь үзсэнчлэн, гэм нүгэл ба махан биеийн ноёрхол нь бие даасан амьдралаар таныг амьдруулахаар хамтран ажилладаг. Гэм нүглийн ноёрхол нь биднийг худал хуурмаг итгэл үнэмшлийн хүлээсэнд байлгах махан биеийн болон гэм нүглийн бодлуудаар бөмбөгдөж байдаг. Жишээлбэл, хэн нэгэн надад шүүмжлэлтэй хандахад би ч эргүүлээд тэдэнд шүүмжлэлтэй хандах эрхтэй гэж итгэдэг махан биеийн зөвтгөл байдаг байлаа. Энэхүү махан биеийн шүүмжлэл болон зөвтгөл нь би хангалттай сайн биш гэсэн худал хуурмаг итгэл үнэмшлээс эх сурвалжтай байсан юм.

Тиймээс, бусад хүмүүс намайг голж, гоочлохын эсрэг юуг, яагаад хийсэн болохоо батлан харуулж өөрийгөө хамгаалахын тулд өөрөө шүүгч болдог хамгаалалтын зэвсэг юм. Намайг чиглэн ирсэн гоочлолын эсрэг гэм нүглийн ноёрхол маань махан биеэр илрэн ажиллаж “Хэлсэн үгээрээ намайг гомдоосон хүмүүст шүүмжлэлтэй хандах эрх надад байгаа. Би өөрөө шүүмжлэлтэй хандсанаар өөрийгөө зөвтгөж чадна” гэсэн махан биеийн бодол төрдөг байлаа. Эдгээр бодолдоо автах бүрт энэ нь худал хуурмаг итгэл үнэмшлийг маань дэврээдэг байв.

Тиймээс, таны бодлын орчинд гэм нүглийн хүч чадал болон махан бие хэрхэн өөр хоорондоо уялдан ажиллагийг сайтар анхааран ажиглаарай.

МАХАН БИЕ ба ГЭМ НҮГЛИЙН НОЁРХОЛ нь махан биеийн бодлыг өдөөж махан биеийн зан авирыг бий болгохоор ХАМТРАН ажилладаг.

Бурхантай харилцах нь: Таны худал хуурмаг итгэл үнэмшлийг өдөөж байгаа махан биеийн бодол төрүүлэгч гэм нүглийн ноёрхлыг илчилж өгөхийг Ариун Сүнснээс гуйгаарай.

Дайсан#3 - Сатан болон бузар муугийн хүч

“Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ.” Ефес 6:12

“...тэр (Сатан) худалч бөгөөд худал хуурмагийн эцэг нь юм.” Иохан 8:44 (хаалтанд байгаа нь миний тайлбар)

Бид Сатан болон түүний бузар муугийн хүчний эсрэг хүчтэй, байнгын тулаанд байдаг гэдгээ ухамсарлах хэрэгтэй. Сатан нэг цагт олон газарт зэрэг байж чадахгүй учраас хорон муугийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд бузар муугийн армидаа түшиглэдэг. Тэд үл үзэгдэгч учраас айхтар сүрхий өрсөлдөгч дайсан юм.

Нэмж хэлэхэд, бид итгэлээр алхаж эхэлбэл Бурхан бидний амьдралд юуг хийж, гүйцэлдүүлэх боломжтойг тэд маш сайн ойлгодог, мөн библийг дэндүү их мэддэг. Тиймээс л Сатан болон бузар муугийн зорилго нь биднийг итгэлээр алхаж, Бурхантай хувьчилсан, дотно харилцааг хөгжүүлж, өөрчлөлтийг мэдрэхээс зайлсхийлгэх явдал билээ. Сатан болон түүний бузар муугийн хүчний үүнчлэн үйлддэг үндсэн стратеги нь:

Бидний оюун бодолд махан биеийн, худал хуурмаг, яллагч, хууран мэхлэгч, уруу татагч бодлуудыг ТАРИХ явдал юм.


Харж байгаа биз. Сатан болон бузар муугийн хүчинд бидний амьдралын хавтаст хэрэг бүрнээрээ байж байдаг учраас ямар бодлыг тарихаа маш сайн мэддэг. Тэд бидний махан биеийн зуршил, хүлээс, шарх, сул талуудыг бүгдийг нь мэддэг. Тиймээс, тэд эдгээр бүх мэдээллээс гадна харилцаа болон нөхцөл байдлыг ашиглан оюун бодолд маань дээрх сөрөг бодлуудыг тарьж гэм нүгэл үйлдэхэд өдөөдөг.

Биднийг Христитгэл, Бурхан болон өөрийнхөө талаарх худал хуурмагт автуулж, итгүүлсээр байвал Бурханы амлалт болон элбэг хангалуун амьдрал, өөрчлөлтийг бид мэдрэхгүй гэдгийг Сатан мэддэг. Гуравдугаар хичээлээр оюун бодол дахь тулаанд сатан болон бузар муугийн хүчийг хэрхэн ялах талаар хэлэлцэх болно.

Сатан болон бузар муу сүнснүүдэд үндсэн нэг ЗОРИЛГО байдаг ба тэр нь таныг худал хуурмаг итгэл үнэмшлийн ХҮЛЭЭСЭНД байлгах явдал юм.

Дараахь диаграмд Сатаны/бузар муугийн сэтгэл санаанд үзүүлэх нөлөө, гэм нүглийн ноёрхол болон махан биеийг дүрслэн үзүүлжээ.

Сэтгэл санаа ба АРИУН БУС гурвал



Бурхантай харилцах нь: Сатан/бузар муу сүнснээс ирж байж болзошгүй аливаа бодлуудыг ил болгож өгөхийг Бурханаас асуугаарай

ДАЙСАН#4 - Оюун бодлын бас нэг дайсан бол ЕРТӨНЦ

“Хэн нэг нь та нарыг Христийн дагуу биш, харин хорвоогийн язгуур юмс, хүний уламжлалын дагуух гүн ухаан болон хоосон мэхлэлээр олзлох вий хэмээн сэрэмжлэгтүн.” Колоссай 2:8

“Учир нь хорвоод байгаа бүхэн тухайлбал, махбодын хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардамнал нь Эцэгээс бус, харин энэ хорвоогоос юм.” 1 Иохан 2:16

Зурагтаа асаагаад, сонингоо аваад, сэтгүүл уншаад үз. Төд удалгүй та энэ ертөнцийн бодлуудаар бөмбөгдүүлэх болно. Энэ нь энэ ертөнцийн бурхан болох Сатан хүчирхэг, өөрийгөө хангасан, бие даасан байлгахын тулд энэ ертөнцийн стандартын дагуу амжилттай, ялалттай байх хэрэгтэй гэсэн үзэл суртлаар тасралтгүй нөлөөлхөөр оролдож байгаа хэрэг юм. Сатан бидний соёлыг ашиглан илүү том, илүү сайн, илүү их зүйлийг хөөцөлдөхийг уруу татдаг. Энэ ертөнцийн өгөх цорын ганц мессеж бол энэ юм. Яагаад? Энэ ертөнцийн танд өгч чадах зүйл бол 1 Иохан 2:14 дээр хэлсэнчлэн махан биеийн хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал болон амьдралын БАРДАМ бахдал юм.

Нэмж хэлэхэд энэ ертөнцийн үйл явдлууд, улс төрчид гэх мэт зүйлс нь танд айдастай, уур хүргэм, бухимдал төрүүлэм бодлуудыг суулгаж байдаг. Би засгийн газрын юу хийж байгаа болон хийхгүй байгаа зүйлсийн талаар бухимдсан бухимдлаасаа ангижирч чаддаггүй Христитгэгчдыг мэднэ. Улс төрчид болон засгийн газрын үйл ажиллагаа тэдний Христ доторх амар тайвныг хулгайлж байдаг. Тэд “өмхийрсөн” бодол дотроо “хөлбөрч” байдаг. Бидний соёл, бодолд минь гүн гүнзгий нөлөөлж шунал, атаархал, уур хилэн, бухимдал зэрэг махан биеийн бодлыг өдөөдөг болохыг мэдэхдээ гайхшрух болно гэдэгт би итгэдэг.

Бурхантай харилцах нь: Энэ ертөнц таны бодолд сөргөөр нөлөөлж, ертөнцийн юмсад шунахад хүргэж байгааг хараахан анзаараагүй байгаа тэр талбарыг илчилж өгөхийг Бурханаас асуугаарай.

Энэ ертөнцийн бурхан болох Сатан таны бодолд СӨРГӨӨР нөлөөлөхийн тулд энэ ертөнцийн юмсыг ашиглах болно.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

ДАЙСАН#5 - Өдөр тутмын аар саар бодлууд

Өдөр тутмын аар саар бодлуудаас болоод Бурхантай хамт өдөр бүр тогтмол алхах алхаа маань сарниулагддаг.

Үр хүүхдээ асрах, ажил төрөл, аливаа үйл ажиллагаа зэрэг нь гэм нүгэл биш боловч биднийг Бурхантай хамт алхахаас сатааруулах боломжтой. Бидний хийх ёстой ажлыг ЭЗЭНТэй хамт алхах алхааг сатааруулах стратеги болгон Сатан ашиглах боломжтой.

“Завгүй байдал” нь Христээс хараагаа салгах болон оюун бодлын тулаандаа ялагдах бас нэгэн хэлбэр юм. Бид цаг мөч болгоноо ямар нэг хийх зүйлсээр дүүргэх хандлагатай байдаг. “Завгүй байдал” нь Бурхантай цаг өнгөрүүлэх Түүний талаар бодох зэргийг орлуулах тахал мэт тархжээ.

Бурхантай нөхөрлөхөд цаг зарцуулахаас илүү цаг мөч бүрийг завгүй өнгөрүүлж байгаа нь амьдралын БҮРЭН ДҮҮРЭН БАЙДАЛ гэж итгэж байгаатай холбоотой юм биш биз?

Сатан/бузар муугийн бас нэг заль бол таныг байнга сатааруулах явдал юм. Таныг Христ дотор суулгагдаж Түүнтэй цаг өнгөрүүлэх зорилгоос сатааруулснаар учруулж чадах хор хохирлыг тэр сайн мэддэг. Христ дээр суурилсан бодлоос сатааруулах бүх төрлийн арга хэлбэрийг тэр ашиглах болно.

Бурхантай харилцах нь: Бурхантай цаг өнгөрүүлж болох байдлаас холдуулж байгаа завгүй байдал ямар талбарт байгааг илрүүлж өгөхийг Ариун Сүнснээс асуугаарай. Бурхантай цаг өнгөрүүлж, Түүний тухай бодохоос зайлсхийлгэх ямар заль мэхийг Сатан ашиглаж байгааг илчилж өгөхийг Ариун Сүнснээс гуйгаарай.

***Сатан биднийг Бурханаас сатааруулахын тулд өдөр тутмын ГЭМ ХОРГҮЙ,
ААР СААРХАН бодлуудыг ашигладаг.***

Та энэ тулаанд өөрөө ялж ЧАДАХГҮЙ! (Христээс салангад)

Оюун бодлын талаархи судлалаа цааш үргэлжлүүлэхээс өмнө үндсэн суурь үнэнийг эхлээд ойлгох хэрэгтэй.

***Та ӨӨРИЙН хүч чадал, хүсэл зоригоо ашиглан оюун бодлын тулаанд ялж
ЧАДАХГҮЙ.***

Иохан 15:5-ийн бас нэгэн хэрэгжүүлэлт нь энэ байна. “... Надаас ангид та нар юу ч хийж чадахгүй...” Бидний дотор орших Түүний хүч байхгүйгээр Сатан/бузар муу, гэм нүгэл, махан биеийн ноёрхлыг хэзээ ч ялан дийлэхгүй гэдгийг Бурхан мэдэж байсан. Бурханаас салангад энэ тулаанд бид ялж чадахгүй зарим нэг шалтгаан нь юу вэ:

- Бид бодолдоо хууртагддаг
- Бид худал хуурмаг болон үнэн бодлын хоорондохыг ялгаж чаддаггүй
- Бид өөрсдөө чөлөөлөгдөж чадахааргүй худал хуурмаг итгэл үнэмшлийг өдөөж байдаг Бурханы үнэнтэй нийцдэггүй бодлуудад маш удаан автсан байдаг
- Бидний хүсэл зориг, ухамсар дангаараа Сатан/бузар муу, гэм нүгэл, махан биеийн оюун санаанд суулгадаг бодлуудыг дийлдэггүй

Асуулт: Та энэхүү тулаанд өөрийнхөө хүчээр ялахыг оролдож байв уу? Хэрэв тийм бол ингэх нь ямар үр дүнтэй байв.

Хэрэв энэ тулаанд та өөрийн хүч чадал, хүсэл зоригийг ашиглан тулалдахад уруу татагдаж байвал дараахь ишлэлийг бодоорой.

“...Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус, харин ялагдашгүйг ч ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд юм.” 2 Коринт 10:4

Тулааны ЯЛАГЧ таны дотор амьдардаг

Миний дагалдуулдаг маш олон итгэгчид өөрсдийн хүч чадал ба хүсэл зоригоор оюун бодол дахь тулаандаа ялж чадна гэдэгт итгэдэг байсан юм. Гэвч оюун бодлын тулаанд ялна гэдэг нь Христитгэлт амьдралаар амьдрахтай адилхан. Энэ тулаанд ялж чадах цорын ганц НЭГЭН байдаг ба тэр нь Ариун Сүнс юм. Ром 8:13-г харцгаая:

“Учир нь хэрэв та нар махбодын дагуу амьдарвал үхэх ёстой. Харин та нар Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно.”

Иохан 15:5 дээр Есүс хэлэхдээ “Надаас салангид та нар юу ч хийж чадахгүй” гэж хэлсэн бас нэг утга нь Ариун Сүнсний хүч чадлаас салангид оюун бодлын тулаанд та нар ялж чадахгүй гэсэн үг юм. Бурхан Өөрийн төгс дүүрнийг бидний дотор тавьсан өөр нэг шалтгаан нь энэ юм.

“Учир нь Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог. Бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн Түүн дотор та нар төгс болгогдсон.” Колоссай 2:9-10

Түлхүүр үнэн:

Таны дотор буй АРИУН СҮНС ЗӨВХӨН оюун бодлын тулаанд ялж чадна.

Оюун бодлын тулаанд ялахад Ариун Сүнсний зүгээс хийдэг зүйлсийн түлхүүр үнэнүүд энд байна.

Ариун Сүнс Ялагчийн хувиар:

1. Танд Бурханы үнэнийг заадаг. Иохан 14:26
2. Бурханы үнэнийг танд илчилж өгдөг. Иохан 16:13
3. Бурханы үнэнд итгэхэд таны оюун бодлыг шинэчилдэг. Ром 12:2
4. Худлын эсрэг үнэн бодлыг ялгахад тусалдаг. 1 Коринт 2:12
5. Тулаан дунд Бурханы үнэнийг сануулдаг. Иохан 14:26
6. Тулаанд дайснуудын чинь дээгүүр ноёрхдог. 2 Коринт 10:4

Бодлоо олзлуулах - та үүнийг хийж чадах үү?

Энэ тулаанд тулалдахад Ариун Сүнсийг хэрхэн оролцуулах талаар ярилцахаас өмнө бас нэгэн түлхүүр үнэнийг судалцгаая. 2 Коринт 10:4-5 харцгаая:

“...Бид (бидний дотор буй Христ) цэцэрхлийг нурааж, Бурханы мэдлэгийн эсрэг босогч алив бардамналыг устгаж, бодол бүрийг Христийн дуулгаварт олзолдог.” 2 Коринт 10:4-5 (Хаалтан дотор байгаа нь миний тайлбар)

Би энэ ишлэл дотор хаалтанд үг бичсэнийг харж байгаа байх. Паул дайснаа устгах болон бодлоо олзлуулах нь таны хариуцлага гэж хэлээгүй байгааг ойлгох нь чухал юм.

Үнэн бол таны бодлыг олзлон авдаг Ариун Сүнснээс САЛАНГАД та өөрийн бодлыг олзлон авч ЧАДАХГҮЙ

Энэ ишлэлд Паулын хэлсэн санаа нь таны бодол Бурхан, махан бие, Сатаны алинаас эхтэй болохыг Ариун Сүнс л ялгаж чадна гэсэн утгатай юм. Ариун Сүнс бидний бодлыг ялгаж салгахаас гадна Түүнтэй хамтарвал бидний оюун бодолд “тэнгэрлэг шүүлтүүр”-ийг суулгахыг хүсдэг.

Оюун бодлын тулаанд ялахад Ариун Сүнстэй харилцах тухай үнэн

“Тиймээс та нар оюун санаагаа үйлдэлд бэлтгэж, эрүүл ухаантай байж, Есүс Христийн илчлэлт дээр та нарт өгөгдөх нигүүлсэлд найдвараа бүрэн тавь.” 1 Петр 1:13

1. Юу бодож байгаа талаараа БОД

“Учир нь тэр дотроо боддогтойгоо адил юм” Сургаалт үгс 23:7

Нэн тэргүүнд бидний хийх хэрэгтэй зүйл бол оюун бодолд маань ямар бодол эргэлдэж байгаад соргог байх явдал юм. Учир нь бид Бурханы хүсээгүй бодолд автах зуршлыг хөгжүүлчихсэн байдаг.

Тиймээс дараахь зүйлст анхаарч эхэл:

Тогтмол бодогддог бодлууд: Бидэнд тогтмол бодогддог бодлууд нь ихэнхдээ худал хуурмаг итгэл үнэмшилтэй нягт уялдаатай байх магадлалтай байдаг.

Махан биеийн бодлууд: Хоёрдугаар хичээл дээр жагсаан бичсэнээс тэмдэглэсэн махан биеийн бодлын хэв шинжүүдээ эргэн нэг хараарай. Махан биеийн зан авирыг бий болгодог зарим нэг махан биеийн бодлуудаа тодорхойлоорой.

Хийсвэр бодлууд: Хэрэв та хийсвэрлэн боддог төрлийн хүн бол тэр бодлууддаа анхаарч эхлээрэй.

Хорон муу бодлууд: Дахин дахин давтагддаг хорон муу бодлууддаа анхаарал хандуулаарай. Учир нь тэдгээр бодлууд бараг дандаа Сатан болон бузар муугаас эхтэй байдаг.

Таны бодлын хэв шинжийг хүлцдэг Бурханы ялгах чадварын гэрэлд тэдгээрийг итгэлээр авчрах нь чухал юм. Энэ итгэлийн алхам дараахтай адил харагдана:

“Эзэн минь, бодож байгаа зүйлдээ нэн анхааралтай байх соргог байдлыг надад зөвшөөрөөч. Гэмтэй бодлыг маань илрүүлж өгнө үү.”

Бурхантай харилцах нь: Юу бодож байгааг тань соргогоор сануулахыг Ариун Сүнснээс гуйгаарай.

2. Бодлын тань ЭХ СУРВАЛЖЫГ илчилж өгөхийг Бурханаас асуу

“Та нар итгэл дотор байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө батал. Эсвэл Есүс Христ та нарын дотор байгааг та нар өөрсдөө мэддэггүй юм уу? Та нар үнэхээр шалгалтандаа унадаггүй л юм бол....” 2 Коринт 13:5

2 Коринт 13:5-аас бидний ойлгох хэрэгтэй гол зүйл бол Паулын хэлснээр Ариун Сүнсний ялгах чадварын гэрэлд бодлоо шалгуулахаар авчирч, Түүгээр бодлын эх сурвалжаа илчлүүлэх тухай юм. Оюун бодолд орж ирдэг зарим бодлуудыг шалгаж, Бурханаар эх сурвалжийг нь илчлүүлэх шаардлагатай байдаг. Дараагийн диаграмд бодлыг тань ялгах чадвартай Бурхантай харилцах талаар харуулжээ:



Бурхантай харилцах нь: Юу бодож байгааг тань сануулах Ариун Сүнсний соргог байдлыг гуйгаарай.

Гэм нүгэлтэй бодлууд: Гэм нүгэлтэй бодлууд Ариун Сүнсээр илчлэгдэх болно гэдгийг ойлгох нь нэн чухал. Асуудал нь Ариун Сүнс тэдгээрийг илчилж байгааг бид анзаардаггүйд байдаг. Тиймээс энэ тал дээрх итгэлийн алхам нь дараахь байдалтай харагдана:

“Эзэн минь, гэм нүгэлтэй бодолд мэдрэг, соргог байх байдлыг маань нэмэгдүүлж өгнө гэж би итгэж байна”

Бурхантай харилцах нь: Гэм нүгэлтэй бодол орж ирэх үед тэдгээрт мэдрэг байдлыг нэмэгдүүлж соргог байлгахыг Ариун Сүнснээс гуйгаарай.

**Та итгэлийн алхам хийснээр АРИУН СҮНСНИЙ илчилж байгаа
ГЭМ НҮГЭЛТЭЙ бодлууддаа илүү МЭДРЭГ болох болно.**

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

3. Таны бодлын талаарх үнэнийг ИЛЧИЛЖ өгөхийг Бурханаас асуу

“Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана.” Иохан 16:13a

Ариун Сүнсний итгэмжтэй хийдэг нэг үүрэг нь үнэнийг танд илчлэх тул бодож байгаа зүйлийн чинь талаарх үнэнийг илчилж өгөхийг Бурханаас асуугаарай.

Оун бодолд орж ирэх
бодлууд

Надад уурлах
эрх байгаа

Бодлын эх сурвалжыг
Бурханаас асуух

Эзэн минь,
энэ бодлын эх
сурвалжийг илчлээч

Бодлын эх сурвалжыг
Бурхан илчлэх

Надад махан
биеийн дагуу
уурлах
эрх байхгүй



Бурхантай харилцах нь: Бодлын тань талаархи үнэнийг илчилж өгөхийг Бурханаас асууж эхлээрэй.

3. Гэм нүгэлтэй, худал хуурмаг, хууран мэхлэгч, уруу татагч, махан биеийн, яллагч бодлыг тань Ариун Сүнс илчлэх үед тэдгээр махан биеийн бодлыг ЭСЭРГҮҮЦЭЖ Бурханд ДААТГАЖ өг.

а. Бодлууддаа автахаас татгалз

“Тиймээс биеийнхээ тачаангуй хүслүүдэд дуулгавартай байх ёстой хэмээдэг үхлийн биед чинь нүгэл бүү ноёрхог.” Ром 6:12

Бодлын талаархи үнэнийг Ариун Сүнс нэгэнт илчилсэн бол Бурханаас ирээгүй аливаа бодлуудад автахгүй байхаар эсэргүүцэх боломжтой. Христийн хүч дотор аливаа гэм нүгэлтэй, махан биеийн бодлуудад “ҮГҮЙ” гэж хэлэх Түүний хүч танд байгаа. Хэн нэгэн хэзээ нэгэн цагт “Хэрэв махан биеийн, худал хуурмаг бодол урд хаалгаар орж ирвэл арын хаалгаараа хөөгөөд гарга” гэж хэлж билээ.

Нэмж хэлэхэд, таныг бодлоо итгэлээр Бурханд олзлуулахыг Тэр хүсдэг. **Итгэн даатгах гэдэг нь Бурханд өөрийн бодлыг өгөх явдал юм.** Бурханд худал хуурмаг/махан биеийн бодлоо даатгаж өгөхгүй бол Сатан тухайн бодолд автах хүртэл чинь таныг уруу татаж, гэмд унагахад хөтлөх болно.

Асуудал нь байнга давтагддаг махан биеийн, худал хуурмаг бодолд АВТОМАТААР автчихаад байдагт байдаг бөгөөд үргэлжлүүлэн автах нь амархан байдаг.

Оун бодолд орж ирэх бодлууд

Надад уучлахгүй байх эрх байгаа

Бодлын эх сурвалжыг Ариун Сүнс илчлэх

Энэ бол гэмт бодол

Автахаас татгалзах

Би энэ бодолд автахгүй.



Бурхантай харилцах нь: Бурханаар үнэн эсэхийг нь шалгуулалгүйгээр автоматаар автчихаад байдаг махан биеийн, худал хуурмаг, яллагч бодлуудыг ичлилж өгөхийг Бурханаас гуйгаарай. Тэдгээр бодлуудыг Тэр илчилж өгөх үед тэдгээр бодлуудад “ҮГҮЙ” гэж хэлэх Түүний хүчийг урин дуудаарай.

б. Тэдгээр бодол бүрийг Бурханд даатгаж өг

“Тэр та нарын төлөө санаа тавьдаг учраас бүх зовнилоо Түүнд үүрүүл.” 1 Петр 5:7

Тиймээс л бид махан биеийн, худал хуурмаг бодлуудтайгаа зууралдаж цаг алдах хэрэггүй. Бурханд нэн даруй тэдгээр бодлуудаа даатгаж өгөх нь чухал юм. Тиймээс л 1 Петр 5:7 дээр Петр “Түүнд бүх зовнилоо үүрүүл” гэж хэлсэн нь уруу татлага, худал хуурмаг, яллагч бодлуудаа Ариун Сүнсээр Түүнд олзлуул гэсэн утгатай юм.

Жишээлбэл, “Эзэн минь, надад байнга бодогддог айдастай бодол байгааг Та илчилж өгсөн билээ. Эдгээр бодлуудад “Үгүй” гэж хэлэх хүч минь та БОЛЖ өгөөч. Мөн эдгээр айдастай бодлуудад үргэлжлүүлэн автахгүй байхад туслаач”

Бурханд бодлоо өргөх

**Эзэн минь,
энэ бодлыг танд
өргөж байна**



Бурхангай харилцах нь: Таны бодлын талаарх үнэнийг Бурхан илчилж өгвөл тэдгээр махан биеийн болон худал хуурмаг бодлуудыг Бурханд даатгаж өгөхөд суралцаарай.

Худал хуурмаг, гэм нүгэлтэй бодолд автаад байвал яах вэ?

Хэрэв худал хуурмаг, гэм нүгэлтэй бодолд автаад байвал тэдгээрийг Ариун Сүнс заавал илчилж өгнө гэдэгт баттай итгээрэй. Асуудал нь энэ нь зүгээр л ганц төрлийн бодол биш харин бодлын гинжин хэлхээ байдаг. Шинэ жилийн урт гэрлэн чимэглэлтэй адилхан гэсэн үг. Нэг бодолд нь л автахад бусад нь дагаад л ороод ирдэг нь тэд хоорондоо холбоотой байдгийнх юм. Тиймээс, тухайн бодож байгаа бодол тань худал хуурмаг гэдгийг мэдмэгцээ л Эзэнд нь шууд өргөх нь чухал юм.

ТАВ ДАХЬ ӨДӨР

Бодлын талаар санаж байх хэрэгтэй бусад чухал үнэнүүд

1. Сүнслэг шүүлтүүр

Сүнслэг шүүлтүүр бол таны итгэдэг Бурханы үнэн гэдгийг санаж яв. Эхэндээ таны шүүлтүүр бодол бүрийг олзолж авахуйц мэдрэг байж чадахгүй тул тухайн бодлууддаа автах болно. Гэвч үнэний талаарх илчлэлийг тогтмол авч түүнд итгэснээр таны шүүлтүүр худал хуурмаг, яллагч, уруу татагч гэх мэт бодлуудад илүү мэдрэг болно. Ингээд өмнө нь автчихдаг байсан бодлууддаа дахин автахаа больж байгааг олж харна.

2. “Ариун зуршил”-ыг хөгжүүл

Ариун Сүнсийг бодлын орчиндоо оролцуулах нь сурах хэрэгтэй үйл явц билээ. Энэ нь машин барьж сурахтай л адил. Эхэндээ та тормоз, хурдасгуур, араа зэргээ холбохын тулд маш анхааралтай байх шаардлагатай болдог. Харин дадаад ирэхийн цагт автоматаар л хийдэг болно. Бодлын зуршил яг л үүнтэй адил.

Эхэндээ, та бодлынхоо талаарх үнэн болон эх сурвалжийн талаар илчилж өгөхийг Ариун Сүнсэнд даатгахын тулд зориудаар анхаарч, Ариун Сүнсэнд тэдгээр бодлуудаа олзлуулах хэрэгтэй болдог. Гэвч, “ариун зуршил”-ыг хөгжүүлснээр энэ нь автоматаар л аяндаа зуршил болдог.

3. Өөртэйгөө ярих

“Хайртууд минь, сүнс болгонд бүү итгэ. Харин тэднийг Бурханаас ирсэн эсэхийг мэдэхийн тулд сүнснүүдийг шалга. Учир нь олон хуурамч эш үзүүлэгчид дэлхийд гарсан байна” 1 Иохан 4:1

Бас нэг хөгжүүлэх хэрэгтэй “ариун зуршил” бол миний нэрлэж заншсанаар “өөртэйгөө ярих” юм. Энэ нь Бурханы үнэний талаар бодож, чангаар хэлж тунхаглах үйл явц юм. Би энэ зүйлийг оюун бодолд маань тулаан ид өрнөх үед онцгойлон хийдэг. (Тулаан үргэлж л явагдаж байдаг боловч зарим үед тулаан илүү эрчтэй, өрнүүн байх үе байдаг) Ингэх нь үнэнийг танд сануулах бөгөөд тухайн бодол чинь үнэн эсэхийг шалгах “сүнсийг шалгах” арга зам гэж хэлж болох юм.

4. Та өнгөрсөн эсвэл ирээдүйд амьдрахад уруу татагддаг бол яг одоо энэ цаг мөчид Христ дээр хараагаа ЧИГЛҮҮЛ

“Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлье..” Еврей 12:2

Ихэнх Христитгэгчид ирээдүйд болох зүйлийн талаар “хэрвээ” болон өнгөрсөнд болсон зүйлийн талаар “ингэсэн ч болоосой” гэх бодолтой байдаг. “Хэрэв би энэ тушаалд дэвшиж чадахгүй бол яана аа? Би өнгөрсөнд арай өөр шийдвэр гаргасан ч болоосой. Тэгсэн бол өнөөдөр бүх юм өөр байх байлаа”. Хэрэв та өөрийн бодлуудад сайтар нухацтай анхаарал хандуулбал бодлын чинь хэдэн хувь нь “ингэсэн ч болоосой”, эсвэл “хэрвээ” гэдэг дээр төвлөрч байгааг анзаараад гайхшрах болно. Өнгөрсөнд болсон эсвэл ирээдүйд болох зүйл дээр төвлөрөх нь махан биеийн бодлууд болох уур хилэн, бухимдал, харуусал, хамгаалалтгүй байдал зэрэг үр жимсийг гаргадаг. Энэ нь мөн яг одоо цагт Христ дотор байдаг таны амар тайван, амралт, баяр хөөрийг хулгайлдаг.

“Хэрвээ” гэдэг бодол

“Ингэсэн ч болоосой”
гэх бодол

Хэрвээ би ажлаасаа
халагдчихвал
яана аа.

Би тэр ажлыг л
авчихсан бол...



Үнэнийг хэлэхэд та өнгөрсөнийг эргүүлж, ирээдүйг авчирч чадахгүй. Яагаад? Учир нь Бурхан бол “Би байх болно” эсвэл “Би байсан” гэдэг Бурхан биш. Харин таны Бурхан бол “Би байдаг” Бурхан юм. Өөрөөр хэлбэл, Бурхан таныг өөрийн одоо цагийн амьдралын амар тайван болон амралтаа өнгөрсөн эсвэл ирээдүйн санаа зоволттой, бухимдалтай, яллангуй, буруутгагч бодлоор сүйтгэхийг чинь харахыг хүсдэггүй.

Бурхан таны оюун бодлыг шинэчилснээр, “ХЭРВЭЭ” эсвэл “ТЭГСЭН Ч БОЛООСОЙ” гэж амьдрах нь “ҮР ДҮНГҮЙ” (цаг үрсэн) зүйл болохыг ойлгох болно.

Бурхантай харилцах нь: Таны оюун бодолд нутагшсан байгаа “хэрвээ” эсвэл “тэгсэн ч болоосой” гэдэг бодлыг илчилж өгөхийг Бурханаас асуугаарай. Цаг тутам Түүн дээр хараагаа төвлөрүүлж, Түүнд бүх бодлоо даатга.

Жишээлбэл, “Эзэн минь, Тань дээр төвлөрөхөөс илүү өнгөрсөн эсвэл ирээдүйн хаана нь төвлөрч байгааг илчилж өгөөч. “Хэрвээ” эсвэл “тэгсэн ч болоосой” гэдэг дээр төвлөрөх хүсэлгүй байдалд намайг шилжүүлж өгөөч”

4. Бодол тань ЯЛЛАГЧ бодол эсэхийг шалгах лакмус шалгалт

“Тиймд эдүгээ *Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй.*” Ром 8:1

“Хуулиас гардаг өөрийнхөө зөвт байдалтай биш, харин *Христэд итгэх итгэлээр ирдэг, итгэлийн үндсэн дээр Бурханаас ирдэг зөвт байдалтай* Түүний дотор би олдохын тулд юм.” Филиппой 3:9

Би олон Христитгэгчид өөрийгөө ялладаг болохыг мэддэг. Эдгээр өөрийгөө ялагч бодлууд нь гэм нүгэлд орооцолдох, махан биеийн дагуу байгаагаа олж харах, Христитгэгч хүний хувьд Бурхан биднээс хүлээдэг хүлээлтэнд хүрэхгүй байна гэж бодох үед голдуу илэрдэг. Яг үнэндээ бодитоор гэм нүгэлд унаж, махан биеийн дагуу бодсоноос болоод өөрийгөө ялладаг гэхээс илүү зүгээр байх үедээ л Христитгэгчид өөрсдийгөө яллахад илүү цаг зарцуулдаг болохыг харсан.

Чухал үнэн бол бидний ЯЛЫН БУРУУТГАЛ загалмай дээр БҮРЭН ТӨГС шийдэгдсэн. Танд цаашид ял БАЙХГҮЙ.

Христитгэгчдэд хамгийн чухал ишлэлүүдийн нэг бол Ром 8:1 юм. Нэгэнт та Христ дотор байгаа тул цаашид Христитгэгчийн хувиар танд ял байхгүй. Филиппой 3:9-д хэлэгдсэн үнэн бол та ЗӨВТ НЭГЭН. Энэ нь та өөрийгөө хормын төдийд ч яллах шаардлагагүй гэсэн утгатай. Бурхан цаашид таныг огтхон ч яллахгүй байхад яагаад та өөрийгөө яллах хэрэгтэй гэж? Хэрэв та өөрийгөө ялласан бодол тээж байгаа эсэхээ сайн мэдэхгүй байвал бодсон бодлынхоо урд “Христ дотор” гэж нэмж оруулаад үзээрэй.

Жишээлбэл, танд “би бүтэлгүй” эсвэл “би үнэ цэнэгүй” гэсэн бодол орж ирдэг байж болох юм. Энэ бодол үнэхээр үнэн юм шиг санагдаж болно. Гэвч, “Христ дотор би бүтэлгүй” эсвэл “Христ дотор би үнэ цэнэгүй” гээд орлуулаад хэлээд үзвэл энэ нь худал хуурмаг болохыг тэр даруй л ойлгоно.



**Өөрийн бодлын өмнө “ХРИСТ ДОТОР” гэдэг үгийг нэмбэл тухайн бодол чинь
Бурханаас ирсэн эсэхийг шуудхан мэдэх болно.**

Бурхантай харилцах нь: Танд байгаа ямар нэгэн өөрийгөө ялагч бодол байгаа эсэхийг илчилж өгөхийг Бурханаас гуйгаарай. Тухайн бодол тань ялагч бодол мөн эсэхийг илрүүлэхийн тулд “Христ дотор” гэдэг үгийг ашиглаарай. Өөрийгөө яллах бодол толгойд чинь орж ирэх аваас “Цаашид Христ Есүс дотор буй хэнд ч ял байхгүй” гэдэг Ром 8:1-р ишлэлийг сануулж, тухайн ишлэлээр оюун бодлыг тань шинэчлэхийг гуйгаарай.

Энэ тулаанд ЭНХ ТАЙВНЫГ эрхэмлэн дайны эсрэг байр суурьтай байх боломжгүй гэдгийг сана

“Тимот оо, чи сайн тэмцлээр тэмцэгтүн...” 1 Тимот 1:18

Энэхүү тулаанаас зайлсхийж хажуу тийш суух, эсвэл дайнаас зугтаах нь хэнд ч боломжгүй. Хэдийгээр Христитгэгчдийн дунд үнэн сэтгэлээсээ энэ тулаан байхгүй гэж эсэргүүцэх хүн байж болох ч энэ тулаанд огт тулалдахгүй байж чадахгүй, угаасаа тулаан болж байгаа. Тиймээс ч Паул сайн тэмцлээр тэмц гэж Тимотыг урамшуулсан. Хэрэв та энэ тулаанд оролцохгүй бол тулаанд буугаад өгсөн л гэсэн үг. 1 Тесалоник 5:6 дээр хэлсэнчлэн энэхүү тулааныг Ариун Сүнсний сонор, сэргэг байдал дотор хийх хэрэгтэй.

“Тиймээс бид бусдын адил унталгүй, харин эсрэг бөгөөд эрүүд ухаантай байцгаая.” 1 Тесаллоник 5:6

Хэрэв та ТУЛАЛДАХГҮЙ бол аль хэдийн ЯЛАГДСАН гэсэн үг

Бурхангай харилцах нь: Та тулалдахгүй байгаа болон зүрхэлж орохгүй байгаа тулааны талбаруудыг илчилж өгөхийг Ариун Сүнснээс асуугаарай.

Дүгнэлт

Оюун бодлын тулаанд Ариун Сүнснэй харилцах нь юу болох талаар илүү дээр ойлголтыг энэхүү хичээлээр сурсан гэж найдаж байна. Дараагийн хичээлээр Сатан бидний бодлын амьдралд хэрхэн нөлөөлдөг болохыг үзэцгээх болно.

Гуравдугаар Хичээл

Бодлын орчин дахь сатаны нөлөө

Сүнслэг тулаан

“Энэ үеийн бурхан үл итгэгчдийн бодол санааг сохолсон учраас тэд Бурханы дүр болох Христийн алдрын сайн мэдээний гэрлийг үзэж чадахгүй болжээ.”

2 Коринт 4:4

НЭГ ДЭХ ӨДӨР

Оршил

Хоёрдугаар хичээлээр Сатаны болон бузар муугийн хүч нь бидний оюун бодлын дайсан болох талаар ярилцсан. Харин одоо Сатан оюун бодолд маань хэрхэн нөлөөлдөг талаар төвлөрч үзээд, Сатан болон бузар муугийн хүчний эсрэг сүнслэг тулаанд Бурхантай хэрхэн харилцахыг суралцах нь ашигтай гэж бодож байна. Тэд Бурханы эсрэг аль эрт тэрсэлсэн бөгөөд тэдний эцсийн хувь заяа нь там болохыг тэд мэддэг. Тиймээс тэдний үхэн хатан хийдэг зүйлийн зорилго нь хүн төрөлхтнийг авралаас хол байлгах явдал юм. Нэгэнт та аврагдсан бол тэдний зорилго нь Христтэй хамт алхах алхааг тань хулгайлж, алж устгах явдал юм. Тиймээс дайсны стратегийг бид судалж, Сатан болон бузар муугийн эсрэг Бурханы хүч дотор хэрхэн байхыг судлах хэрэгтэй.

Сатан болон бузар муугийн хүчийг шийдвэрлэх нь

Сатан зөвхөн өнгөрсөн түүхийг л танд заадаг. Тэр таны туулсан амьдралын талаар нарийн бүртгэл хийсэн байдаг. Тэр болон түүний бузар муугийн хүч таны сул тал, махан биеийн хэв шинж, худал хуурмаг итгэл үнэмшлийг мэддэг. Хамгийн эмзэг талбар чинь юу болохыг хамгийн сайн мэддэг. Тиймээс ч тэр гэм нүглийн хүч чадал, махан биеийн хэв шинжээр чинь урхидаж Бурхантай алхах алхааг чинь сарниулах оролдлого хийдэг. Сатан болон түүний бузар муугийн хүч нь итгэлийн алхааг тань зогсоохын тулд ял, худал хуурмаг, уруу татлага, хууран мэхлэлтийг ичих ч үгүй зэрлэгээр ашигладаг.

*“Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай. Та нарын өрсөлдөгч болох **диавол нь** хэн нэгнийг **залгихаар** хайж буй архирах арслан мэт гэсэн явдаг.” 1 Петр 5:8*

1 Петр 5:8 дээр гарч буй “залгих” гэдэг үг нь Грек эх хэлэндээ “устгах” гэсэн утгатай. Энэ тухай хэсэг зуур бодоод үзээрэй. Сатан болон бузар муугийн хүч нь Христитгэгч болон Христитгэгч бус хүмүүсийг устгахаар санаатайгаар эрэн сурвалжилдаг. Христитгэгч биш хүмүүсийг устгах Сатан болон бузар муугийн арга нь тэднийг аврагдахаас хол байлгаж, цаашлаад туйлдаа хүрэх юм бол амиа хорлолт руу түлхэхийг эрмэлздэг. Тэгвэл Христитгэгчдийг устгаж чадах Сатан болон бузар муугийн жишээ нь юу вэ?:

Сатан болон бузар муу нь Христитгэгчдийн эсрэг:

- Бурхантай алхах итгэлийн алхааг нь сарниулах
- Худал хуурмаг итгэл үнэмшил дотор нь хүлэх
- Байнгын ялагдмал гэм нүглийн зуршилд нь байлгах
- Амьдралынхаа эх сурвалжийг өөрөөсөө авдаг болгож эргүүлэх
- Бурханаас тусгаар асуудлуудаа шийдвэрлэхэд ятгах
- Амиа хорлох байдал руу түлхэх

Тиймээс л Христитгэгчид Сатан, бузар муугийн хүч, чадамжийн талаар сонор сэргэг байх хэрэгтэй. Бид тэдний хүчнээс айх хэрэггүй, гэвч харин сүнслэг байдлын мэдлэгтэй, соргог байх хэрэгтэй.

Энэ судлалаа илүү гүнзгийрүүлэн судлахын өмнө биднийг Сатан/бузар муу нь эзэмдэх болон тэдний нөлөөний талаар онцлохыг хүсч байна.


ЧУХАЛ ҮНЭН:

**Христитгэгч хүнийг Сатан болон бузар муу нь ЭЗЭМДЭЖ ЧАДАХГҮЙ. Бурхан-
тай нэгдсэн учраас Сатан болон түүний бузар муу нь таны сэтгэл санаанд
НӨЛӨӨЛӨХИЙГ л оролдож чадна. Тэд таны дотор оршиж чадахгүй.**

2 Коринт 12:7 дээр Сатан бидний сэтгэл санааны эсрэг бузар мууг илгээж чаддаг гэдгийг харсан. Паулыг тарчлаахын тулд Сатан өөрийн элчээ илгээхэд ийм зүйл болжээ.

“Мөнөөх агуу гайхамшигт илчлэлтүүдээс болж, махан биед минь өргөс өгөгдсөн юм. Энэ нь намайг нударгаллах Сатаны элч ажээ.” 2 Коринт 12:7

**Сатан бидэнд нөлөөлж чадах боловч
сэтгэл санааг эзэмдэж, дотор нь байж чадахгүй**



Сатаны стратеги

“Хулгайч зөвхөн хулгайлан, алж, сүйтгэхээр ирдэг.” Иохан 10:10а

Сатаны стратеги нь гурван давхар бодлоготой байдаг гэдгийг санаж байх хэрэгтэй - хулгайлж, алж, сүйтгэх. Сатан Христ доторх бидний амар тайван, баяр хөөр, амралтыг хулгайлж, итгэлээр алхах мөчүүдийг минь алж, Бурханаас үргэлжлүүлэн хамааралтай байх хүсэл зоригийг маань сүйтгэхийг хүсдэг.

Энэхүү стратегиа Сатан хэрхэн хэрэгжүүлдэг зарим нэг арга замыг харцгаая.

Сатан/бузар муугийн стратегийн нэгдүгээр хэсэг - Бидний оюун бодолд өөрсдийн бодлыг ШУРГУУЛАХ

Бидний өнгөрсөн түүхийг Сатан болон түүний бузар муугийн хүч нь мэдэж байдаг гэдгийг санаж байх нь чухал. Тэр бидний давуу болон сул талыг мэддэг. Тэд бидний махан биеийн хэв шинж болон тэрхүү хэв шинжийн хүчийг бас нягт мэднэ. Тиймээс биднийг хэрхэн өөр дээрээ сайн төвлөрүүлэх стратегийг тэд гаргаж махан биеийн хэв шинжийг маань гэм нүгэл үйлдүүлэхэд ашигладаг. Тэдний стратеги нь бидний бодлын амьдралд төвлөрч байдаг. Тиймээс тэдний стратегийн нэг хэсэг нь бидний оюун бодолд **махан биеийн, худал хурмаг, яллагч, уруу татагч** бодлуудыг шургуулах явдал юм.

Бидний оюун бодолд аливаа бодлыг шургуулах Сатаны стратегийн төгс жишээг библийн Матай 16:21-23-р ишлэлээс уншина уу.

*“Тэр цагаас эхлэн Есүс Христ шавь нартаа Өөрийн Иерусалим уруу явах, ахлагчид, ахлах тахилч нар болон хуулийн багш нараас их зовлон амсах, алуулах, гурав дахь хоног дээрээ амилах ёстойгоо илэрхийлж эхлэв. **Петр Түүнийг татаж** -Эзэн минь, Таныг Бурхан өршөөг. **Ийм юм Танд хэзээ ч тохиолдохгүй** гэж зэмлэж эхэлсэнд, ” Матай 16:21-22*

*“Тэр эргэж **Петрт -Миний араас зайл, Сатан аа!** Чи Надад бүдрэх чулуу болж байна. Учир нь чи Бурханы юмыг бус, харин хүнийхийг л боддог гэлээ. ” Матай 16:23*


Есүс Өөрийн дагалдагчдад үхэл болон амилалтынхаа талаар хэлэхэд Петр хариулахад Есүс “Миний араас зайл Сатан аа” гэж хэлсэн байна. Петрийн амаар үг болж гарсан үгний ард байсан бодол хэнээс эхтэйг Есүс мэдэж байсан. Есүс тэр бодол Сатаны өгсөн бодол гэдгийг мэдэж байсныг Петрийг дурдаагүйгээр нь таньж болно. Сатан/бузар муугийн бодол нь миний бодол мэт ирдэг тул бидний бодож байгаа бодол надаас эхтэй юу эсвэл Сатанаас эхтэй юу гэдгийг ялгаж танихад хэцүү байдаг.

ХОЁР ДАХЬ ӨДӨР

Сатан болон өөрийн бодлын амьдралын талаар мэдэж байх хэрэгтэй чухал үнэн:

Сатан/бузар муу нь таны оюун бодолд бодлыг шургуулах үед тэд ТАНЫ БОДОЛ мэт орж ирэх бөгөөд миний дуу хоолойтой их адилхан байдаг.

Сатан таны оюун бодолд өөрийнхөө бодлыг шургуулах үед яав ч гуравдагч этгээд мэт байхгүй. Тэд үргэлж миний бодол мэт нэгдүгээр бие дээр орж ирдэг нь миний бодол гэж итгүүлэхийн тулд байдаг. Доор диаграмд Сатан/бузар муугийн оюун бодолд шургуулдаг өөр өөр төрлийн бодлуудыг харуулсан бөгөөд тэд эзэн бие шиг сонсогддог болохыг харуулжээ.



Дайсны өөр нэг явуулга бол “Би асуудалтай байгаагийн шалтгаан нь Бурхан. Эдгээр бүх зовлонгийн шалтгаан нь Бурхан” гэх мэт Бурханыг буруутгагч бодлыг танд шургуулах явдал юм. Хэрэв та эдгээр бодлуудад автсаар байх юм бол бодлын чинь эх үндэс Сатанаас үүдэлтэй гэдгийг анзааралгүй Бурханыг буруутгах болно.

Асуулт: Бурханыг ямар нэг зүйлд буруутгаж байгаа зүйл амьдралын тань талбарт байна уу? Хэрэв тийм бол үүний ард Сатан/бузар муу нь байгааг илчилж өгөхийг Бурханаас гуйгаарай.

Бурхантай харилцах нь: Сатан/бузар муугаас ирж байгаа аливаа худал хуурмаг, уруу татагч, яллагч, махан биеийн бодлууд байгаа эсэхийг илрүүлж өгөхийг Бурханаас гуйгаарай.

Сатан/бузар муу нь таны оюун бодолд махан биеийн, худал хуурмаг, яллагч, уруу татагч бодлуудыг шургуулах ЧАДВАРТАЙ.

Сатан/бузар муугийн стратегийн хоёрдугаар хэсэг - ХУУРАН МЭХЛЭЛТ

“Гэвч могой залиараа Еваг мэхэлсэн шигээ Христ уруу хандсан [цэвэр,] энгийн байдлаас та нарын санаа бодлуудыг төөрүүлчих вий гэхээс би айж байна.” 2 Коринт 11:3

“Сатан ч өөрийгөө гэрлийн тэнгэр элч болгон хувиргадаг учраас гайхах юм алга.” 2 Коринт 11:14

Сатаны зорилго нь таны оюун бодолд эзэн бие шиг бодлуудыг тарьснаар таны өөрийн бодол гэж итгүүлж тэрэнд автуулах санаатай байдаг. Энэ бол Сатаны агуу мэхлэл юм. Тиймээс л тэр хамгийн аюултай нь. Яагаад? Хэрэв та Сатан/бузар муугийн бодолд автчихвал таныг худал хуурмаг итгэл үнэмшлийн чинь хүлээсэнд байлгаж худал дүгнэлтэнд хүргэх болно.

Жишээлбэл, Сатан болон түүний бузар муу нь “**Би** яагаад гэмээ ялан дийлж чадахгүй байна аа? **Би** дахин дахин ялагдаад л байна. **Би** ямар нэг юм буруу хийгээд байх шиг байна” гэсэн та өөрөө юм шиг буруутгагч бодлыг тарьж болно. Хэрэв та энэ хорон бодолд автаж төвлөрвөл “Бурхан **миний** амьдралд ажиллахгүй байна.

Тэр **намайг** өөрчлөгдөхийг үнэхээр хүсэхгүй байх шиг байна. **Би** Бурханыг орхих юм шиг байна энэ байдлаараа” гэсэн хуурамч дүгнэлт гаргахад уруу татаж хууран мэхлэх болно. Хэрэв та эдгээр бодлуудад автаж, үүгээрээ үйлдээд байвал Бурхан таниар дамжуулан ажиллах арга замыг хааж махан биедээ захируулах байдал руу буцах болно.

ХУУРАН МЭХЛЭЛТ нь Сатан болон бузар муугийн үндсэн стратеги юм. Тэд ӨӨРСДИЙН бодлыг таны ӨӨРИЙН чинь оюун бодол мэтээр итгүүлж хууран мэхлэхийг ямагт оролддог.

Бурхантай харилцах нь: Сатан болон бузар муу нь махан биеийн, гэмт бодлуудыг байнга өгснөөр таныг хууран мэхлэхийг оролдож байгаа бол тэдгээрийг илчилж өгөхийг Бурханаас гуйгаарай.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

Сатан/бузар муугийн стратегийн гуравдугаар хэсэг - Бурханд ЭРГЭЛЗЭХИЙГ ятгадаг

“ЭЗЭН Бурханы бүтээсэн аливаа хээрийн зэрлэг амьтдын дотроос могой хамгийн илүү зальтай байжээ. Тэр могой -**Та нарт энэ цэцэрлэгт байгаа бүх модны жимснээс идэж болохгүй гэж Бурхан үнэхээр хэлсэн үү?** хэмээн эмэгтэйгээс асуужээ.” Эхлэл 3:1

“Тэгээд тэр модны жимс нь хүнс болоход шимтэй, нүд булаам, мэргэн ухаантай болгочихмоор, шунал хөдөлгөм сайхан харагдсан тул тэр эмэгтэй түүнээс авч иджээ. Тэр бас өөртэйгөө хамт байсан нөхөртөө өгч, тэр ч иджээ” Эхлэл 3:6

Эден цэцэрлэгт болсон үйл явдлаас харвал Сатан/бузар муугийн стратеги нь Бурхан, Түүний хайр, хүч, сайн сайхан, таныг өөрчлөх хүсэл гэх мэт зүйлст эргэлзэхийг ятгаснаар сэтгэл санааг тань хоосруулах зорилготой байдаг. Сатан таны дотор ямхын төдий эргэлзээг төрүүлж чадвал та махан бие рүүгээ эргэн өөрийн хүчинд найдахад уруу татагдаж чадна гэдгийг мэддэг.

Жишээлбэл, гэнэтийн аймшигт ослоор сайн найзыгаа алдсан гээд төсөөлөөд бодье л доо. Энэ үйл явдлыг Сатан хэрхэн ашиглаж таны оюун бодолд Бурханы талаарх эргэлзээг бий болгож, Түүнд итгэхээс холдуулах боломжтойг харуулсан дүрслэлийг харцгаая.

Сатан/бузар муу нь бодол тарина

Бурхан яагаад энэ бүхэн тохиолдохыг зөвшөөрөв?

Сатан/бузар муу нь үр дүнг тарина

Бурхан итгэмжтэй гэдэгт би итгэхгүй байна

Сатан/бузар муу нь автуулахыг оролдоно

Би цаашид Бурханд итгэхгүй



Нэгэнт та Бурханд эргэлзэж эхэлбэл өөрөөсөө эх сурвалжтай амьдрах руу эргэх болно гэдгийг Сатан/чөтгөрүүд мэддэг.

Бурхантай харилцах нь: Таны бодолд буй эргэлзээнүүд Сатан/чөтгөрөөс гаралтай эсэхийг илрүүлж өгөхийг Бурханаас гуйгаарай.

Сатан болон чөтгөрүүдийн тал дээр Бурхантай хэрхэн харилцах хэрэгтэй вэ?

1. Бурханы үгнээс Сатаны талаарх үнэнийг СУРАЛЦАХ нь сүнслэг шүүлтүүрийг хөгжүүлдэг

Өмнө нь ярьсанчлан Бурханы үгнээс суралцах нь “сүнслэг шүүлтүүр”-ийг хөгжүүлдэг. Үнэний талаар сурч, Ариун Сүнснээс үнэний талаарх илчлэлийг хүлээн авснаар бидний сүнслэг шүүлтүүр илүү ялгаж салгах чадвартай, итгэн даалгаж чаддаг болж Сатан/чөтгөрийн бодолд автахаа больдог. Сатаны талаар суралцах хэрэгтэй 4 үгнэн байна.

а. Сатан/чөтгөрийн стратеги, явуулгын талаар СОНОР СЭРЭМЖТЭЙ бай

*“Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай. Та нарын өрсөлдөгч болох **диавол нь** хэн нэгнийг **залгихаар хайж буй архирах** арслан мэт гэтэн явдаг.” 1 Петр 5:8*

*“Ингэсэн нь биднийг **Сатан мэхэлж далимдуулах вий гэсэндээ юм. Учир нь түүний хөнөөх санааг бид ямар мэдэхгүй биш.**” 2 Коринт 2:11*

Бид Сатаны хэд хэдэн стратегийн талаар аль хэдийн ярилцчихаад байна. Сатаны стратегийг таних түлхүүр бол **сүнслэг сонор сэрэмж юм**. Би сүнслэг сонор сэрэмж гэдгээр Сатаны явуулгыг илчлэх Ариун Сүнсэнд мэдрэг, сэргэг байх тухай хэлж байгаа юм. Сатаны гол зорилго нь эцэстээ амьдрах эх сурвалжаа өөрөөсөө эхтэй байлгахад төвлөрүүлэх явдал юм.

б. Бид, өөрсдийн хүч чадал дотор, Сатан болон чөтгөрүүдтэй тулалдах ХҮЧГҮЙ

*“Хүчний давамгайлал нь **биднээс биш, харин Бурханых байхын тулд бид энэхүү баялгийг шавар савнуудад тээдэг.**” 2 Коринт 4:7*

Бид үл үзэгдэгч дайсантай тулалдаж байгаа тул Сатан болон бузар муугийн хүчтэй тулалдах боломжгүй юм. Тиймээс Сатан болон чөтгөрүүдтэй бүү ярь. Тэр бол Бурханы ажил. Харин бидний хийх хэрэгтэй зүйл бол Бурхантай харилцаж тэдгээр дайснуудтай Түүний хүчээр тулалдах юм.

в. Бид Бурханы ХҮЧ дотор алхах үед Сатан болон чөтгөрүүд хүчгүй юм.

*“Дараа нь **ёс бус нэгэн илчлэгдэх бөгөөд Эзэн [Есүс] амныхаа амьсгалаар түүнийг алж, Өөрөө ирж үзэгдсэнээрээ төгсгөлийг нь авчирна.**” 2 Тесалоник 2:8*

*“Тийнхүү хүүхдүүд нь **цус ба махан биеийн тасархай болов. Түүнчлэн Тэр Өөрөө бас тасархай болсон. Ингэснээр Тэр үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ устгаж,**” Еврей 2:14*

*“Бяцхан хүүхдүүд ээ, **та нар Бурханых бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс аугаа**” 1 Иохан 4:4*

Бид итгэлээр алхсанаар Сатан/чөтгөрийн дээгүүрх Бурханы хүч дотор алхаж байгаа хэрэг. Тиймээс л итгэлээр алхах нь чухал гэдэг нь гол учир юм. Бурханы хүчээс зуурч, Түүн дотор амарч, найдах үед Сатан бол “шүдгүй” арслантай адил юм.

Бурхантай харилцах нь: Сатан болон чөтгөрийн үнэний талаарх илүү тод томруун илчлэл өгөхийг Бурханаас гуйгаарай.

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

г. Та одоо Бурхантай нэгдмэл тул танд Түүний БҮРЭН хамгаалалт байгаа (ЗЭВСЭГ)

“Та нар (Бурханы хүч дотор) диаволын заль мэхний эсрэг бат зогсох чадвартай байхын тулд **Бурханы бүрэн хуяг дуулгыг өмс.** ” Ефес 6:11 (Хаалтан доторх миний тайлбар)

Бид аврагдах тэр агшинд Бурхан Өөрийн зэвсгийг өмсөх боломжийг бидний өмнө нээж өгдөг. Зэвсэг бол Христ Өөрөө юм. Гэвч, тэрхүү зэвсгийг авах эсэх нь таны сонголт. Та Бурханаас хамааралтай алхсанаар Түүний зэвсгийг (Түүний бүрэн хамгаалалт) өмсч буй хэрэг юм. Харин Бурханаас салангид алхах сонголт хийх үедээ үр дүнд нь зэвсгээ тайлж тавиад махан биеэр амьдарч байгаа хэрэг юм. Бурханы зэвсэг нь махан бие, гэм нүглийн хүч, Сатан болон чөтгөрийг хамгаалах зориулалттай биш учраас тэр юм.

Тэгэхээр та өөрийн дотоод болон гадаад дайснаасаа хамгаалах эсэх нь ТАНЫ гарт байна. Гэвч та гараа ардаа хүлчихээд эдгээр дайснуудынхаа эсрэг ямар ч хамгаалалтгүй байж байгаа юм биш биз. Тиймээс үргэлжлүүлэн итгэлээр алхсанаар дайсны “галт сумнаас” хамгаалах Бурханы зэвсэгтэйгээ байх нь чухал юм.

“Энэ бүгд дээр муу нэгний бүх галт сумыг унтрааж чадах итгэлийн бамбай, ” Ефес 6:16

Бурхантай харилцах нь: Түүний бүрэн зэвсэгтэй алхах агуу хүслийг өгснөөр дайсны галт сумыг тэсвэрлэж чадахын төлөө Бурханаас гуйгаарай.

2. Таны бодож буй бодол Сатан/чөтгөрийнх эсэхийг ИЛЧИЛЖ өгөхийг Ариун Сүнснээс асуу

“Хайртууд минь, сүнс болгонд бүү итгэ. Харин тэднийг **Бурханаас ирсэн эсэхийг мэдэхийн тулд сүнснүүдийг шалга.** Учир нь олон хуурамч эш үзүүлэгчид дэлхийд гарсан байна. ” 1 Иохан 4:1

Таныг голсон найзаасаа хариугаа авах бодолтой байна гэж бодъё. Гэтэл тэр бодол Сатанаас иржээ гэж төсөөлөө. Энэ нь “Найз маань надад тэгж хэлсэн гэж итгэж чадамгүй нь. Үүнийг би зүгээр өнгөрөөж чадахгүй. Энэ хүнээс хариугаа авна.”

Энэ бодол дээрээ үйлдэл хийхээсээ өмнө энэ бодлын эх сурвалж нь юу болохыг Бурханаас асуу. Ариун Сүнс танд юу илчлэхийг анхааралтай сонс. Яг ингэх нь хэрхэн харагдахыг доор дүрсэлж үзүүлжээ.

Сатан/бузар муу нь махан биеийн бодол тарина



Бурханаас бодлын эх сурвалжийг илчлэхийг асууна



Ариун Сүнс бодлын эх сурвалжыг илчилнэ.



Бурхантай харилцах нь: Ариун Сүнснээс таны бодлын эх сурвалжийг илчилж өгөхийг асуудаг зуршлыг хөгжүүл. Сатан болон чөтгөрөөс эхтэй бодлуудыг илрүүлж өгөхийг Түүнээс асуу.

3. Сатан/чөтгөрийн бодлуудыг Бурханд ДААТГАЖ, тэдгээр бодлуудыг олзолж өгөхийг Ариун Сүнснээс гүй

Нэгэнт Ариун Сүнс бодлууд тань Сатан эсвэл чөтгөрөөс гаралтайг илчилж өгсөн бол тэдгээр бодлуудыг олзолж авахыг Түүнээс гүй. Бурханд бодлуудаа даатгаж өгнө гэдэг нь тэдгээр Сатан/чөтгөрийн бодлуудад автахгүй байх гэсэн утгатай. Энэ нь Бурханд олзлуулахаар өргөн барьж байгаа гэсэн үг.



ТАВ ДАХЬ ӨДӨР

4. Хэрэв бодол орж ирсээр л байвал тэдгээр бодлуудыг зайлуулах Бурханы ХҮЧЭЭС ЗУУР

“Тиймээс Бурханд захирагдагтун. Дяволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна.” Иаков 4:7

Ихэнхдээ Сатан бодлыг нэг л удаа шургуулдаггүй. Таныг тэр бодолд автаж гэмд унах хүртэл итгэлээр сульдтал чинь тухайн бодлыг дахин дахин өгсөөр байх хандлагатай байдаг. Тиймээс тэдгээр бодлуудыг зайлуулах Бурханы хүчээс үргэлжлүүлэн зуурсаар байх хэрэгтэй.

Иаков 4:7 дээр Бурханд өөрийн бодлыг захируулбал Бурхан таниар дамжуулан Сатан/чөтгөрийн бодлыг зайлуулна гэснийг харсан байх. Бурханаас салангид та Сатаныг эсэргүүцэж чадах нэгэн биш. Та өөрийн хүчээр үүнийг хийх хүчгүй.

Сатан ЭЦЭСТЭЭ бууж өгөхөд тодорхой хугацаа орох ч Сатан/чөтгөрийн бодлыг ЗАЙЛУУЛАХ Бурханыг эрэн хайсаар байгаарай.

Дараагийн диаграм дээр Сатан/чөтгөрийн бодолтой тэмцэхийн тулд Бурханы хүчээс зуурсаар байхыг харуулсан “шугаман” зураглалыг ашиглалаа. Зүүнээс баруун тийш унших юм бол “шугам”-ны доод талд таны оюун бодолд махан биеийн бодлыг Сатан/чөтгөр өгсөн байгааг харах болно.

Хэрэв та “шугам”-аас дээш гарч Бурханы хүчээс зуурвал Түүнд бодлоо даатгах болно. Гэвч дайсан нөгөө л гэмт бодлыг “шугам”-ын доор танд дахин өгөх болно. Тиймээс та “шугам”-аас дээш гарч тэдгээр бодлыг зайлуулах Бурханы хүчээс дахин зуурах хэрэгтэй. Энэхүү үйл явц нь тэдгээр бодлуудаар дайсан тань уруу халдахаа болих хүртэл үргэлжлэх болно.

Сатан/бузар муугийн бодлыг зайлуулах хүчийг үргэлжлүүлэн
Бурханаас эрэлхийлэх

Энэ бодлыг
зайлуулах Таны хүч
чадалд би
итгэж байна

Энэ бодлыг
зайлуулах Таны хүч
чадалд би
итгэж байна

Би найзаасаа хариугаа
авна

Би найзаасаа хариугаа
авна

Сатан/бузар муу нь
гэмт бодол тарина

Сатан/бузар муу нь
үргэлжлүүлэн гэмт
бодол тарина



5. Хэрэв та ЧӨТГӨРИЙН халдлагад байгаагаа мэдэрвэл таныг ДАРАМТАЛЖ буй чөтгөрийг зайлуулах БУРХАН болон Түүний хүчээс зүүр



Итгэлийн алхаан дунд Сатан/чөтгөрийн тасралтгүй дарамтийг мэдрэх үе байдаг. Энэ нь таны оюун бодолд дусашгүй дайралт юм шиг санагдах болно. Та үүнийг өөрийн хүчээр зогсоож чадахгүй. Тиймээс таныг дарамталж буй Сатан/чөтгөрийн нөлөөг зайлуулах Түүний хүчийг Бурханаас гуйгаарай. Та мөн л адил тухайн дарамтыг зайлуулахыг Бурханаас гуйхдаа итгэлийн тэмцлээр үргэлжлүүлэн тэмцэх хэрэгтэй болно. Чөтгөрийн дайралтын үед тэд нэг л удаагийн дайралтын дараа буугаад өгчихдөггүй. Ялангуяа өдөөгдсөн худал хуурмаг итгэл үнэмшил болон гэм нүгийн хүлээсийн талбарт энэ нь бодитой тохиолддог. Дараагийн диаграмд үүнийг илэрхийлжээ.

“Шугам”-н зураглалыг ашиглан чөтгөрийн дайралтыг харуулья. Дайралт ирэх үед та чөтгөрийг зайлуулах Бурханы хүчийг тэр даруу эрэлхийлэх болно. Дайралтын хүчээс шалтгаалан энэ нь хэд хэдэн удаа давтагдах хэрэгтэй ч болж мэднэ. Гол нь дайралт дахин ирэхээ больж чөтгөрийн нөлөө алга болох хүртэл Бурханы хүчээс зуурсаар байх явдал юм.

Чөтгөрийн халдлагад өртсөн үедээ Сатаныг зайлуулах Бурханы хүчээс зуураарай

Чөтгөрийг
зайлуулах Таны хүч
чадлыг гуйж байна

Чөтгөрийн дайралт



Чөтгөрийн дайралт

Зэвсэгээ зузаатгах нь (Итгэлээр алхсаар байвал юу тохиолддог вэ?)

Миний хуваалцсан зураглалыг бидний амьдралд Сатан/чөтгөрийн хэрэгжүүлдэг стратегийг ярихдаа үргэлжлүүлэн ярих хэрэгтэй болно. Бид аврагдах мөчид Бурханы бүрэн зэвсгийг авахад нээлттэй болдог гэж сурсан. Тэр зэвсэг бол үнэн болох Христ Өөрөө юм. Гэвч анхан үедээ бидний зэвсэг итгэл багатайгийн улмаас маш цөөхөн байдаг. Харин цаашид итгэлээр өсөж үнэн дотор алхах тусам бид зэвсэгээ зузуутган дайсны галт зэвсгийг сөрөн зогсох чадвартай болсоор байдаг. Дайсан бидний өнгөрсөн түүхийг мэддэгээс хойш таны зэвсгийн сул орон зайг цаашид онилсоор л байх болно. Тиймээс итгэлээр үргэлжлүүлэн алхснаар зэвсэгээ зузаатгах нь чухал бөгөөд ингэснээр дайсны дайралтын эсрэг бат зогсох чадвартай болох юм.

Дүгнэлт

Сатан болон түүний бузар муугийн талаар ярих зүйл олон байна. Гэвч энэ судлалын чухал үнэн нь Ариун Сүнсний хүчээс салангид та Сатан/чөтгөрийн өмнө хүчгүй юм. Харин Бурхантай харилцсанаар Ариун Сүнс таны доторхи Сатан/чөтгөрөөс ирсэн бодлыг илрүүлж тэдгээрийг олзлон авах болно.

Дөрөвдүгээр Хичээл

Сэтгэл хөдлөлөө ойлгох нь

НЭГ ДЭХ ӨДӨР

Оршил

Энэ хичээлээр бид сэтгэл санаанд буй шарх болон гэмтсэн сэтгэл хөдлөлийн эдгэрэл дээр төвлөрөх болно. Бид шархныхаа эх сурвалж, мөн Бурханы эдгэрлийн үйл явцыг судлах болно. Хэрэв та энэ талбар дээр зөрчилддөг бол Бурхан эдгээр үнэнийг ашиглан эдгэрлийн үйл явцыг эхлүүлнэ гэж итгэж байна.

Бид сэтгэл хөдлөлийн талаар юуг мэдэх хэрэгтэй вэ?

Эхэнд Бурхан биднийг бүтээхдээ сэтгэл санааны маань нэгэн хэсэг болгож сэтгэл хөдлөлтэй бүтээсэн. Энэ бол бидний “оршихуйн” нэг бүрдэл хэсэг юм. Сэтгэл хөдлөл бол Бурханаас ирсэн бэлэг. Энэ нь бидний амьдралд тохиолдож буй болон тохиолдсон зүйлсийн талаарх мэдрэмжийг илэрхийлэхэд тусалдаг.

Нэгэн олны танил зохиолч “Сэтгэл хөдлөл бол бидний дотор юу болж буйг харуулах Бурханы заагч заалтуур юм. Энэ нь сайн эсвэл муу зүйл ердөө биш. Ердөө л ямар нэг дүрмэнд хязгаарлагддаггүй, хүн байхын нэгэн илэрхийлэл юм. Бие махбодын зовиурт хариу үйлдэл үзүүлдэгтэйгээ адил сэтгэл хөдлөлийн заалтдаа ч мөн адил хариу үйлдэл үзүүлэхэд л болох юм” гэжээ.

Бидний сэтгэл хөдлөл Бурханы үнэнтэй нийцсэн үед Бурханы анхны зорьсон зорилгын дагуу үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлдэг. Харин сэтгэл хөдлөл маань худал хуурмаг итгэл үнэмшилтэй барьцалдаж, тэндээс ундарч байвал гэмтэлтэй болж сэтгэл санаанд замбараагүйдлийг бий болгодог. Гэмийн уналтын дараа Эден цэцэрлэгт болсон сэтгэл хөдлөлийн гэмтэл ямар байсныг харцгаая:



“Гэтэл ЭЗЭН Бурхан хүнийг дуудаж, -Чи хаа байна вэ? Гэсэнд тэрээр -Би Таны дууг цэцэрлэг дотор сонсоод, нүцгэн байсан учир **айж**, өөрийгөө нуусан юм гэж хэлэв.” Эхлэл 3:9-10

Асуулт нь, “Адам Ева хоёр яагаад айдсыг мэдрэх болов?” Гэмийн уналтаас өмнө тэд айдсыг, ялангуяа Бурханаас айх айдсыг мэддэггүй байсан. Тэд яагаад өөрсдийгөө Бурханаас нуув? Тэд гэм нүглийн улмаас Бурханаас нуугдсан бөгөөд худал хуурмаг итгэл үнэмшил нь Бурханаас айх ёстой гэсэн ойлголтыг өгсөн. Бурханд итгэлгүй байх бие даасан сонголтын үр дагавар нь өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй сэтгэлийн гэмтэл буюу айдас хэмээх гэмтлийг учруулжээ.

Дасгал: Таны худал хуурмаг итгэл үнэмшил өдөөгдөх үед мэдэрдэг гэмтэлтэй сэтгэл хөдлөлөө жагсаан бичнэ үү. (бухимдал, айдас, хангалтгүй байдал, буруутгал, ял гэх мэт)

ГЭМТЭЛТЭЙ сэтгэл хөдлөл гэдэг нь худал хуурмаг итгэл үнэмшилтэй нягт барьцалдсан, худал хуурмаг итгэл үнэмшлийн бүтээгдэхүүн юм.

Есүс хүртэл сэтгэл хөдлөлтэй байсан

“Учир нь бидэнд байгаа нь бидний мөхөс байдлыг хуваалцаж чаддаггүй тэргүүн тахилч бус, харин нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн билээ.” Еврей 4:15

“Тэгээд тэдэнд -Сэтгэл минь үхтлээ зовж байна. Энд үлдээд, Надтай хамт сэргээг байцгаа гэв.” Матай 26:38

Есүс махбодод оршин байхдаа та бидний л адил сэтгэл хөдлөл, мэдрэмжтэй байсан. Бидний мэдэрдэг сэтгэл хөдлөлийн гадуур тэр тойроогүй. Яагаад? Учир нь бидний мөхөс байдлыг хуваалцахын тулд бидний сэтгэлийн зовлонг Тэр эдлэх хэрэгтэй болсон. (Еврей 4:15). Лазарын үхлийг харахдаа найзынхаа үхэлд **гашуудсан**. (Иохан 11). Тэр зуутын даргын итгэлд **сэтгэл нь хөдөлж** байсан (Матай 8). Тэр сүмийн ширээг хөмрөхдөө **уурласан** (Иохан 13). Гетсемени цэцэрлэгт тэр үхтлээ **зовсон** (Матай 26:38).

Есүс бидэнтэй адил сэтгэл хөдлөлтэй байсан гэдгийг санаж байх нь яагаад чухал вэ? Учир нь хором мөч бүр, өдөр тутам Тэр яг бидэнтэй адил сонголтуудтай нүүр тулж байсан юм. Бидний туулдаг яг адил асуулттай Есүс тулж байсан нь “Чи өөрийн сэтгэл хөдлөлөөр амьдрах сонголт хийх үү, эсвэл хором мөч бүр Өөрийн Эцэг болон Түүний үнэнийг сонголтоо болгох уу?” гэдэг асуулт.

Хэрэв Есүс Эцэгээсээ хамааралтай байхын оронд Өөрийн сэтгэл хөдлөлөөс эхтэй амьдарсан бол бидний төлөө загалмай дээр ЦОВДЛОГДОХ сонголт хийхгүй байх байсан гэж та бодож үзсэн үү?

Гэмтсэн эсвэл хуурмаг сэтгэл хөдлөл

Гэмтсэн сэтгэл хөдлөл



Гэмтсэн сэтгэл хөдлөл бол давтагдсан дарамт, хүчирхийлэл, цочрол болон сөрөг мессежийн үр дүн юм. Өсөж байх явцдаа сонсож болох сөрөг мессежүүдийг харцгаая. Жишээ нь: “Чи бол муу. Чи бүтэлгүй. Би чамд хайргүй.” (Эдгээр нь үгэн болон үггүй байх боломжтой гэдгийг санаж байгаа биз дээ.) Эдгээр мессежүүд таныг хангалтгүй, үнэ цэнэгүй, хамгаалалтгүй мэт мэдрэмжтэй үлдээжээ гэж бодъё. Энэ нь таны талаархи үнэн гэж та итгэж эхэлмэгц энэхүү мессеж сонсогдох үед л та өөрийг үнэ цэнэгүй, хангалтгүй, хамгаалалтгүй гэж мэдрэх болно.

ХОЁР ДАХЬ ӨДӨР

Хуурмаг сэтгэл хөдлөл



Хуурмаг сэтгэл хөдлөл нь ихэнхдээ эерэг мессеж, эерэг нөхцөл байдлаас үүдэлтэй байдаг. Хэрэв эдгээр нь “Чи чадна. Чамд чадахгүй зүйл гэж байхгүй гэх мэт” эерэг мессежээс гаралтай бол өөртөө бардсан, өөртөө найдсан байдлыг бий болгодог. Яагаад эдгээр сэтгэл хөдлөл нь хуурмаг байдаг вэ? Эдгээр нь хуурмаг байдгийн шалтгаан нь таны Бурханаас салангид бие даан Христигэлт амьдралыг өөрийнхөө чадал, бие даасан байдал дээр суурилан явуулах байдлыг өдөөж БИ гэсэн үзлийг өөгшүүлдэг юм.

“СЭТГЭЛ ХӨДЛӨЛ”-ийн тогтворгүй байдал

Мэдрэмж нь сэтгэл санаанаас ямагт урсаж гардаг. Бид хайр, аз жаргал гэх мэт эерэг сэтгэл хөдлөлийг ч мэдэрдэг мөн айдас, уур хилэн гэх мэт сөрөг сэтгэл хөдлөлийг ч мэдэрдэг. Энэ нь яг л савлуур дээр байгаа мэт. Бидний сэтгэл санаа эерэг болон сөрөг сэтгэл хөдлөлийн савлуур дээр нааш, цааш савлаж байдаг. Хэдийгээр эерэг

сэтгэл хөдлөлд автахад асуудал байдаггүй ч сөрөг сэтгэл хөдлөлд автах үед үүнээс зугтахыг бид оролддог. Бид сэтгэл хөдлөлөө тогтворгүйтгэх байдлаас өөрийгөө хол байлгаж хянах гэж оролддог ч энэ савалгаанаас зайлсхийх аргагүй нь бодит үнэн юм. Энэхүү үнэнийг дараагийн диаграмд харуулжээ:

СҮНС

СЭТГЭЛ САНАА

Эерэг сэтгэл хөдлөл



Сөрөг сэтгэл хөдлөл

Бидний сэтгэл хөдлөл савлууртай адил

Бурхан анхнаас нь сэтгэл хөдлөлийг савалгаатай байхаар загварчилжээ. Энэ нь бидний сэтгэл санаатай амьд биет гэдгийн илэрхийлэл юм. Гэхдээ Бурхан биднийг сэтгэл хөдлөл дээрээ ажиллаасай гэж хүсдэг. Бурхан бидний сэтгэл санааг шинэчлэхдээ баяр хөөр, аз жаргал гэх мэт эерэг сэтгэл хөдлөлийг мэдрээсэй гэж хүсдэг. Харин сөрөг сэтгэл хөдлөлийг маань бидний махан биеийн хандлага, худал хуурмаг итгэл үнэмшлийг илчлэхдээ ашигладаг. Аливаа сөрөг сэтгэл хөдлөлийн ард нуугдаж буй асуудлуудынхаа төлөө Бурханыг өөрийн Эх сурвалж болгохоор Түүн рүү эргэх хэрэгцээг харуулахын тулд бидний сэтгэл хөдлөлийг ашигладаг.



Жишээлбэл, танд аминд халтай эрүүл мэндийн асуудал байлаа гэж бодъё. Энэхүү муу мэдээг сонссон даруйд танд төрөх сэтгэгдэл бол айдас болон санаа зоволт байх болно. Харин энэхүү санаа зоволт, айдсыг Бурханд даатгах уу эсвэл айдас, санаа зоволтоосоо зуурах уу гэдэг сонголтын өмнө та ирэх болно. Хэрэв та сөрөг сэтгэл хөдлөлдөө автсаар байвал энэ нь таныг залгиж, захирах болно. Эсрэгээр нь та сөрөг сэтгэгдлээ Бурханд даатгавал Тэр таны тайвшрал болон амар тайвны Эх сурвалж болох болно.

Сөрөг мэдрэмж, сөрөг сэтгэл хөдлөлөөс аль болох зугтахыг оролдовч энэ нь боломжгүй юм. Тиймээс л бид мэдрэмж гэдэг бол дотоод ертөнцөд маань юу болж байгааг заах заалтуур гэж хүлээж авах нь чухал юм. Мөн энэ мэдрэмжийг удирдах гэж зүтгэх хэрэггүй. Харин сөрөг сэтгэл хөдлөл маань худал хуурмаг итгэл үнэмшлээс үүдэлтэй бол том асуудал болно гэсэн үг.

Сэтгэл хөдлөлийн САВАЛГААГАА хянах гэж оролдох нь боломжгүй юм. Харин Бурхан бидний сэтгэл хөдлөлийг Өөрийн шинэчлэлийн үйл явцад ашиглах чадалтай.

Мэдрэмж ба таны итгэл үнэмшлийн систем

Оюун бодолд маань байнга орж ирж байгаа мессежүүд үнэн эсвэл үнэн биш мэдрэмжийг өгдөг ч бид үнэн гээд хүлээгээд авчих тохиолдол байдаг. Хэрэв хуурмаг мессеж давтамжтай орж ирж байгааг Бурханы үнэнээр шүүлтүүрдэхгүй бол энэ мессежээс үүдэн гарах мэдрэмж нь худал хуурмаг итгэл үнэмшил болж бүрэлдэх аюултай. “Би ... гэж мэдэрч байна” гэдэг нь явсаар “Би гэж итгэдэг” болж хувирна гэсэн үг. Нэгэнт худал хуурмаг итгэл үнэмшлийг үнэн хэмээн хүлээн авсан бол үүнээс урган гарах мэдрэмждээ бид эргэлзэхээ больж эхэлдэг. Мэдрэмж тухайн хүний юуг үнэн гэж хүлээж авахыг тодорхойлчих боломжтой. Энэ нь тухайн мэдр-

эмж дээр дөрөөлсөн махан биеийн зан авирыг бий болгодог. Энэхүү сэтгэл хөдлөл нь биднийг хууран мэхэлдэг тул “гэмтсэн” сэтгэл хөдлөл гэж нэрлэдэг.

Дараагийн диаграмаар, бид юу мэдрэх болон юунд итгэх нь яваандаа нэг зүйл болж байгааг харах болно. Худал хуурмаг итгэл үнэмшилээр тэжээгдсэн гэмтсэн сэтгэл хөдлөл илрэхэд худал хуурмаг сэтгэл хөдлөл махан биеийн зан авирыг бий болгодогтой яг адил махан биеийн зан авирыг бий болгодог.



ГУРАВ ДАХЬ ӨДӨР

“Би ... гэж мэдэрч байна” -аас “Би гэж итгэдэг” - рүү

Гэмтсэн болон хуурмаг сэтгэл хөдлөл нь хэрхэн худал хуурмаг итгэл үнэмшил болдгийг харцгаая. Гэмтсэн сэтгэл хөдлөлөөс эхэлцгээе.

Жишээ: Та ихэнхдээ эцэг, эхийнхээ хүлээлтэнд хүрдэггүй байсан гэж бодье. Энэхүү бүтэлгүй байдлаас үүдсэн мэдрэмж танд төрж эхэлнэ. Тэрхүү бүтэлгүйтийн мэдрэмжээс болоод та ингэж хэлж магад:

Би үнэ цэнэгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй МЭТ САНАГЦДАГ.

Би ингэж МЭДЭРЧ БАЙГАА болохоор:

Би үнэ цэнэгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй мэт ААШИЛДАГ.

Би ингэж МЭДЭРЧ, ҮЙЛДДЭГ болохоор:

Би үнэ цэнэгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй гэдэгтээ **ИТГЭДЭГ**.

Би ингэж **МЭДЭРЧ, ҮЙЛДЭЖ, ИТГЭДЭГ** болохоор:

“Би үнэ цэнэгүй” эсвэл “Би хүлээн зөвшөөрөгдөөгүй” гэдэг нь миний хувьд бодитой **БАРИМТ** юм.

Мэдрэмж нь **итгэл үнэмшил** болж итгэл үнэмшил нь **хөдлөшгүй баримт** болох үйл явц нь урт хугацааны туршид бид өөрсдөө ч анзаараагүй байхад явагддаг. Дээрх жишээ нь гэмтсэн сэтгэл хөдлөл дээр тулгуурласан байсан. Харин одоо **хуурмаг** сэтгэл хөдлөлөөс хэрхэн итгэл үнэмшлийн систем бүрэлдэгийг харцгаая.

Таны эцэг, эх танд байнга л чи буруугүй гэж хэлдэг байсан гэж бодье. Ингэвэл та өөртөө ингэж хэлж болох юм:

Би өөртөө итгэлтэй, бүгдийг чадах юм шиг **САНАГДДАГ**.

Би ингэж **МЭДЭРЧ БАЙГАА** болохоор:

Би өөртөө итгэлтэй, бүгдийг чадах юм шиг **ААШИЛДАГ**.

Би ингэж **МЭДЭРЧ, ҮЙЛДЭГ** болохоор:

Би өөртөө итгэлтэй, бүгдийг чадна гэдэгтээ **ИТГЭДЭГ**.

Би ингэж **МЭДЭРЧ, ҮЙЛДЭЖ, ИТГЭДЭГ** болохоор:

“Би өөртөө итгэлтэй” эсвэл “Би бүгдийг чадна” гэдэг нь миний хувьд бодитой **БАРИМТ** юм.

Эдгээр “мэдрэмж”-ээс үүдэлтэй итгэл үнэмшил танд хэрхэн нөлөөлдөг вэ?

Таны итгэл үнэмшил танд өнөөдөр хэрхэн нөлөөлдөг вэ? Цаашид хоёр үндсэн зүйл үүнээс улбаатай байнга бий болдог. Төстэй үйл явдал болох үед таны мэдрэмж итгэл үнэмшлийг чинь өдөөнө эсвэл итгэл үнэмшлийг чинь өдөөсөн үйл явдал тухайн итгэл үнэмшилтэй чинь холбоотой мэдрэмжийг өдөөнө.



Жишээ нь, та ажилдаа иртэл босс чинь ямарч сануулга, мэдэгдэл урьдчилан өгөлгүйгээр энэ бол таны ажиллах сүүлчийн өдөр гэж хэлжээ. Энэ үед таны хариу үйлдэл бол итгэл үнэмшлийн системээс чинь урган гарах хүлээн зөвшөөрөгддөггүй, үнэ цэнэгүй гэх мэдрэмж юм. Эсвэл таны худал хуурмаг итгэл үнэмшил үнэ цэнэгүй, хүлээн зөвшөөрөгддөггүй гэсэн мэдрэмжийг өдөөн тэрхүү мэдрэмжээс худал хуурмаг итгэл үнэмшил чинь ажиллаж эхэлнэ. Энэхүү үйл явдлаас харахад үүнтэй адил төстэй үйл явдал танд тохиолдвол та худал хуурмаг зүйлд үргэлжлүүлэн итгэх өдөөлтүүд мэдрэмж болон итгэл үнэмшилд чинь явагддаг гэсэн үг.

САНАМЖ: Таны итгэл үнэмшилд юу байгааг бататгах үйл явдал болох болгонд та итгэл үнэмшлээ **өдөөдөг**. Хэрэв таны итгэл үнэмшил Бурханы үнэний үгтэй нийцэхгүй бол та худал хуурмаг итгэл үнэмшлээ давтан өдөөж байгаа хэрэг болно.

Сэтгэл хөдлөл – бодол болон зан авир

Тухайн мөчид гэнэт л орж ирсэн **бодол** дангаараа бидний зан авир эсвэл хандлагыг тодорхойлдоггүй. Харин бодол нь хамтран ажиллах хөшүүрэгтэй байж зан авирыг бий болгодог. Бидний бодлыг хянаж, тухайн бодлыг хүлээн зөвшөөрөх байдалд хүргэдэг зүйл бол **мэдрэмж** юм. Энэ бүхэн бидний мартсан эсвэл далдлагдсан итгэл үнэмшлээс үүдэлтэй байдаг.

Хэрэв ямар нэг бодол бидэнд төрөхдөө ижил төстэй өмнө нь болсон зүйлийн дурсамж бодол эсвэл сэтгэл хөдлөлтэй адилгүй байвал агшин зуур замхардаг. Бид тэрэнд хариу үйлдэл үзүүлдэггүй.

ЭСВЭЛ

Тухайн орж ирсэн бодол өөр адил төстэй хадгалагдсан дурсамж бодлыг сэргээвэл өдөөгдөж зан чанарт маань нөлөөлөхүйц хариу урвал үзүүлэх боломжтой.

Жишээ: Замд явж байтал жижиг оврын ачааны машин өөдөөс ирж байна гэж бодъё. Тэр үед би байсан бол “За бүр дөхөөд ирэхээр нь л хажуу тийш нь эргүүлээд өнгөрчихье” гэж бодоод өнгөрнө. Энэ бодол өнгөрсөнд болсон ямар нэг дурсамжтай холбогдохгүй учраас ямар нэг мэдрэмж, сэтгэл хөдлөлийг бий болгохгүй. Энэ нь миний хувьд зүгээр л орж ирээд л өнгөрөөд л явдаг түр зуурын бодол. Харин эсрэгээрээ би тухайн зүйлээс болж ямар нэг аюул, осолд өртөж байсан бол шууд л найдваргүй, хүсэмжлэшгүй, ичгүүртэй, хямралтай гэх мэт бодол сэтгэл хөдлөлийг дагуулан итгэл үнэмшлийг маань хөндөх болно. Улам илүү бодох тусам илүү сэтгэл хөдлөлд автана. Тухайн бодолд хэр их ач холбогдол өгнө төдий чинээ бодол амилж эхэлнэ. Тэгээд би аюулд орно.



Энэ нь нэг ёсондоо өнгөрсөн дурсамж маань одоо цагтай холбогдож зуршил маань одоо цагийн бодолд хөдөлгөгдөж байгаа хэрэг. Орж ирсэн бодолтойгоо нийлээд өмнөх бодлын зуршил маань сэтгэл хөдлөлийг үүсгэж зан авирыг өдөөж хүчирхэгжүүлж байгаа юм.

Үнэний хэмжүүрээр шүүлтүүрдээгүй сэтгэл хөдлөлтэй байх юм бол өөрийн мэдрэмжээ өдөөж, өөгшүүлэн түүндээ хэт автдаг гэсэн үг. Тэгэхээр бид ер нь л төрсөн цагаасаа эхлээд л амьдралд хариу үйлдэл үзүүлж байдаг учраас эрх чөлөөгөө алдталаа аливаа бодлын зуршил, сэтгэл хөдлөлөө өдөөх зуршилтай байдаг нь сэтгэл хөдлөлийн боол болгочихдог.


ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

Анхлан төрж буй мэдрэмжинд ямар ч буруу байхгүй

“Уурласан ч, нүгэл бүү үйлд...” Ефес 4:26

Ефес 4:26 дээр бидэнд уурлах сэтгэл хөдлөл байж болно гэж хэлж байгаа бөгөөд энэ нь дангаараа гэм биш гэжээ. Мэдээж энэ нь гэмд хөтлөх гүүр боловч ийм сэтгэл хөдлөл байж болох талаар чухал үнэнийг хэлж байна. Хэн нэгэн хүн эсвэл аливаа юмс танд сөрөг сэтгэл хөдлөлийг өгч болох ч сэтгэл хөдлөлд өөрт нь гэм байхгүй гэдгийг хэлжээ. Сөрөг сэтгэл хөдлөл бол бидний сэтгэл санаанд юу тохиолдсоныг илэрхийлэх заалт юм. Сэтгэл хөдлөлийг машины хяналтын самбарын зүү гэж хэлж болно. Бензины шар гэрэл асмагц бид бензин дуусах дөхсөнийг мэддэг. Үүнтэй яг адил бидний сэтгэл хөдлөл бол “сэтгэл санаа”-ны хянах самбарын заалтуур юм. Бид уур уцаар, айдас, буруутгал гэх мэт сэтгэл хөдлөлийг мэдрэх нь сэтгэл санаанд асуудал учирчээ гэдгийг зааж байгаа хэрэг юм.

“СЭТГЭЛ ХӨДЛӨЛ”-ИЙН САМБАР



Бүх төрлийн анхдагч сөрөг сэтгэл хөдлөлүүд нь “Асуудал үүсчээ. Сонголт хийх хэрэгтэй боллоо” гэдгийг илтгэж байдаг. Ямар сонголт вэ? Сонголт нь сэтгэл хөдлөлтэй маань уягдсан байгаа худал хуурмаг итгэл үнэмшлийг сонгох эсвэл Христийг сонгох хоёрын нэг юм. Тиймээс эдгээр сэтгэл хөдлөлийн ард нуугдаж буй худал хуурмаг итгэл үнэмшлийг Бурханаар шийдвэрлүүлэхийн тулд “шугам”-аас дээгүүр гарах хэрэгтэйг харуулахаар бидний сэтгэл хөдлөлийг Бурхан ашигладаг.

Жишээлбэл, та татварт 3,000 доллар төлөх ёстой байснаа олж мэдсэн боловч энэхүү татварыг төлөх хангалттай мөнгө таны дансанд байхгүй байлаа гэж бодъё. Та айдас, санаа зовнилд автах үед таны сэтгэл хөдлөлийн заах самбар асах болно. Яг тэр мөчид та сонголт хийх хэрэгтэй болно. Тухайн сөрөг мэдрэмжинд автах юм бол махан бие болон гэм нүглийн хүчинд автах болно.

Хэдийгээр таны сэтгэл хөдлөл үймэрсэн байгаа ч “Шугам”-аас дээгүүр амьдрах боломжтой

“Эцэж түйлдсэн, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая.”
Матай 11:28

“Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм.” 1 Коринт 10:13

“Тэгээд тэдэнд -Сэтгэл минь үхтлээ зовж байна. Энд үлдээд, Надтай хамт сэргээг байцгаа гэв. Тэр тэднээс жаахан цаашаа яваад, нүүрээрээ унаж, -Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог гэж залбирлаа.” Матай 26:38,39

Есүс загалмайд цовдлогодохоосоо өмнөх шөнө Гетсемени цэцэрлэгт байхдаа Түүний сэтгэл санаа ямар байсныг харцгаая. Тэрээр Матай 26:38 дээр хэлэхдээ “сэтгэл нь үхтлээ зовж байна” гэсэн. Өөрөөр хэлбэл, Есүс загалмайд цовдлогдох гэж байгаа нь маш хүнд дарамт зовлон байсан гэсэн үг. Энэ нь маш хүнд байсан учраас Эцэгээсээ боломжтой бол загалмайг зайлуулаач гэж гуйсан. Гэвч, Есүс тэр даруй Сүнс дотор хариу өгч дуулгаварлалыг үйлдсэн. Хэдийгээр Есүс Сүнсээр сонголт хийсэн боловч тэрхүү зовлон нь алга болсон гэж бодож байна уу? Би үгүй л болов уу гэж таамагладаг. Загалмайд цовдлогдох хүртэл тэрхүү сэтгэлийн дарамт үргэлжилсэн гэж би боддог. Есүс та бидний хийх ёстой тэр сонголтыг хийж Сүнсээр явахдаа сэтгэл хөдлөлд Өөрийг нь захирахыг зөвшөөрөөгүй.

Бидний сэтгэл хөдлөл үймүүлэгдэхэд бид ч гэсэн үүнтэй адил сонголт хийх хэрэгтэй. Бид Христ дотор “шугам”-аас дээгүүр сонголт хийж сэтгэл санаа маань сэтгэл хөдлөлийн “савалгаа”-нд орсон ч Түүний амралт, амар тайвныг мэдрэх боломжтой.

Энэ нь таны амьдралд хэрхэн илрэх вэ? Жишээлбэл, танай захирал таныг өрөөндөө дууджээ. Таны гүйцэтгэлд тэрээр сэтгэл ханамжгүй байжээ. Тэр үед таны дотор ажлын байраа алдах вий гэсэн айдас, түгшүүр эсвэл захирал чинь таныг буруу дүгнэж байгаад уур хүрэх мэдрэмж төрнө. Гэвч, тэр даруй та Христ дотор “шугам”-аас дээгүүр гарч Христийн амар тайван, амралт, итгэлтэй байдлаас хамаарах боломжтой. Энэ нь Бурхан бүх зүйлийг хяналтандаа байлгаж байгаа гэсэн итгэлийн хандлага бөгөөд Түүний амар тайван, амралтыг танд өгнө. Үүнийг илэрхийлсэн диаграмыг доор харуулжээ:

СҮНС

Христтэй адил хандлага:
Итгэлтэй байдал - Амралт - Амар тайван

ШУГАМ

СЭТГЭЛ САНАА

Сэтгэл түгшүүр - Санаа зовнил - Уур бухимдал
ГЭХ МЭТ СЭТГЭЛ ХӨДЛӨЛ

ТАВ ДАХЬ ӨДӨР

Бидний худал хуурмаг итгэл үнэмшлийг Өөрийн Үнэн рүү Бурхан хэрхэн хандуулдаг вэ?

“Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн мөн.” Иохан 17:17

Бурханы үнэн бол итгэгчдийн ашиглах хэрэгтэй Эх сурвалж юм. Итгэл бол мэдрэмж эсвэл амсаж туулах туршлага биш гэдгийг санаарай. Энэ нь баталгаа болон найдвар юм. Итгэл нь биднийг “Би ингэж мэдэрч байна” гэдгээс “Би ингэж итгэдэг” гэдэг төлөвт авчирдаг. Тиймээс бидний ашиглах хэрэгтэй Эх сурвалж нь мэдрэмж биш юм. Харин ч Бурхан юуг үнэн гэж хэлж байгааг итгэл Эх сурвалжаа болгон хэрэглэдэг. Бурханы үнэнд үргэлжлүүлэн итгэснээр Түүний үнэнийг та өөр дээрээ амсах болно. Сэтгэл хөдлөлийнхөө оронд Бурханы үнэнийг итгэлээр сонгож эхлэмэгц ямар үйл явдал болдог вэ?

БУРХАНЫ ҮНЭН хэлэхдээ би бол Түүний дотор хангалттай гэдэг.

БУРХАНЫ ҮНЭН хэлсэн учраас би Түүний дотор хангалттай.

Тиймээс хангалтгүй гэдэг худал хуурмагт би итгэхгүй бөгөөд энэ мэдрэмжийг **БИ ЦААШИД СОНГОХГҮЙ**

Бурханы үг болох Христ дотор би хангалттай гэсэн үнэнд итгэлээр **ИТГЭХИЙГ СОНГОЖ БАЙНА.**

БУРХАНЫ ҮНЭН ба **ИТГЭЛИЙНХЭЭ** улмаас

Христ дотор би хангалттай гэсэн **ҮНЭН ДОТОР БИ АЛХАЖ** чадах болно.

Итгэлийн алхааныхаа эхэн үед бид итгэл үнэмшлийн системд маань өөрчлөлт орж байгааг “мэдрэхгүй” байх боломжтой. Гэвч, итгэлээр Бурханы үнэн дотор үргэлжлүүлэн алхсанаар бидний итгэл үнэмшил болон сэтгэл хөдлөл Бурханы үнэнтэй нийцэж эхлэхийг харах болно.

Тухайн мөчид л бид сэтгэл хөдлөлөөсөө дээгүүрт Есүсийн “БИ БОЛ” гэдгийг СОНГОЖ чадна

“Есүс -Би бол зам, үнэн, амь мөн..” Иохан 14:6

Хэзээ ч хамаагүй нөхцөл байдал, бодол, харилцаа гэх мэт зүйлс бидний сөрөг сэтгэл хөдлөлийг өдөөж болно. Яг тухайн мөчид бид гологдсон мэт, хяналтаа алдах мэт, сул дорой, ялгаварлуулсан мэт мэдрэмжийг авч болно. Харин эдгээр сэтгэл хөдлөл болон үүнтэй холбоотой худал хуурмаг итгэл үнэмшилд автахын оронд Есүсийн “БИ БОЛ” гэдэг үгэнд итгэхийг сонгох боломжтой.

Жишээлбэл:

Би хангалтгүй мэт мэдрэмж төрж байгаа ч: Есүс хэлэхдээ “Би бол чиний сэтгэл ханамж” гэж хэлсэн.

2 Коринт 3:5

Би гологдсон мэт мэдрэмж төрж байгаа ч Есүс хэлэхдээ “Би бол чиний хүлээн зөвшөөрөл” гэж хэлсэн.

Ром 15:7

Би сул дорой мэт мэдрэмж төрж байгаа ч Есүс хэлэхдээ “Би бол чиний хүч чадал” гэж хэлсэн.

Ром 6:10

Та итгэлээр Христийг “Би бол” гэж сонгох тэр агшинд мэдрэмж тэр дороо арилж ч болно, үгүй ч байж болно. Гэвч, Бурхан таны оюун бодлыг Өөрийн үнэнээр шинэчилж Бурхан бол таны “хэрэгцээг хангагч” гэдгийг амсаж мэдэрч эхлэх бөгөөд цаашлаад ямар нэг мэдрэмж төрсөн ч энэ нь асуудал байхаа болих болно. Тэгэхээр танд аливаа төрлийн мэдрэмж төрөх агшинд л Бурханаас тухайн мэдрэмжтэй холбоотой хэрэгцээ рүүгээ ханддаг болоход суралцана гэсэн үг.

Асуулт: Танд байнга төрдөг гэмтсэн эсвэл хуурмаг сэтгэл хөдлөл байна уу? Энэ нь танд Христийн хангамжаас авах ямар хэрэгцээг бий болгож байна вэ?

Бурхантай харилцах нь: Тухайн гэмтсэн эсвэл хуурмаг сэтгэл хөдлөл төрөх агшинд Христэд тухайн зүйлээ даатгаж эхлээрэй.

Шарх



“Учир нь чамайг анчны урхинаас, Бас үхлийн тахлаас авардаг нэгэн бол Тэр юм. Тэр чамайг өдөөрөө хучих бөгөөд Түүний жсигүүр дор чи хоргодох болно. Түүний итгэлтэй байдал бол бамбай болон бэхлэлт юм. Чи шөнийн аймшигаас ч, Өдөр исгэрэх сумнаас ч айхгүй.”

Дуулал 91:3-5

Нэгэнт л та гэмт дэлхийд төрсөн учраас тань руу чиглэн ирсэн хорлолт “суманд” өртөж, шарханд нь өнөөдөр ч шаналж байж болно. Магадгүй таны амьдралд исгэрэн ирсэн “сум” архичин аав, сэтгэл зүйгээрээ хөндий ээж, бэлгийн дарамт учруулсан хойд эцэг ч байж болох юм. Эсвэл гэнэтийн ослоос үүдэлтэй цочрол, биеийн гаж хөгжил, салалт, амиа хорлолт ч байж болно. Гэхдээ эдгээр сумны шархны үр дагавар нь юу вэ?

Эдгээр “сумны” шархны үр дагавар нь худал хуурмаг, сэтгэл хөдлөл дээр дөрөөлсөн Бурхан болон бусад эсвэл өөрийнхөө талаар үүсгэсэн худал хуурмаг итгэл үнэмшлийн систем юм. Тэдгээр “мэдрэмж”-үүд “Би бол хангалтгүй”, “Би хайрлагдаагүй”, “Би буруутай” гэх мэт үнэ цэнэгүй, ичгүүртэй, өөрийгөө буруутгаж, гологдсон худал хуурмаг итгэл үнэмшлийг төрүүлдэг. Жишээлбэл, та бага насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн байлаа гэж бодъё. Тэгвэл та өөрийгөө ичгүүртэй нүдээр харж үнэ цэнэгүй гэдэгтэй итгэх болно. Энэ худал итгэл үнэмшил маш хүчтэй танд нөлөөлснөөс болж эрэгтэй хүнээр хайрлагдах зохисгүй гэж өөрийгөө дүгнэж магад. Гэтэл нэгэн бурханлаг эр хүн таны амьдралд гарч иржээ. Энэ нь та хоёрыг гэрлүүлэх Бурханы хүсэл байлаа гэж бодъё. Гэтэл та өөрийгөө үнэ цэнэгүй гэж гүн бат мэдэрдэг тул танд зориулсан бурханлаг эр хүнийг Бурхан хангаж өгөөд байхад л тэрхүү үнэ цэнэгүйдлийн хүлээс таныг гэрлэхэд саад болох болно. Энэ нь өөрийн үнэ цэнэгүй гэдэг худал хуурмагийг хаацайлж Бурханы нигүүлсэл болон үнэнийг хүлээн авахгүйд хүргэдэг. Жон Элдриж гэдэг хүн Ариун Романс номондоо энэхүү “сумны” талаар ийнхүү өгүүлсэн байдаг:

“Бидний зүрх сэтгэл рүү чиглэн ирдэг үхлийн сумнаас хэрхэн хамгаалах вэ? Аль хэр хэмжээний алдагдлыг зүрх сэтгэл минь үүрч чадах вэ? Хэрэв бид шарх байгаа гэдгээ хүчээр үгүйсгэж өөрөө багасгахыг оролдох аваас зүрх сэтгэлээ үгүйсгэж энэ ертөнцөд илүү дээр хүн шиг харагдах хэрэгцээний улмаас өнгөн хэлбэрийн өөдрөг байдлыг бий болгож амьдрах болно. Нөгөө талаар, тухайн сумыг тэврэн авч ийм л байх ёстой юм шиг байх аваас зүрх сэтгэлээ алдаж цөхрөлд унах болно. Итгэл найдвараа алдах нь амьсгалахаа зогсоохтой яг адил үр дагаварыг зүрх сэтгэлд өгдөг. Бидний дотор давагдашгүй айдаст хучигдсан гүн гүнзгий хүсэл эрмэлзлийг хангахад туслах хэн нэгэн байдаг ч болоосой.”

Бид бүгд л ямар нэг байдлаар шархалсан байгаа. Бид гэмт дэлхийд амьдарч байгаа учраас шарх түүний нэг хэсэг нь юм. Гэвч, тавдугаар хичээлээр Бурханаас ирэх шархны эдгэрлийн талаар болон Түүний эдгэрлийг хүлээн авах өөр өөр арга замуудыг суралцах болно.

Тавдугаар Хичээл

Шархалсан зүрхийг эдгээх нь

“Тэр эмтэрсэн зүрхтэй хүмүүсийг анагааж, Тэдний шархыг боодог.”

Дуулал 147:3

НЭГ ДЭХ ӨДӨР

Оршил

Бид сэтгэл хөдлөлийн гэмтэл болон шархны үр дагаварын талаар ярилцсан тул зүрх сэтгэлийн шархыг эдгээх Бурханы үнэн дээр төвлөрөхийг хүсч байна. Бурхан “зүрх эсвэл зүрх сэтгэл” гэдгээр юуг илэрхийлж байгааг эхлээд харцгаая.

“Зүрх” гэж юу вэ?

Зүрх гэдэг үг бибрид 795 удаа бичигдсэн байдаг. Тиймээс шархны эдгэрлийн талаар ярихад зүрхний талаар заавал оруулах нь чухал гэж би бодож байна. Үнэн гэвэл Бурхан Өөрөө “зүрх”-тэй. Давидын талаарх библийн ишлэлүүдэд үүнийг дурдсан байдаг:

“ЭЗЭНд найдагч бүгд ээ, Хүчтэй байн, ЗҮРХЭЭ зоригтой байлга.” Дуулал 31:24

“Түмэн цэргүүд намайг бүслэвч Миний ЗҮРХ айхгүй. Миний эсрэг дайн гарсан ч, Энэ бүгдийн дунд би итгэлтэй байх болно.” Дуулал 27:3

“Та "Миний царайг эрэн хайгтун" гэхэд Миний ЗҮРХ Танд "ЭЗЭН, Таны царайг би эрж хайх ёстой" гэж хэлжээ.” Дуулал 27:8

Эдгээр ишлэлүүдээс харвал зүрх нь сэтгэл санаатай үндсэндээ холбоотой харагдаж байна. Тиймээс шархны эдгэрлийн талаархи сэдвийнхээ хүрээнд сэтгэл санаа болон зүрхийг аль алийг нь сольж хэрэглэх болно оо.

Зүрх нь үргэлж Бурханы тухай байдаг. Бид зүрхний гүнээс Есүст итгэдэг. Бурханы үг зүрхэнд таригдах ёстой байдаг. Бурхан хүний сүнсээр дамжуулан бидний зүрхэнд ярьдаг. Жим Ричард “Үл үзэгдэгч хил хязгаараа тэлэх нь” хэмээх номондоо “зүрх бол үл үзэгдэх нь үзэгдэх рүү шилжиж, боломжгүй нь боломжтой болгогдож, сүнслэг бодит байдал материаллаг бодит байдал болох орчин” гэж хэлжээ.

Бид Мари болон Мартагийн түүхийг уншихдаа Марта Есүсийн хөлд сууж байгаа Маритай адилгүй гал тогоонд байсан гээд л зэмлэдэг. Гэвч үндсэн асуудал Марта гал тогоонд байсанд биш юм. Харин түүний асуудал нь зүрх сэтгэлд нь байсан. Тэр Есүсийн төлөө ямар нэг зүйл хийснээрээ бусдын хүлээн зөвшөөрлийг эрснээр зогсохгүй Марийг тусалсангүй гэж зовоосноороо өөрийгөө зөвтгөгч болсон юм. Гэхдээ Марийн хувьд яг адил зүйл бодсон ч байх боломжтой. Есүсийн хөлд суунгаа “Марта яачихаав дээ? Гал тогоонд байхаас илүү Есүстэй байх нь чухал бус уу? Чухал зүйлээ Марта эхлээд хийгээсэй” гэж бодож байсан ч байж магад. Хэрэв Мари тэгж бодсон бол мөн л адил өөрийгөө зөвтгөгч болох байсан. Гэхдээ Марийн хувьд Есүсийн хөлд сууж байсан үйлдлээс нь илүү зүрх сэтгэл нь зөвт байсанд байгаа юм. Тэрээр Христийн оршихуйд байхын төлөө өлсөж, цангаж байсан юм.

Бид зүрхэндээ шорон болон өрөө хэрхэн бий болгодог талаар үргэлжлүүлэн судлая.

Та зүрхэндээ шорон/өрөө байгуулдаг

“Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.” Илчлэлт 3:20

Төрсөн цагаасаа эхлээд л бид зүрхэндээ өрөө тасалгаатай байшин үүсгэж эхэлдэг. Би энэ байшинг “шарх” гэж нэрлэе. Бид амьдралын туршлага хуримтлуулах тусмаа тухайн байшиндаа өрөө тасалгаа нэмдэг. Зарим өрөө



тасалгаанууд нь айдас, уур хилэн, эмзэг байдал, хангалтгүй байдал гэх мэт шархнаас үүдэлтэй махан биеийн зан авирыг агуулдаг. Зарим өрөө нь хүчирхийлэл, гологдол, орхигдох гэх мэт шархлуулсан үйл явдлаар дүүрсэн байдаг. Тэнд мөн эцэг, эх, хойд эцэг эхийн өрөө ч байгаа.

Тэдгээр өрөөний зарим нь нөгөөгөөсөө харьцангуйгаар жижигхэн байдаг нь том өрөөтэй адил зүрхэнд маань ноцтой гэмтэл учруулсан нөлөөллийн хувьд арай бага учраас тэр юм. Харамсалтай нь амьдрах явцдаа тухайн өрөөнийхөө асуудлыг шийдвэрлээгүйгээс болоод сэтгэл санаанд маань тухайн өрөөний эзлэх орон зай томорсоор л байдаг. Энэ томрох тусмаа бидний баяр хөөр, амралтаас хулгайлж байдаг. Тэр нь биднийг захирч, ядраахад хүргэнэ. Үүнийг шийдэхгүй бол энэ байшин яг л хорт хавдартай адил зүрхээр тархаж, зүрхийг алдаг. Зүрх сэтгэлийн өвчин бодит махан зүрхийг аажмаар гэмтээдэг шиг шарх нь “сэтгэл санаа”-ны зүрхийг мөн устгадаг.

Эдгээр өрөөнүүдийн учруулдаг зовлонгоос болоод бид өрөөгөө түгждэг. Бид эдгээр дурсамж, мэдрэмж, тохиолдлуудаа түгжчихвэл өнөөдөр бидэнд нөлөөлөхгүй гэж андуурдаг. Яг энэ мөчид эдгээр өрөөнүүд зүрхний шорон болж хувирдаг. Тэгээд бид эдгээр бүх зүйл тохиолдоогүй мэт энэ сэтгэл санааны шоронгоос зайлж (өөрийгөө хамгаалж, тусгаарласнаар) чадна гэж боддог. Биднийг энэхүү шоронгоос чөлөөлж, эдгээхээр Бурхан ирээд хаалга тогших үед бид Түүнийг оруулахыг хүсдэггүй. Тэгээд хаалган дээрээ зогсчихоод Бурханд “үгүй” гэж толгой сэгсэрдэг. Яг үнэндээ бид хаалганыхаа өмнө зогсож байгаа биш харин бидний хувьд шорон болсон өрөөн дотроо түгжигдчихээд байгаа хэрэг юм.

Бид зүрх сэтгэлдээ барьж байгуулсан байж болох шархны шорон/өрөөнүүдийн жишээ:

Бэлгийн хүчирхийлэл	Сэтгэл зүйн хүчирхий-	Гологдол	Өөрийгөө үзэн ядах
Эцгийн хүчирхийлэл	лэл	Бие махбодийн хүчир-	Эхийн хүчирхийлэл
Хөсөр хаях	Хойд эцэг, эхийн хү-	хийлэл	Гэр бүл салалт
Өөрийгөө буруутгах	чирхийлэл	Айдас	Хангалтгүй
	Уур бухимдал	Эмзэг байдал	Үнэ цэнэгүй

Дасгал: Дээрх жагсаалтаас нэг болон түүнээс илүүг сонгоно уу. Өөрт чинь хамааралтай зүйлс байхгүй байвал өөрт чинь илэрхий биш боловч шархалсан талбарыг тань илчилж өгөхийг Эзэнээс гуйгаарай. Сонгосон зүйлээ доор бичнэ үү.

Асуулт: Шархалсан өрөөнүүд чинь бодол, сонголт болон үүнээс ч илүүтэйгээр Бурхан болон эцэг эх, хань ижил, өөрийнхөө талаарх мэдрэмжинд чинь хэрхэн нөлөөлж байна вэ? Эдгээр өрөөнүүд таны өсөлтийг хазаарлаж байх боломжтой юу?

Бурханаас САЛАНГИД бид шархаа хэрхэн эдгээхийг оролддог вэ?

1. Өөрийгөө хамгаалах/тусгаарлах




Тухайн үйл явдлын бидэнд учруулсан өвдөлтөөс өөрийгөө тусгаарлаж, хамгаалахыг хичээхдээ бид тэр шоронгийн торны цаана өөрчдийгөө цоожилчихдог. Хэрэв бид шарх эсвэл шархлуулсан үйл явдлын дурсамжаа түгжчихвэл тухайн үйл явдлын учруулсан өвдөлтөөс өөрийгөө хамгаалж чадна гэж найддаг. Өөрийгөө хамгаалах/тусгаарлах нь өнгөрсөн шархаа банкны сейфэнд хийж түгжээд ахин амьдралд маань ямар ч нөлөө үзүүлэхгүй гэж орхихтой адил.

Ярьж байгаа зүйлийнхээ утгыг жишээгээр тайлбарлая. Нэгэн эрийг ээж нь төрөхөд нь голж хаяад үхэх хүртлээ тэр зангаа хаяагүй ажээ. Тэр эр ээж нь өөрийг нь хэрхэн голдог байсан болон тэр нь өөрт нь ямар үр дагавартай байсныг надад хуваалцсан юм. Тэр эр Христийг мэддэг байснаар барахгүй Түүгээр амьдардаг байсан. Нэг өөрчлөлт түүнд ирэх хүртэл нөгөө эр Христ дотор алхам бүр гайхалтай алхаж байлаа.

Гэтэл тэр үйл явдал түүний баяр хөөрийг аажмаар сорж авч байгааг ажигласан юм. Тэр уур уцаартай байх болж өөрийгөө хамгаалж эхэлсэн. Өөрийгөө хамгаалах нэг арга нь хүмүүсээс дөлж, өөрөөсөө холдуулах байлаа. Эцэст нь Христийн амь түүгээр дамжин илэрхийлэгдэхээ больж эхлэхийг харсан юм. Энэ бүхэн яагаад тохиолдов?

Үнэн: Зовлонгоос өөрийгөө тусгаарлаж, хамгаалахыг оролдох нь хоосон төөрөгдөл юм. Учир нь та өөрийгөө зовлонгоос хамгаалж чадахгүй. Махан бие эсвэл би өөрөө өөрийгөө шархнаас хамгаалж чадахгүй. Дээрх банкны сэйфний онолоор шарх банкны сэйфэнд хадгалагдахаас илүү таны нөхцөл байдал, харилцаанд бага багаар сөргөөр нөлөөлж “сэтгэл санааны цоорхой”-гоор аажмаар “дусагнаж” эхэлдэг.



ХОЁР ДАХЬ ӨДӨР

2. Хав дарж орхих

Өөрөөр хэлбэл шархнаас өөрийгөө хамгаалах, тусгаарлахын тулд бид хав дардаг. Хав дарах оролдлого нь хоёр амьдралаар амьдрахад хүргэдэг. Энэ нь биднийг бүх юм “зүгээр” юм шиг дүр төрхийг үүсгэн маск зүүж тухайн үйл явдал миний амьдралд нөлөөлөхгүй байгаа юм шиг аашилуулдаг. Хав дарахыг өөрөөр “чигжих” гэж хэлдэг. Бидэнд цаашид сөргөөр нөлөөлөхгүй эсвэл аяндаа алга болно гэж найдан цааш нь хийгээд “чигжиж” орхидог.

Үнэн: Ангилан ялгах нь цөмийн цахилгаан станцын реактораас цацраг идэвхит туяа хайлж урсан гарч байгааг цааш нь хийгээд хадгалаад байхтай адил юм. Өөрийгөө хамгаалж, тусгаарлахтай адил хав дарах нь мөн л төөрөгдөл юм. Зовлонг цааш чигжиж орхино гэдэг ойлголт байхгүй. Урьд нь дурьдсан шиг цааш дарж орхихыг оролдвол бидний амьдралын талбар бүрээр шүүрч асгарах болно.

3. Зугтах эсвэл өвдөлтийг намжаах



Хэрэв бид зовлон шаналалаа тусгаарлах эсвэл хав дарж чадахгүй бол өвдөлтийг намжаах эсвэл зугтах оролдлого хийдэг. Үл хэрэгсэх, өөрийгөө хянах, эм тан хэрэглэх (архи, хар тамхи, эм тариа гэх мэт) зэргээр зовлонгоо намжаах эсвэл зугтах гэж оролддог.

Зовлон шаналалаа Эзэнээр шийдүүлэхийн тулд Түүнийг урихгүй бол зугтах эсвэл өвдөлт намжаах арга хэрэглэхээс өөр замгүй. Зугтах оролдлогын жишээг доор харуулав:

Ажил
Порно
Бэлгийн харьцаа
Кино

Дэлгүүр хэсэх
Бурханы төлөө ажиллах
Хэтрүүлэн идэх
Утас

Телевиз
Хобби
Орчноо хянах
Компьютер

Үнэн: Ариун Сүнс эдгээхээс нааш зовлон шаналалаас зугатах арга байхгүй. Зугатах бүх оролдлогууд тухайн үедээ л аргацаахаас өөрөөр жинхэнэ эдгэрэл, эрх чөлөөг хэзээ ч бий болгохгүй.

Дасгал: Та шарх болон зовлон шаналалаасаа зугтахыг оролдож байгаа хэлбэр байна уу? Дээрх жагсаалтаас ашиглаж болно.

Та эдгээр ойлголтуудыг уншиж танилцсан тул асуултанд хариулах цаг гаргана уу. Та нэг болон түүнээс дээш арга замаар өөрийн шарх эсвэл зовлон шаналалаа давж гарахын тулд хав дарах, өөрийгөө тусгаарлах, өөрийгөө хамгаалах зэрэг оролдлогууд хийж байна уу? Хэрэв тэгж байгаа бол тэр нь хэр үр дүнтэй байна вэ?

Бурхантай харилцах: Энэ хэсгийг уншиж байхад Ариун Сүнс таны өөрийгөө хамгаалж, тусгаарлаж, хавдарж, зугтахыг оролдож байгаа зовлон шаналал болон шархтай талбарыг илчилж өгсөн гэж итгэж байна. Хэрэв үгүй бол тэдгээр талбарыг харуулж өгөхийг Түүнээс асуух цаг гаргаарай.

Сатан/чөтгөр таныг шоронд хориотой байлгахыг хүсдэг.

Сатан/чөтгөр таныг шоронгийн торонд найдваргүй, шархалсан, зовлон шаналалтай байдал дотроо өөрийгөө цоожилж тэр дотроо амьдрахыг чинь үнэхээр их хүсдэг гэдгийг төсөөлөл төдий л мэдэж байгаа байх. Хэрэв та Бурханы эдгэрлийн үйл явцыг эсэргүүцвэл Бурханаас эдгэрэл гуйх сүнслэг хормыг алдаж шаварт “гацах” болно гэдгийг чинь чөтгөр мэддэг. Тиймээс бидний ярилцсанчлан Сатан/чөтгөр бидний гэм нүглийн хүч болон махан биетэй маань уялдаатай ажиллаж таныг чөлөөлөхөөс хойш татаж байдаг. Таныг шоронд байлгах ямар стратегиудыг тэр ашигладаг вэ?

1. Таны шоронгийн торны ханыг ЗУЗААТГАН, ӨДӨӨХ өнгөрсөн шархыг байнга таны оюун бодолд өдөөж байдаг.



Таныг шархлуулахуйц үйл явдлын дурсамж тархинд чинь хадгалагдсан байдаг. Энэ нь утас болон компьютерийн дэлгэцэн дээр байнга байж байдаг зурагтай адил юм. Сатан тэрхүү дурсамж болон дурсамжтай холбоотой мэдрэмжийг тасралтгүй слайд шоу шиг гаргахыг оролддог. Хэрэв та тэрхүү шархлуулам үйл явдлаас үлдсэн мэдрэмж, бодлууддаа автсаар байвал таны шоронгийн хана зузаарч томорсоор байх болно гэж мэддэг.

2. Хэрэв та сүнслэг эдгэрлийн замыг сонговол Сатан шоронд чинь буцаан хорихын тулд ЭСЭРГҮҮЦЛИЙГ таны дотор тавихыг оролддог.

Та Христээс эх сурвалжтай амьдрах аялалыг эхлүүлж байхдаа Сатан хэрхэн эсэргүүдгийг олж мэдсэн байх. Учир нь ямар ч шийдвэргүй “дундын” бүсэд өөрөөсөө эхтэй амьдарч байхад чөтгөр таныг эсэргүүцэх шалтгаан байхгүй. Гэвч, та үнэнийг сурч, итгэж, сонгож эхэлмэгц Сатан эсэргүүцэж эхэлдэг нь Бурхантай таныг харилцаж, эдгэрэл явагдана гэдгээс үхтлээ айдаг.

3. Сатан/чөтгөр таныг шоронд чинь буцаан татах ялагч, махан биеийн, уруу татлагын, үл итгэгч, эргэлзээтэй БОДЛУУДЫГ таны дотор СУУЛГАХЫГ оролддог.

а. **Итгэлгүй/эргэлзээтэй бодлууд:** “Бурхан намайг эдгээхгүй, чадахгүй”, “Зовлон шаналал дэндүү их байгаа болохоор Бурханыг оролцуулж чадашгүй нь”, “Би Бурханаас гуйхгүй. Учир нь Түүний нигүүлсэл зовлон шаналалыг минь давж гарч чадахгүй”, “Надад тохиолдсон зүйлсээс үүдэлтэй ялагдмал байдал, уур бухимдал, үл уучлал, айдас, зовлон шаналалаас чөлөөлөх хангалттай хүч Бурханд байхгүй”

б. **Уруу татагч бодлууд:** “Үргэлжлүүлэн зовлондоо умбах. Эцсийн эцэст энэ үйл явдал дэндүү шархлуулсан. Хэрэв би нэг ном уншчих юм бол эсвэл нэг зөвлөгч дээр очвол эдгэрчих байх. Энэ үйл явдал өнгөрсөнд болсон болохоор зүгээр л орхиод шархаа түгжээд орхичих хэрэгтэй”

в. **Махан биеийн бодлууд:** “Надад (хорсох, уурлах, үл уучлах, өөрийгөө үзэн ядах, хангалтгүй гэж бодох гэх мэт) эрх байгаа”, “Манай (аав, ээж, хойд эцэг эх, ах дүү, өмнөх нөхөр, эсвэл эхнэр) надад хийсэн зүйлийнхээ төлөө надаар уучлуулах эрх байхгүй”, “Хэрэв би тэднийг уучилбал хариугаа авалгүй явуулчихаж байгаа хэрэг”

г. **Ялагч бодлууд:** “Би.....(хүчирхийлэл, шарх, салалт, хөсөр хаягдал) амсвал таарсан амьтан. Би үнэ цэнэгүй, бохир. Би Бурханы эдгэрлийг авах үнэ цэнэгүй”

4. Сатан/чөтгөр таныг өвдөлтөө зогсоож, намжаахын тулд ЗУГТАХ арга хэрэгслийг ашиглахад уруу татах болно.

Бид өмнөх хэсгүүдэд өвдөлт намжаах, зугтах гэж оролддог талаар суралцсан. Дайсан энэ зугтах механизмийг оюун бодолд чинь байнга авчирч зугтах оролдлого хийлгэхээр уруу татах болно.

5. Сатан/чөтгөр таны ЗАВГҮЙ байдлыг ашиглан шархтайгаа тэмцэхгүй байлгахгаар сатааруулдаг.

Энэ бол маш зальхай, үр дүнтэй арга юм. Дайсан надад олон жилийн турш ашиглахыг оролдсон аргуудын нэг юм. Хэрэв би өөрийн бизнес, хобби гэх мэт зүйлс дээр төвлөрч завгүй байх юм бол өвдөлтөө санах шаардлагагүй болчихдог байлаа.

Бид маш анхааралтай байх хэрэгтэй нэг зүйл бол Сатан/чөтгөр таныг шархны шоронд чинь хорьж байхын тулд янз бүрийн зогсоох аргыг хэрэглэх болно. Энэ нь яг л резинээр уягдсан мэт эрх чөлөө рүү тэмүүлэх тусам дайсан таныг шоронд чинь буцаан татах гэж оролдох болно.

Түлхүүр үнэн: Хэдийгээр чөтгөр оршин байдаггүй байсан байлаа ч бидний махан бие, гэм нүглийн хүч бидний дотор байдаг учир дээрх зарчим ажилласаар л байх боломжтой юм. Гэвч нэгэнт Сатан болон чөтгөрүүд оршин байдаг тул “ариун бус гурвал” (махан бие, гэм нүглийн хүч, Сатан) амлагдсан эрх чөлөө, эдгэрлийг амсахаас таныг хол байлгах гэж ажилласаар л байх болно.

Бид шорон/өрөөндөө эдгэрлийг авчруулахаар Бурханд нээж өгөхгүй бол яах вэ?

1. Шархлуулсан үйл явдлаас үүдэлтэй бодол, мэдрэмждээ суурилсан “өгөгдмөл” мэдрэмжийг хөгжүүлэх болно.

*“Тэдний хувьд **“НОХОЙ БӨӨЛЖСӨӨ ДОЛООДОГ, гахайг угаасны дараа шаварт буцаж хөлбөрдөг”** хэмээх үнэн сургаалт үгийн дагуу тохиолдсон аж.” 2 Петр 2:22*

Зарим хүмүүс өнгөрсөн үйл явдлыг оюун бодолдоо байнга тээж байдаг. Үүний үр дүнд тэрхүү бодол оюун бодолд орж ирэх бүрт “өгөгдмөл” мэдрэмжийг хөгжүүлж байдаг. Петр 2:22-г үүнийг нохой бөөлжсөө долоох гэж хэлсэн нь их оновчтой санагдлаа. Яг энэ санааг өөрийнхөө жишээнээс тайлбарлая.

Би аавынхаа эсрэг хорсол, үл уучлал дотор амьдарсаар байхдаа шархлуулам үйл явдлын талаархи бодол оюун санаанд орж ирэх болгонд үл уучлал, уур бухимдлын “өгөгдмөл” мэдрэмж илэрдэг байлаа. Миний бас нэг өгөгдмөл хариу үйлдэл хангалтгүй, эмзэг, айдастай байдал байлаа. Эдгээр хариу үйлдлүүд өдөөгдөхөд хэрхэн хариу үйлдэхээ бодох ч сөхөөгүй болдог байлаа. Ямар нэг шархлуулсан үйл явдлын талаар эсвэл аавын талаар бодол орж ирэх болгонд л **автоматаар** хариу үйлдэл үзүүлдэг болсон байлаа.

2. Шорон доторх мэдрэмжүүд ӨССӨӨР илүү хүчтэй, салшгүй болдог.

Шархтай холбоотой бодол, мэдрэмждээ автах тусам илүү хүчтэй, салшгүй болох болно. Тогтмол фитнесээр хичээллэдэг хүн хүчирхэг болдогтой адил шархлуулам үйл явдалтай холбоотой бодол мэдрэмж ч мөн адил байнга бодох тусам хүчирхэгждэг.

Насанд хүрсэн хоёр хүүхдээ алдсан эх байдаг юм. Тэр эмэгтэй хүүхдээ алдсан харууслаа дахин дахин дурсахыг олон жил харж билээ. (Энэхүү түүхийг хуваалцсанаараа би харуусах хэрэггүй гэж хэлэх гээгүй юм шүү. Харуусал бол байх зүйл юм.) Харин тэр эмэгтэй түүхээ хуваалцах бүрт үүсдэг байсан асуудал нь шарх нь сэдэрч өөрийгөө өрөвдөх байдал нь улам хүчирхэгжиж байсанд байгаа юм. Үүний улмаас тэр эмэгтэй Бурханы эдгэрлийг авахын оронд харууслаас үүдэлтэй шархны балчиг шаварт шигдсээр байсан юм.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

3. ЭВЛЭРЭНГҮЙ БАЙДАЛ - “Яахав дээ болж л байна ш дээ”

Бурханыг эдгэрлийн үйл явцад оролцуулахгүй байх нэг зүйл бол эвлэрэнгүй байдал юм. Та магадгүй эдгэрлийн талаар ном уншиж, зөвөлгөө авсан ч эдгэрэл явагдаагүй тул залхсан байж магад. Магадгүй хэсэг хугацаанд Бурхан эдгээнэ гэж эрэн хайсан боловч ямар ч эдгэрлийг аваагүй байж болох юм. Тиймээс нэг л мэдэхэд “Яахав дээ болж л байна ш дээ” гэсэн бодолтой болсон байж болно. Энэ бол маш аюултай зүйл бөгөөд Сатан таныг шархны хүлээсэнд чинь хүлцэнгүй байлгах үүд хаалгыг нээж байгаа хэрэг болно.

4. Зүрхний ХАТУУРАЛ



Миний хувьд маш асуудалтай нэг зүйл бол Бурханыг эдгэрлийн үйл явцдаа урихгүй байснаар Бурханд хандах зүрх хатуурдаг. Зүрхний хатуу байдал нь хадгаламжийн хүүтэй бичиг авахтай адил юм. (Жинхэнэ хүү нь бодитой). Бид улам илүү урт хугацааны хадгаламжтай байх тусам л хүү нь өсдгийг мэднэ дээ. Шарх яг үүнтэй адилхан байдаг. Цаг хугацаа өнгөрөх тусам Бурханыг эдгэрэлдээ оролцуулахыг зөвшөөрөхгүй хаалгаа цоожилсноор зовлон дээрээ улам илүү зовлонг нэмдэг. Эдгээр “хуримтлагдсан” зовлон нь Бурханаас асуудлынхаа гарцыг хайхаас хөндийрүүлсэ-

эр л байдаг. Аажмаар та Бурханаас бүрэн холдож Түүнийг эдгэрлийн эх сурвалжаа болгохоор хайхаа зогссон байдаг. Үүнийг илэрхийлэх түүхийг тангтай хуваалцья:

Сүйт бүсгүй нь хуримынхаа өдөр машины ослоор нас барсан тухай надтай хуваалцсан миний дагалдуулж байсан нэг залуу байсан юм. Тэр залуутай энэ үйл явдлаас хойш 15 жилийн дараа уулзсан боловч түүний ярьсан зүйл нь энэ байлаа. “Бурхан миний хайрладаг цорын ганц хүнийг алчихсан”. Энэ үгийг тэр маш гүн гүнзгий уур хилэнтэйгээр хэлсэн тул 15 жилийн турш тэрээр Бурханы эсрэг зүрхээ хатууруулж байжээ гэдэг нь тодорхой байсан юм.

5. НАЙДВАРГҮЙ мэдрэмж

Эвлэрэнгүй байдлаас ч аюултай зүйл бол эдгэрэл чөлөөлөлтийн найдвар тасарсан байдал юм. Найдваргүй байдал нь “сэтгэл санааны гүн ангал”-тай адил бөгөөд эдгэрлийн ямар ч найдлага байхгүй гэж дүгнэн харанхуй байдалд автах явдал юм. Энэ найдваргүй байдал нь яваандаа цөхрөлийг бий болгож таныг ноцтойгоор гэмтээн Бурхантай алхах алхааг тань бүх түвшинд устгах ч боломжтой.

6. СЭТГЭЦИЙН болон МАХБОДИЙН эмгэг үүсэх ч боломжтой

Өөрсдийн шархыг Бурханаар эдгээлгэхгүй явсаар сэтгэцийн эмгэгтэй болсон хэд хэдэн хүмүүстэй ажиллаж байлаа. Үүний улмаас хямрал, хэт мэдрэг эмгэг, үймрэх айдас, хоолны хэм алдагдал гэх мэт зүйлс болдог. Шарх “хорт хавдартай” адил оюун бодол төдийгүй бие махбод руу ч дайрдаг нь эмгэнэлтэй.

Шарх нь сэтгэл зүйн хувьд эрүүл бус сүнслэг байдлыг бий болгодог

“Сэтгэл зүйн хувьд эрүүл сүнслэг байдал” хэмээх номондоо Пете Шазарро шархны улмаас бий болдог “сэтгэл зүйн хувьд эрүүл бус сүнслэг байдал”-ын дөрвөн шинж тэмдгийг онцолжээ. Тэдгээрийг бүгдээрээ харцгаая:

1. Бурханаас хөндийрөхөд Бурханыг ашигладаг

Бурханаас хөндийрөхийн тулд Бурханыг ашигладаг гэдэг нь өөрийн зовлон шаналалаас зугтахын тулд өөрөө ч мэдэлгүй Христитгэлийн аливаа үйл ажиллагааг зугтах хэрэгслээ болгон ашиглахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, бид өөрсдийн зовлон шаналалыг далдлахын тулд Бурханы төлөө ажиллаж эсвэл үйлчлэл хийхийг оролддог. Мөн Бурхантай нэг ёсны барьцаа хийх төлөвлөгөө зохиодог. Энэ нь Бурханы төлөө хангалттай ажиллах юм бол Тэр биднийг эдгээнэ гэсэн тохиролцоо шиг зүйл гэсэн үг.

Аливаа зүйлийг “гүйцэтгэл” хийж байж санаа амардаг над шиг хүмүүст энэ тохиролцоо хийх оролдлого байдаг. Миний Христитгэлийн амьдралын олон жилийг энэхүү тохиролцооны сэтгэлгээ тушсан. Би байнга л Эзэнд их зүйлийг хийж өгөх тусам Эзэн надад их зүйлийг хийж өгөх юм байна гэж боддог байсан. Харамсалтай нь юу ч өөрчлөгдөөгүйгээс гадна шархны нөлөө нь улам л аюултай болж ирсэн.

2. Сэтгэл хөдлөлөө үл хэрэгсэх

Бидэнд шархнаас маань үүдэлтэй уур бухимдал, гуниг, айдас гэх мэт мэдрэмжүүд оргилж эхлэхэд бид зүгээр л үл хэрэгсэх тохиолдлууд байдаг. Хэрэв бид хангалттай хугацаанд үл хэрэгсвэл намжиж аажмаар бүр оргилохоо болино гэж найддаг.

Та бүхэн “өрөөнд байгаа заан” гэдэг яриа сонсож байсан байх. Та шархтайгаа хамааралтай мэдрэмжийг тань харуулсан баахан заанаар дүүрэн өрөөнд байна гэж төсөөлье л дөө. Та бодохдоо тэдний дээгүүр гараад эсвэл хажуугаар нь зөрөөд өнгөрөөд байвал тэд аяндаа өрөөнөөс гараад явчихна гэж боджээ. Гэтэл үнэн бодит зүйл бол бид гэмтсэн сэтгэл хөдлөлөө үл хэрэгсэн орхино гэдэг нь боломжгүй зүйл юм.

3. Өнгөрсөн үйл явдлын өнөөдөрт үзүүлэх нөлөөг үгүйсгэх

Сэтгэл зүйн хувьд эрүүл бус сүнслэг байдлын бас нэгэн шинж тэмдэг нь өнгөрсөнд болсон үйл явдлын өнөөдөр үзүүлэх нөлөөг үгүйсгэх юм. Үүнийг би “мартаад цааш явах” синдром гэж нэрлэдэг. Хэрэв энэ нь үнэхээр л үр дүнтэй байдаг байсан бол ямар гоё вэ, тээ? Та яг ингэх гэж оролдож үзсэн үү? Ингэх нь хэр үр дүнтэй байв? Асуудал нь өнгөрсөнд болсон ч шархлуулам үйл явдлын дурсамж тархинд сийлэгдсэн байдаг. Ариун Сүнсний эдгэрэлийг авалгүйгээр арчиж хаях, мартаж орхих, эсвэл үгүйсгэх боломжгүй юм.

4. Шархаа сүнслэгжүүлэх

Сэтгэл зүйн хувьд эрүүл бус сүнслэг байдлын дараагийн нэгэн шинж тэмдэг нь шархаа “сүнслэгжүүлэх” явдал юм. Үүнийг хэд хэдэн янзаар хийх боломжтой. Жишээ нь бидний шарх бол Паулын өргөстэй адилхан зүйл юм гэж хэлдэг нэгэн байна. Тиймээс сүнслэг бодит байдал гэдгийг нь хүлээн зөвшөөрөөд л цааш урагшлахаас өөр аргагагүй гэж хэлдэг. Зарим хүмүүс миний шарх бол “үүрэх ёстой загалмай” маань юм гэж хэлдэг. Бас нэг их сонсогддог зүйл бол библид шархыг “Түүний зовлонгийн хуваалцагч болох” гэж хэлдэг. Бид шархтайгаа зууралдсаар байгаагаа зөвтгөхийн тулд сүнслэг эсвэл библийн үгийг ашиглах нь “Би энэ шархнаас эдгэрч чөлөөлөгдөж чадахгүй нь” гэдэг үгийг хэлэхээс ч дор зүйл юм.

Магадгүй эдгээр нь маш сүнслэг сонсогдож болох ч би энэ үйлдлийг “Шоколадаар бүрсэн нохойн хоол” гэж нэрлэх дуртай. Нохойн хоол нь бидний шархыг илэрхийлж байгаа бол шоколадан бүрмэл нь өөрсдийн шархыг зөвтгөх гэсэн сүнслэг үгнүүд юм. Сонсоход таатай сонсогддог ч хазаход амтгүй тийм л зүйл. Та энэ зүйлийг хүснэ гэж үү?

Шарх ба Бурханы тухай бидний үзэл баримтлал

Энэ зүйлийн талаар хэсэг ярилцахыг хүсч байгаа ч энэ тал дээр яг юу хуваалцахыг минь та гайхаж байж болох юм. Ямар нэгэн шархлуулам үйл явдлын дараа хүмүүс “Би хүчирхийлүүлж байхад, хаягдаж байхад Бурхан хана байсан юм бэ?” гэж хэлэхийг сонсож байлаа. Энэ асуулттай зэрэгцээд “Хэрэв Бурхан бүхнийг захирдаг юм бол эсвэл Бурхан надад хайртай юм бол надад ийм зүйл болохыг яагаад зөвшөөрч байгаа юм бэ?” гэж хэлдэг. Хэрэв бид энэ бодлоо сэдэрээсээр байх юм бол Бурханы талаарх үзэл баримтлалд маань сөргөөр нөлөөлөх ч боломжтой.

Бурхан хэлэхдээ Тэр сайн, бидэнд хайртай, бүхнийг захирдаг гэдэг. Хэрэв энэ үнэн юм бол энэ шархлуулам үйл явдал болох үед яагаад хөндлөнгөөс оролцож зогсоогоогүй юм бэ гэж бид асуудаг. Хэдийгээр ийм боловч нэн тэргүүнд бидний ойлгох хэрэгтэй үнэн бол Бурхан Өөрийнхөө талаар хэлсэн бүхэн үнэн юм. Энэ үнэнийг өөрчилж орлуулах зүйл гэж байхгүй. Харин бид Бурханы үнэнийг өөрсдийн хүлээлтэд нийцүүлэх гэж оролддог. Үүгээр би юу гэж хэлэх гээд байгаа санаа нь Бурхан үнэхээр сайн, бидэнд хайртай, бүхнийг захирдаг юм бол энэ үйл явдал болоход хөндлөнгөөс оролцож зогсоох ёстой гэсэн хүлээлт байдаг гэсэн үг юм. Тэгээд Бурхан бидний хүлээлтэнд хүрэхгүй болохоор бид Бурханы сайн чанар, хайр, төгс эрх мэдэлд эргэлзэж эхэлдэг. Хэдий Бурхан бидний хүлээлтэнд хариулахгүй байлаа ч энэ нь Бурханы мөн чанарыг өөрчлөхгүй. Бид бол хязгааргүй Бурхантай харилцаж буй хязгаарлагдмал хүмүүс билээ. Бид “яагаад” гэдэг асуултанда хариулт авч чадахгүй үедээ Бурханд уурлаж, бухимддаг.

Төгс эрх мэдэлтэй, хайр дүүрэн, сайн Бурханы хөндлөнгөөс оролцдоггүйн хариулт нь Тэр гэмт хүмүүст чөлөөт сонголтыг өгсөнд байгаа юм. Бид өөрсдийн сонголтыг бусдыг хүчирхийлж, шархлуулахад ашиглаж болно. (Тэр ч байтугай энэ сонголтыг өөрийгөө хүчирхийлж, амиа хорлоход ч ашигладаг.) Нэгэнт Бурхан гэмт хүнд чөлөөт сонголтыг үлдээсэн тул хүмүүс бусдыг шархлуулах үйл явдалд оролцохыг нь Тэр зөвшөөрчихсөн гэсэн үг. Гэвч, ямар ч төрлийн шархлуулам үйл явдлыг Бурхан сайн уруу эргүүлэх чадалтай гэж бичсэн байдаг. (Ром 8:28) “Сайн” гэдгээр Бурхан юуг илэрхийлэхийн тулд энэ үгийг ашиглав? Би өөрийн хувийн түүхээр үүнийг тайлбарлая.

Энэ түүхийг хуваалцахаасаа өмнө хэлэх зүйл бол би аавынхаа хүчирхийллийн талаар 48 жилийн турш “яагаад” гэж асууж байсан юм. Бурхан үүнд хөндлөнгөөс оролцоогүйн төлөө би Түүнрүү гараа зангидаж байлаа. Би бүр Түүнээс холдон явж ч үзсэн. Хэрэв та яг одоо ийм нөхцөл байдалтай байгаа бол би ч мөн тэр замыг туулаад гарсан шүү. Харин ч хайр татам, энэрэнгүй, араас минь тэмүүлэгч Бурхан намайг Өөртөө эргүүлэн татсан бөгөөд аавын маань хэрэглэсэн хүчирхийллийг миний “сайн”-ы төлөө эргүүлж чадсан юм. Тэр “сайн” нь ямархуу харагддаг вэ?

Эдгэрлийн замаар алхах явцдаа аавын маань хүчирхийлсэн шалтгаан нь өвөөгийн маань аавыг хүчирхийлдэг байсантай холбоотой болохыг би ойлгосон. Аав маань өөрийнхөө ааваас авсан хүчирхийллийн талаар би сонсоод бүр гайхширсан. Үе дамжсан гэм нүглийн хохирол нь над дээр бууж ирснийг би ойлгосон. Би аавынхаа хүчирхийллийг үүгээр зөвтгөх гээгүй юм шүү. Мэдээж энэ бол гэм нүгэл байсан. Гэхдээ л аавд маань хэн ч Христ дотор бидэнд байдаг амийн талаар зааж байгаагүй гэдгийг ухаарсан юм. Тиймээс л аав маань хэдийгээр Христитгэгч байсан ч өөрчлөгдөн шинэчлэгдэх гэдгийг ойлгоогүй гэсэн үг. Үр дагавар нь бидний л нэгэн адил махан бие, гэм нүглийн хүч болон Сатаны хүлээсэнд буй хүчирхийлэгч болж хувирсан юм.

“Сайн”-ы бас нэгэн хэсэг нь Бурхан намайг эдгээж, аавыгаа уучлах хүсэлтэй болгож зүрх сэтгэлийг маань шинэчлэн өөрчилсөн юм. Гайхалтай нь Бурхан аавынхаа эсрэг байсан үл уучлалаас минь чөлөөлсний дараа би хэнийг ч уучилж чадна гэдгээ ойлгосон. Тэгж л би хэдийгээр Бурхан хүчирхийллийг зөвшөөрсөн ч намайг эдгээж, чөлөөлсөн хайрын, сайн Бурхан гэдгийг олж харсан юм. Дайсан бичээсийг хүртэл ашиглан эдгэрлийг өгч чадах цорын ганц Нэгэнд эргэлзүүлж, Түүнээс хөндийрүүлж чадна гэдгийг санаарай.

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

Бурханы эдгэрлийн үйл явцад бидний зүгээс оролцох оролцооны талаар үнэн

1. Бидний эдгэрлийн ЦОР ГАНЦ найдвар бол Христ доторх НАЙДВАР юм.

“Бурхан харь үндэстнүүдийн дунд энэхүү нууцын алдрын баялаг гэж юу болохыг тэдэнд мэдүүлэхийг хүссэн юм. Энэ нь та нарын дотор байгаа алдрын **НАЙДВАР БОЛОХ** Христ мөн.” Колоссай 1:27

“Тиймээс та нар оюун санаагаа үйлдэлд бэлтгэж, эрүүл ухаантай байж, Есүс Христийн илчлэлт дээр та нарт өгөгдөх нигүүлсэлд **НАЙДВАРАА БҮРЭН ТАВЬ.**” 1 Петр 1:13

Тэр зөвхөн АМЬ байгаад зогсохгүй бас НАЙДВАР юм. Бидэнд Христээс өөр эдгэрэх найдвар байхгүй. Нэгэнт таны дотор Христийн бүрэн дүүрэн байдал байгаа тул хэрэгцээтэй бүх Найдвар танд байна гэсэн үг. Өмнөх судлалаас шинэ гэрээнд найдвар гэдэг нь “итгэл дүүрэн хүлээлт” гэж суралцсан билээ. Тэгэхээр бидний үзэл бодол Христ энэ бүхэн **биелэх болно** гэж амласан тул энэ бүхэн нь **биелэх байх гэж** найдаж байна гэж хэлэх юм. Тиймээс л бид Бурханыг эрэлхийлэгчид гэж хэлэгддэг юм. Учир нь тэр бидний найдвар билээ.

Хүний найдвар ингэж хэлдэг: Хонгилын үзүүрт эдгэрлийн гэрэл гарна гэж би найдаж байна.

Христитгэл ингэж хэлдэг: Би (Есүс) бол тэр хонгилын үзүүр дэх гэрэл юм

Хүний найдвар ингэж хэлдэг: Би нэг ном нэмээд уншчихвал, би нэг удаа зөвлөгч дээр очвол, нэг л номлол сонсчихвол эдгэрэх байх.

Христитгэл ингэж хэлдэг: Би ном уншиж, зөвлөгч дээр очиж, номлол сонсож болох ч Христ л ЦОР ГАНЦ эдгээгч юм.

Хүний найдвар ингэж хэлдэг: Би итгэл алдарч байна.

Христитгэл ингэж хэлдэг: Би (Есүс) найдварыг төгсгөлгүйгээр хангах болно.

Сатаны нэг стратеги бол таны найдвараас хулгайлах явдал юм. Хэрэв та Бурханд найдах найдлага алдарвал үнэхээр найдвар тасарна гэдгийг тэр мэддэг.

Бурхантай харилцах нь: Хэрэв та эдгэрлийнхээ талаар найдвар тасарсан бол Бурхан таны найдвар гэж ятгаснаар үнэхээр Тэр таны найдвар болж эдгээхийн төлөө залбираарай.

2. Шархлуулам үйл явдлыг “сүнслэгээр” мартагч нь

“Ах дүү нар аа, би өөрөө хараахан барьж авсан гэж боддоггүй, харин нэг л юмыг хийдэг, **ардахаа мартаж**, урьдах зүйлс уруугаа зүтгэн тэмүүлж,” Филиппой 3:13

“**Ардахаа мартаж**” гэдэг үгээр Паул яг юуг илэрхийлсэн бэ? Бидний зүрх сэтгэлийг шархлуулсан үйл явдлыг бид хэзээ ч мартаж чадахгүй. Гэвч, тухайн шархлуулсан үйл явдлын дурсамж нь гол асуудлыг үүсгэдэггүй. Харин тухайн шархлуулсан үйл явдалаас үүдсэн **гэмтсэн сэтгэл хөдлөл** болон **худал хуурмаг итгэл үнэмшил** нь гол асуудал болдог. Бид тухайн үйл явдлыг оюун бодолдоо мартагчгүй байлгах боловч “сүнслэг” мартагналаар дамжуулан тухайн үйл явдлаас үүссэн гэмтсэн сэтгэл хөдлөл болон худал хуурмаг итгэл үнэмшлээсээ чөлөөлөгдөж, эдгэрэх боломжтой юм. Үүний талаарх ухагдахууныг тайлбарлая.

Электрон залгуураар шархлуулах үйл явдлыг төлөөлүүлье. Харин тухайн үйл явдлаас үүсэн гарах худал хуурмаг итгэл үнэмшил болон гэмтсэн сэтгэл хөдлөлийг тухайн залгуураар гүйх цахилгаан гүйдлийг төсөөлөе. Тэгэхээр тухайн үйл явдлын талаар санах бүрт та гараа залгуурт хүргэж байгаа гэсэн үг. Хэрэв та гараа залгуурт хүргэвэл тог гүйнэ. Харин тухайн залгуурын цахилгаан гүйдэл үүсгэгч үүсгүүрийг угаар нь унтраачихвал яах вэ? Хэдийгээр залгуур (үйл явдал) тэнд залгаатай байгаа боловч цахилгаан гүйдэл (гэмтсэн сэтгэл хөдлөл, худал хуурмаг итгэл үнэмшил) түүгээр дамжихаа болино. Энэ нь залгуур салгахтай л адил амархан байгаасай гэж бид хүсдэг ч тухайн мартагч үйл явц хормын төдийд ч болж болно эсвэл урт удаан үйл явц ч болж болно. Харин сайхан мэдээ нь юу гэвэл нэгэнт сүнслэгээр мартагч бол оюун бодолд дахин дахин орж ирсэн ч зүрхэнд маань нөлөөлөхөө больсон байдаг.

Бурхантай харилцах нь: Тухайн шархлуулам үйл явдлын талаарх үнэнийг оюун бодолд тань Ариун Сүнс шинэчилж өгөхийг Түүнээс гуйгаарай. Тухайн “цахилгаан гүйдэл”-ийг Бурхан унтрааснаар цаашид шархлуулам үйл явдлын талаарх шаналал байхгүй болох болно гэж Бурхан таныг ятгахыг Түүнээс гуйгаарай.

3. Хэрэв бид эдгээр өрөөндөө Эзэний эдгэрлийг зөвшөөрвөл ИЛҮҮ өвдөлттэй байна гэж боддог.

“Би өрөөндөө Бурханыг оруулж чадахгүй нь. Учир нь энэ их өвдөлттэй байх болно.” Би энэ үгийг маш олон удаа сонсож байсан. Харамсалтай нь та шархлуулам үйл явдлаас үүссэн зовлон шаналалаа өрөөндөө хийгээд түгжиж анхнаасаа л чадаагүй учраас тухайн үйл явдлаас хойш тэр шаналалыг тээсээр ирсэн л гэсэн үг. Тэгэхээр бид энэ шаналалдаа дасал болчихсон байдаг. Бидний зарим нь энэ шаналалдаа дэндүү удаан дассан учраас шаналал гэж хүлээж авахаа ч больсон байдаг. Тиймээс, Бурхан бидний үүдэн дээр ирээд эдгээхээр хаалга тогших үед эдгэрлийн үйл явцад бидний “танил биш” зовлон шаналал нэмэлтээр үүсэх вий хэмээн айдаг.

Эдгэрлийн үйл явц **зовлонтой байх вий гэсэн** худал хуурмаг нь нэг бол таны оюун бодол дахь төсөөлөл эсвэл дайсны тарьсан бодол юм. Таниас нэг асуулт асууя: “Хэрэв та Ариун Сүнсээр эдгээлгэхийг сонголтгүй шаналал дундаа явсаар байвал юу болох вэ?” Эдгэрээгүй зовлон шаналал бол банкны хугацаатай хадгаламжийн хүүтэй л адил гэдгийг санаарай. Тухайн зовлон улам л хүндэрч таны амьдралын талбар бүрт сөрөг нөлөөллөө гүн үлдээсээр байх болно.

Би дахин нэг асуулт асууя: “Та оёдол тавиулах хэрэгтэй шархаа оёулахын тулд өвдөлт мэдэрнэ гэдгийг мэдсээр байж яагаад эмч дээр очдог вэ?” Хэдийгээр оёдол тавиулах нь өвдөлтийг тухайн мөчид өгөх боловч эмчид очих нь л эдгэх ганц зам гэдгийг та мэддэг. Сэтгэл санааны эдгэрэл ч яг үүнтэй адил юм. Эдгэрлийн үйл явцад мэдээж өвдөлт байх боломжтой, гэхдээ л эцсийн үр дүн нь эдгэрэл юм.

Бурхантай харилцах нь: Хэрэв та яг энэ нөхцөл байдалд байгаа бол үүдээ нээж Бурханыг оруулахгүй байх нь өвдөлтийг улам л даамжруулна гэдгийг илчилж, үүдээ нээхэд тусалж өгөхийг Бурханаас гуйгаарай.

4. Эдгэрэлд зөвлөгч, ментор, ном, номлолын нөлөө

Бурханд таныг эдгээх зэвсгийн агуулахад нь маш олон сүнслэг “зэвсэг” байгаа. Тэр таны эдгэрэлд зориулан зөвлөгч, ном, номлол гэх мэт зүйлсийг ашиглаж болно. Гэхдээ эдгээр “зэвсгийг” хэрэглэх шалтгааны талаар таниас хэдэн асуулт асуумаар байна:

- Тухайн зөвлөгч эсвэл ментор Христ төвтэй юу? Тэр Бурханы тусламжтай өөрсдөө эдгээх эх сурвалж болох гэж оролдож байна уу? Эсвэл таныг эдгээхийн тулд Христийн хангамж руу таныг чиглүүлж байна уу?
- Таны уншиж буй ном өөрийгөө эдгээх техник, жор санал болгож байна уу? Эсвэл Ариун Сүнс л ганцхан эдгээж чадна гэдгийг илчилж байна уу?
- Таны сонсож буй номлол эдгэрлийн талаарх библийн үнэнийг ярьж, Христ рүү хандуулж байна уу?

Миний асуусан асуултууд танд туслах сонголт бүр нь Христ төвтэй байх хэрэгтэй гэдэгт чиглүүлж байгаа гэдгийг ойлгосон гэж итгэж байна.

Шархны эдгэрэлийн төлөө Бурхантай харилцах талаарх үнэн

Шархны эдгэрлийн төлөө Бурхантай харилцах талаар хэд хэдэн үнэнийг тантай хуваалцья гэж бодлоо.

1. Таны зүрхийг СУДЛАХЫГ Бурханаас гуй

“ЭЗЭН, намайг шалгаж, намайг туршаач. Миний оюун бодол, зүрхийг минь шалгаач.” Дуулал 26:2

“Өө, Бурхан, намайг судлан, миний зүрхийг мэдээч. Намайг шалгаж, миний бодлуудыг мэдээч. Миний дотор ямар нэгэн хөнөөлт үйл буй эсэхийг харж, Мөнхийн зам уруу намайг залаач.” Дуулал 139:23-24

Зүрхээ судлан мэдэхийг Бурханаас гуйна гэдэг бол агуу даруусал болон нээлттэй байдал юм. Та Бурханаар зүрхээ судлуулах зөвшөөрөл өгч байгаа нь Бурханд дараахь зөвшөөрлийг өгч байгаатай адил:

- а. Таны зүрхэнд юу байгааг харж, өөрөөс чинь илүү нэгэн хэрэгтэй гэдгийг харуулах
- б. “Нууцлагдсан” шархны талбаруудыг илчилж, харуулах
- в. Зовлон шаналалаас өөрийгөө тусгаарлах, хамгаалах, зугтах, үгүйсгэх, эвлэрэх гэх мэт өөрийн арга замуудыг чинь танд илчлэх
- г. Таны шарх “үхэл” авчирч байгаа зарим талбаруудыг танд илчлэх (уур хилэн, хорсол, үл уучлал гэх мэт)

Итгэлийн алхам: “Эзэн минь, миний дотор “үхэл”-ийг авчирч буй болон шархтайгаа эвлэрэх оролдлогуудыг илчилж өгөхийг би Таниас гуйж байна.”

2. Шархны талаарх итгэл үнэмшил, мэдрэмжээ Бурханд ИЛЭРХИЙЛЖ, шархныхаа талаар Бурханд МЭДҮҮЛ.

“ЭЗЭН, хэдий болтол юм бэ? Та намайг үүрд мартаж юм уу? Хэдий болтол Та надаас нүүрээ нуух юм бэ? Би хэдий болтол сэтгэлтэйгээ ярьж, Бүхий л өдөржин зүрхээрээ зовох юм бэ? Хэдий болтол дайснууд минь миний дээр өргөмжлөгдөх вэ?” Дуулал 13:1-2

Давидын дуулалыг унших юм бол тэр дахин дахин Бурханд хандан юу мэдэрч байгаагаа хэлж хашгирч байсныг харж болно. Бурхантай шударга, нээлттэй байх нь зүгээр. Бид заримдаа Бурханы сахилгажуулалт болон шийтгэлээс эмээхдээ үнэн сэтгэлээ хуваалцахаас цааргалдаг. Бурхан аль хэдийн таны юу мэдэрч байгааг мэдэж байгаа тул үүнийгээ үгээр илэрхийлэхээс эмээх хэрэггүй. Тэр мөнхөд таны юу мэдэрдгийг бүхлээр нь мэдэж байсан.



Та Бурханд уурлаж, гараа зангидан “яагаад” гэж асууж ч болно. Тэр бидний хүн гэдгийг мэддэг тул бүрэн биднийг ойлгоно. Заримдаа доторхоо “ариун”-аар уудлах нь чухал гэж бодож байна.

Бурхантай харилцах нь: Хэрэв яг одоо таны шарх сэдэрч шаналал, эргэлзээ, итгэлгүй байдлыг мэдэрч байгаа бол түүнийг Бурханд энгийнээр хэлэх цагийг гаргаарай. Бүү дар. Бурханд юу бодож, мэдэрч байгаагаа хэлээрэй.

3. Бурханд үүдээ нээвэл илүү их өвдөлт мэдэрнэ гэж АЙЖ байгаа тул хаалттай хандаж байгаа бол таны зүрхэнд ҮНЭНИЙГ ярихыг Бурханаас гүй

“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраая.”
Матай 11:28

“Амар амгаланг Би та нарт үлдэнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай.” Иохан 14:27

Эзэн хаалгыг тань тогшиж байгааг мэдэрч байгаа ч эдгэрэлтэй цуг өвдөлт ирнэ гэдгээс айхдаа үүдээ нээхгүй байж болох юм. Хэрэв энэ үнэн бол таны дэндүү удаан “дасал” болсон шаналал илүү даагдахгүй хүнд болно гэдгийг Бурханд хүлээн зөвшөөрөөрэй. Тэгээд Түүний амар тайван болон итгэлтэй байдлаар айдсыг тань сольж өгөхийг гуйгаарай.

Итгэлийн алхам: “Эзэн минь, эдгэрэл, чөлөөлөлттэй хамт өвдөлт ирэхээс би айж байна. Надад айх хэрэггүй гэж хэлээч дээ. Хэрэв өвдөлт ирэх аваас үүнийг давж гарахад Та туслаач. Өвдөлтийн цаана тэнгэрлэг эдгэрэл байгаа гэдгийг надад сануулаач”

4. Шархалсан бодолтой холбоотой оюун бодлын тулаан болж байдагт “сүнслэг” СЭРЭМЖТЭЙ байлгахыг Бурханаас гүй

Хоёрдугаар хичээл дээр үзсэн зүйлсээ давтан хэлбэл шархтай холбоотой оюун бодлын хүчтэй тулаан өрнөж байдаг гэдэгт соргог байх хэрэгтэйг сануулахыг Эзэнээс гуйж байх нь чухал юм. Бидний нэг талд тэнгэрлэг гурвал тулалдаж байдаг бол нөгөө талд үүний эсрэг “ариун бус” гурвал тулалдаж байдаг юм. Бид бодлоо олзлуулахгүй бол шархны нөлөө улам л хүндэрч, хуримтлагддаг гэдгийг сурсан билээ. Тиймээс, уг тулаанд орохор Бурханд даатгахаасаа өмнө үүнийг соргогоор хүлээж авсан байх хэрэгтэй юм. Тулааны талаар ойлголтуу байвал тулаанд ялагдаж, шарх улам л даамжрах болно.

Бурхантай харилцах нь: “Эзэн минь, шархлуулам бодлын талбарт маш хүчтэй тулаан өрнөж байдаг гэдгийг байнга сануулж, соргог байхад туслаарай.”

5. Шархтай холбоотой бодол оюун бодолд орж ирмэгц АЗНААД, Бурханы үнэнийг ХЭРЭГЖҮҮЛ

“Та нар итгэл дотор байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө батал.....” 2 Коринт 13:5

Оюун бодолд өрнөдөг тулааны талаар ярилцаж байхдаа оюун бодлоо олзлуулах хэрэгтэйг ярилцсан билээ. Бодлоо олзлуулна гэдэг нь түр “азнаж” байгаад тухайн бодол нь үнэн бодол уу эсвэл уруу татагч, махан биеийн, буруутгагч, худал хуурмаг бодол уу гэдгийг шалгах тухай юм гэж хуваалцсан билээ. Би танд шархалсан бодлынхоо хувьд ч гэсэн адилхан хэрэгжүүлэлтийг хийгээсэй гэж хүсэх байна. Учир нь шархалсан бодол нь худал хуурмаг итгэл үнэмшил, гэмтсэн сэтгэл хөдлөлийг авчирдаг.

Санаж байх хэрэгтэй нэг чухал зүйл бол тухайн “шархалсан” бодолдоо та хэт удаан автаад дэдчихсэн байдаг тул ямар ч асуулт, эргэлзээгүй түүнийгээ өөрийн болгочихсон байдаг юм. Та тогтмол тухайн бодолдоо автаад сурчихсан учраас шархалсан бодол гэдгийг нь ч анзаарахаа больчихсон байдаг.

Тиймээс тэр бодолдоо автахаасаа өмнө азнаад Ариун Сүнснээс орж ирсэн бодлуудын чинь талаарх үнэнийг хэлж өгөхийг асуу. Хэрэв тухайн бодол нь шархнаас улбаалсан бодол гэдэг нь хараахан илэрхийлэгдэхгүй байвал Ариун Сүнснээс үнэн юу болохыг илчилж өгөхийг асуугаарай.

Танд жишээ харуулья. Та эцэг эхийн чинь салалтаас болж шархалсан гэж бодъё. Энэ үйл явдлаас болж гологдол, эмзэг байдал, орхигдсон мэдрэмж гэх мэт шархалсан сэтгэл хөдлөлтэй болжээ. Эцэг эхийн тань салалттай холбоотой бодол орж ирэх болгонд тэдгээр сэтгэл хөдлөлийн мэдрэмж танд төрөх болно. Тэгэхээр дээр сурсанчлан ийм бодол орж ирмэгц түр азнах хэрэгтэй болно. Тэгээд энэ бодолтой холбоотой үнэнийг цэгнэж үзнэ. Яг үнэндээ Христ доторх таны шинэ мөн чанар бол аюулгүй, хүлээн зөвшөөрөгдсөн гэдэг үнэн юм. Удаахи үнэн бол хэдийгээр эцэг эх тань таныг голж орхисон байлаа ч Еврей номонд хэлэхдээ таны тэнгэрлэг Эцэг “таныг хэзээ ч орхихгүй” юм.

Магадгүй таны бодолтой холбоотой гэмтсэн сэтгэл хөдлөл танд сөрөг нөлөө үзүүлэхээ болих хүртэл энэхүү үнэнийг дахин дахин давтах хэрэгтэй болох байх. Заримдаа тэрхүү үнэнийг чангаар тунхаглах ч хэрэгтэй болж магадгүй юм. Ингэх нь шархлуулсан бодлын эсрэг үр дүнтэй арга болохыг би суралцсан билээ. Тэгэхээр итгэлийн алхам нь иймэрхүү харагдах болно:

Итгэлийн алхам: “Эзэн минь, би бодож байгаа бодлоо таны өмнө өгөөд шархлуулсан бодол эсэхийг илчилж өгөхийг Таниас асууж байна. Энэ бодол орж ирэх бүрт миний үнэн мөн чанар бол бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн, аюулгүй бөгөөд Та намайг хэзээ ч орхихгүй гэдгийг сануулж өгөөч”

ТАВ ДАХЬ ӨДӨР

6. Таны шархыг сэдрээх аливаа бодлуудыг Эзэнд ДААТГА

“Ачаагаа ЭЗЭНД даатга, Тэр чамайг өмгөөлнө. Зөв шударгыг ганхахыг Тэр хэзээ ч зөвшөөрөхгүй.” Дуулал 55:22

Орж ирсэн бодол бүрээ шалгах аас гадна тэрхүү бодол зовлонт дурсамжийг чинь сэдрээх бүрт тэр даруй Христэд тэр бодлыг даатга. Тэр бодолд хором ч автах хэрэггүй. Учир нь автах мөчид л таны зүрх сэтгэлийг ураг болно.

Бурхантай харилцах нь: Таны шархыг сэлрээгч бодол бүрийг Бурханд даатгаж эхэл. Тэгснээр Бурханы эдгээгч хүчээр тэр бодол орж ирлээ ч бага нөлөөлөл үзүүлж байгааг ойлгож эхлэх болно.

7. Таныг шархлуулсан бодлоос үүдэлтэй мэдрэмж, итгэл үнэмшлээс “Ариунаар” САЛАХ НЬ

Наалддаг товчийг төсөөлөөд бодоорой. Тэгвэл наалддаг хэсгийн нэг нь таны зүрх гэж төсөөлөөд нөгөө тал нь таны шархнаас үүдсэн худал хуурмаг итгэл үнэмшил болон мэдрэмж гэж төсөөлөө. Та шархлуулсан бодолдоо автах болгондоо л нөгөө гэмтсэн мэдрэмж болон худал хуурмаг итгэл үнэмшилдээ “наалдах” болно. Харин та бодлоо азнаад тэрний эсрэг үнэнийг ялган салгаж тунхаглах үед шархалсан бодлоос салах “ариун” салалтын үйл явц эхлэх болно. Тэгэхээр наалддаг товчийг аажмаар салгаж байгаатай адилхан юм.

Тухайн бодлоо салгах болгонд л сэтгэл санаа, зүрхний наалт салах шаржигнасан чимээг та сонсоно гээд төсөөлөөд бод доо. Шархлуулсан бодлоо салгаж сурах бүрт тухайн “ариун” хагацлын үйл явц хурдтай өрнөж эхлэхийг та анзаарах болно.

Итгэлийн алхам: “Эзэн минь, шархлуулсан бодол, мэдрэмжийг маань зүрхнээс маань “салгаж” өгөөч гэж би Таниас гуйж байна. Та бодлоо шалгаж, бодлынхоо эсрэг үнэнийг ярьж, ариун хагацлыг амсаж мэдрэх хэрэгцээг маань тогтмол сануулж өгөөч”

8. Шархлуулсан, хүчирхийлсэн хүн болон өөрийгөө УУЧЛАХ нь эдгэрэлд чухал юм

“Ингэхдээ нэг нэгнээ хүлцэж, бие биеэ уучилж, хэрэв хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал та нарыг Эзэн уучилсны адил та нар бас уучил. ” Колоссай 3:13

Та бүхэнд хуваалцсанчлан уучлахгүй бол сүнслэг эдгэрэл явагдахгүй. Энэ нь зөвхөн таныг шархлуулж, хүчирхийлсэн нэгнээр зогсохгүй өөрийгөө уучлахад ч хамаатай. Өөрийгөө уучлах хэрэгтэй шалтгаан нь та шархлуу-

лам үйл явдлын хариуцлагыг өөртөө тохсон байж магадгүйтэй холбоотой. Та уучлах хүсэл төрөхгүй байвал Бурханаас тэр хүслийг өгөхийг гуйгаарай.

САНАМЖ:

***Эзэн доромжлолыг тэвчиж, уучил гэж хэлээгүй.
Харин доромжлол үйлдэгчийг уучил гэж хэлсэн юм.***

9. Таны шархыг эдгээхээр ажиллаж байгаад нь Бурханд ТАЛАРХ

“Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. Сүнснийг бүү бөхөө.” 1 Тесалоник 5:18

Эдгэрлийн ямар нэг шинж тэмдэг илрээгүй байлаа ч Бурханд эдгэрлийнхээ төлөө талархах нь итгэлийн үйлс юм. Эдгэрлийг мэдэрч эхлэх үедээ Бурханд талархах нь амархан байдаг ч эдгэрлийн үйл явц эхэлсэнд итгэн талархаж эхлэхэд Тэрээр дуртай байдаг билээ.

Бурхантай харилцах нь: Таныг чөлөөлж, үнэнээр оюун бодлыг тань шинэчлэх үйл явцын туршид Бурханд талархах ариун дадлыг хөгжүүл.

Эдгэрлийн талаарх хүлээлт

“Өөрийн замыг ЭЗЭНд даатга, Мөн Түүнд итгэж найд. Тэгвэл Тэр биелүүлж өгнө.” Дуулал 37:5

Бидний Христигэлийн амьдралын бусад талбарт мөн адил байдаг хүлээлтийг Бурханы өөрчлөн шинэчлэлтийн үйл явц дээр мөн адил тавьдаг. Бидний хэзээ болон хэрхэн гэдэг хүлээлтэнд Бурхан хариулахгүй бол эргэлзээ, итгэлгүй байдал, бухимдал, Бурханыг орхих гэх мэт уруу татлагууд ирдэг.

Тиймээс Бурхан л эдгэрлийн үйл явц, цаг хугацаа, арга замыг мэдэх тул өөрийн хүлээлтийг “үхүүлэх” хэрэгтэй. Бидний хийх хэрэгтэй хэсэг бол Бурхан юунаас биднийг эдгээж, хэрхэн ажиллаж байгаа гэдэгт нь итгэх Христэд итгэлтэй байдал хэрэгтэй. Тиймээс л Дуулал 37:5 дээр Эзэнд өөрийн замыг **даатга**, эдгээнэ гэдэгт Түүнд **итгэж найд**, Тэр **биелүүлж өгнө** гэдэгт **Христэд итгэлтэй бай** гэж хэлээд байгаа юм.

Бурхан таны гэмтсэн сэтгэл хөдлөлийг эдгээж байгааг хэрхэн мэдэх вэ?

Та итгэлээр Бурхан руу ирэхэд Түүний хийж өгч буй өөрчлөлтийг **мэдэрч, амсахгүй** байж болох юм. Ялангуяа гэмтсэн сэтгэл хөдлөлийн хувьд тэр даруй мэдрэхгүй байх боломжтой. Бурхан таны оюун бодлыг үнэнээр шинэчилж байх явцад эдгэрлийн үйл явцыг мэдрэхэд цаг орж магад. Тэгвэл шарх эдгэрч байгааг батлах зүйл юу юм бол оо?



- Бурхан таны шархтай холбоотой худал хуурмаг итгэл үнэмшлийг үнэнээр шинэчлэх бөгөөд шархтай холбоотой гэмтсэн сэтгэл хөдлөл сэдэрх үед түүнд автахгүй байж чадахаар болгодог нь эдгэрэл юм.
- Ингэснээр шархтай холбоотой гэмтсэн сэтгэл хөдлөл таныг захирахаа больж эхэлнэ.
- Гэмтсэн сэтгэл хөдлөл Бурханы үнэнтэй нийцэхүйц сэтгэл хөдлөлөөр шинэчлэгдэнэ.
- Та гэмтсэн сэтгэл хөдлөл болон худал хуурмаг итгэл үнэмшлээс үүдэлтэй гэмт зан авир болон дасан зохицож эвлэрдэг байдлаа орхисон болохоо анзаарч эхэлнэ.

Дараахь түүх танд эдгэрэл хэрхэн явагддаг болохыг ойлгоход туслах байх гэж найдаж байна.

Өөрийнхөө аавд хүчирхийлүүлсэн эмэгтэй байсан юм. Үүнээс болоод тэр гэрлэх зохисгүй, үнэ цэнэгүй, бохир гэж итгэх болсон. Тэр гэрлэснийхээ дараа гэмтсэн сэтгэл хөдлөл болон үүнээс үүдэлтэй худал хуурмаг итгэл үнэмшлээсээ болоод бэлгийн дотно байдлыг мэдэрч чадахаа больсон юм. Харин тэр Христ дотор бүрэн бүтэн хангалттай (2 Коринт 3:5) гэдэг үнэнийг суралцсанаар Бурхантай харилцах болж үнэний илчлэлийг авсан. Ингээд үнэн илчлэгдэж, Бурхан түүний худал хуурмаг итгэл үнэмшлийг үнэнээр шинэчилснээр бохир, үнэ цэнэгүй гэдэг гэмтсэн сэтгэл хөдлөлөөс үүдэлтэй мэдрэмждээ автахаа больсон. Бурханы үнэнд итгэх үедээ

эмэгтэй Христ дотор хангалттай үнэ цэнэтэй гэдэг үнэнээр үнэ цэнэгүй, хангалтгүй гэдэг мэдрэмжээ сольсон билээ.

“Нугарашгүй”

Би танд нэгэн түүх хуваалцсанаар энэ бүлгийн хичээлийг дуусгая. 2014 онд “нугарашгүй” гэдэг нэртэй кино шинээр гарч байлаа. Энэ кино нь Льюис “Лью” Замперинигийн тухай түүхийг харуулсан. Энэ киноны зохиолыг Лаура Хилленбрандийн яг адил нэртэй номоос сэдэвлэсэн билээ. Киноноос илүү номыг нь унших нь түүхийн “бүтэн” зураглалыг харахад тустай гэж хэлмээр байна. Лью 10 жилд байхдаа мужийнхаа гүйлтийн аварга болсон юм. Тэр маш хурдан гүйдэг тул 1936 оны Берлиний Олимпод оролцох боломж нээгджээ. Хэдийгээр тэр ялаагүй ч 1940 оны Японы Олимпод ялах боломжтой гэж мэдэж байлаа. Гэтэл дайн мөрөөдлийг нь үгүй хийж тэрээр “Нисэх Хүч”-ний цэрэгт татагдлаа.

Лью Б-24 бөмбөгдөгч онгоцны нисгэгч болсон юм. 1943 оны 5 сарын 27-д газар буусан онгоцны эрэлд явж байх явцад онгоцонд техникийн асуудал үүсч 11 хүнтэй онгоц далайд унаж 8 нь амь үрэгддэг. Льюг оролцуулаад амьд үлдсэн 3 цэрэг усгүй, маш бага хүнстэй үлдэж, далайн бороонд дайруулж, түүхий загас идэж 47 хоногийг амь тэмцэж өнгөрүүлнэ. Тэд байнга махчин загасны дайралтыг эсэргүүцэж, шуурганд завиа хөмрүүлчих шахан тэмцдэг. Мөн Японы бөмбөгдөгчийн хараанд хэдэн арван удаа өртдөг.

Далайд байсан 47 дахь өдөртөө Маршал аралд хүрсэн боловч Япончуудад баригддаг. Лью 1945 оны 8 сард дайн дуустал гурван өөр олзлогдогсдын кемпэд аймшигтай зодуулж, тамлуулж байсан байна. Түүнийг голчлон тамладаг байсан харгалзагч “Шувуу” гэдэг хочтой байжээ. Дайн төгстөл тэр Льюг хайр найргүй тамлаж байв.

Мэдээж түүний бие махбод болон сэтгэл санааны шархыг үгээр ч илэрхийлэхийн аргагүй. Гэртээ харьж ирснийхээ дараа Япончуудын эсрэг, ялангуяа “Шувуу” хочит харгалзагчийн эсрэг уур уцаар, хорсол, үзэн ядалтаар дүүрсэн байлаа. Шөнө бүр л хар дарж зүүдэлнэ. Тэр зүүдэндээ “Шувуу”-ны хүзүүг боодог ч алахад хангалттай хүчээр боож чаддаггүй байлаа. Үүнээсээ болж өвдөлтөө дарахын тулд архинд донтох болов. Тэгээд эхнэрээ хэл яриагаар, сэтгэл санаагаар, сүүлд нь бие махбодиор хүчирхийлэх болов.

Эхнэр нь Льюгээс салах дээрээ тулсан байх үедээ Лос Анжелас хотод болсон Билли Грахамын сэргэлтийн цуглаанд хамрагдаж авралыг хүлээн авдаг. Түүний өөрчлөлт нь маш гайхалтай огцом явагдсан бөгөөд өөрт нь байгаа цорын ганц найдвар бол Христ гэдгийг мэддэг. Тэгээд нөхрөө бараг чирэх шахам сэргэлтийн цуглаанд авч очоод Христийг нөхөр нь аврагчаараа хүлээн авдаг. Тэр цагаас хойш ахиад хэзээ ч хар дарж зүүдлэхээ больжээ. Гэвч, Льюг энэ шаналалаас эдгээхэд олон жил шаардагддаг. Бурхан эдгэрлийн маш агуу ажил хийсэн тул Лью Японд өөрийг нь олзолсон хүмүүс дээр хувьчлан очиж уулзан уучласан гэдгээ хэлэхээр Япон руу аялдаг. Мэдээж тэд гайхширсан нь гарцаагүй. Зөвхөн “Шувуу” л түүнийг хүлээн авсангүй. Гэвч Лью түүнийг уучилсан гэдгээ илэрхийлсэн захиа бичиж “Шувуу”-нд хүргүүлдэг. Лью 2014 он хүртэл шархнаас эрх чөлөөтэй болсон амьдралаар амьдарсан билээ.

Би яагаад энэ түүхийг хуваалцсан бэ? Таны шарх аль хэр гүн, аймшигтай байхаас үл хамааран Бурхан хамгийн гүнзгий шархыг ч эдгээж, чөлөөлж чаддаг гэдгийг хэлэх гэсэн юм.

Дүгнэлт

Эхэнд хэлсэнчлэн, энэ хичээлийн сэдвээр хэд хэдэн номууд бичигдсэн байгаа. Гэхдээ зарим сэдвийг би хэтэрхий өнгөцхөн хөндсөн нь ч байгаа. Хэдийгээр шархлуулам үйл явдал болсон ч Лью болон бусад үйлчилж байсан хүмүүсийн маань нэгэн адил та ч мөн адил Бурханы эдгэрэл, чөлөөлөлтийг эдлэх боломжтой шүү гэдгийг хэлье.

Зургаадугаар Хичээл

Хүсэл зоригийн шинэчлэл


Эмтэрсэн байдал

НЭГ ДЭХ ӨДӨР

*“Биеийнхээ эрхтнүүдийг зөвт бус байдлын зэвсэг болгон нүгэлд бүү өргө. Харин Бурханд өөрсдийгөө үхэгсдээс амьд болгогсод мэт, мөн биеийнхээ эрхтнүүдийг зөвт байдлын зэвсэг болгон **Бурханд өргө.**” Ром 6:13*

Оршил

Бид хүсэл зориггүй эсвэл бие даасан хүсэл зоригтой авралд ирдэг тул сэтгэл санааны гурав дахь бүрдэл хэсэг болох хүсэл зориг ариусгагдах хэрэгтэй болно. Авралын үед бидний хүсэл зориг ямар байдалтай байдгийг доор диаграмаар илэрхийлж харуулжээ.



Бурханы хүсэл нь бидний хүсэл зоригийг шинэчлэх бөгөөд ингэснээр бидний хандлага Түүнээс бүрэн хамаарахын тулд бид хүслээ Түүний дуулгаварлал дотор авчрах юм. Гэвч, Христигэлийн алхааны эхэн үед бидний хүсэл зориг ихэнхдээ махан биеэр захируулаад сурчихсан тул маш зөрүүд, дуулгаваргүй байж Бурханы хүсэлд дуулгаварлахгүй байх боломжтой. Харин Бурхан бидний амьдралд ажилласнаар Түүнээс Эх сурвалжтай, Түүнээс хамааралтай амьдрах хүслийг Тэрээр өгөх болно. Энэхүү аялалд санаж байх хэрэгтэй нэг гол чухал үнэн байна.

Чухал Үнэн:


Та өөрийн хүслээр Бурханаас хамааралгүй байдаг байдлаа Бурханы хүсэлд дуулгавартай болох байдалд аваачиж ЧАДАХГҮЙ. Зөвхөн Бурхан үүнийг гүйцэлдүүлж чадна.

Зөвхөн Бурхан л таны итгэх хүсэл зориггүй, хамаарах хүсэлгүй, дуулгаваргүй байдлыг хүсэлтэй болгож өөрчилж чадна. Тиймээс, бидний зүгээс үйлдэх хэрэгтэй зүйл бол итгэлээр Бурханы өмнө ирж хүсэл зориггүй, бие даасан байдлаас өөрчлөгдөж хамааралтай, хүсэл зоригтой болгож өгөхийг гуйх явдал юм.

Бурхантай харилцах нь: Бурханд хандан Түүнд итгэх хүсэлгүй байгаа амьдралын талбаруудыг тань илчилж өгөхийг гуйж Түүнд хүслээ даатгаарай.

Таны хүсэл зориг бол оюун бодол болон сэтгэл хөдлөлд тань ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭГЧ гэдгийг санаарай.

Хүсэл зориг бол та юунд **итгэж**, юуг **мэдэрч** байгаад ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭГЧ гэдгийг санаарай. Хүсэл зориг таны юунд итгэж, юуг мэдэрч байгаад үндэслэн СОНГОЛТ хийдэг. Энэхүү үнэнийг доор диаграмд харууллаа.



Тиймээс, гэмтсэн сэтгэл хөдлөлөөс үүдэлтэй худал хуурмаг итгэл үнэмшилдээ итгэсээр байвал тухайн худал хуурмаг итгэл үнэмшилээр амьдрах сонголтыг хүсэл зориг тань хийсээр байна гэсэн үг. Худал хуурмаг итгэл үнэмшил дээр суурилсан сонголтуудыг хийж, тийнхүү итгэсээр байвал тэдгээр сонголтууд нь махан биеийн дагуух сонголтууд л байх юм. Тиймээс л Бурхан оюун бодол болон сэтгэл хөдлөлөө өөрчлөн шинэчлэхийн чухлыг хэлдэг бөгөөд ингэснээр махан биеийн сонголтын оронд бурханлаг сонголт хийхэд суралцах юм.

Бурхан таны оюун бодол болон сэтгэл хөдлөлийг Өөрийн үнэнээр шинэчилснээр Бурханы үнэнтэй нийцэх сонголтуудыг хийж эхлэх юм.

Асуулт: Махан биеийн дагуу амьдрахад хүргэдэг сонголтуудаа нэг ажиглаарай (гэмт зуршил гэх мэт). Эдгээр сонголтууд таны худал хуурмаг итгэл үнэмшил/гэмтсэн сэтгэл хөдлөлтэй холбогдож байна уу?

Бурхантай харилцах нь: Таны сонголтууд хэрхэн худал хуурмаг итгэл үнэмшилтэй холбогдож байгааг илчилж өгөхийг Бурханаас гуйгаарай.

Бууж өгөх, дагах, захирагдах, өргөх

“Харин Петр болон бусад элч нар тэдэнд -Бид хүнийг дагахаасаа илүү Бурханыг дагах ёстой. ” Үйлс 5:29



Та “бууж өгөх, дагах, захирагдах, өргөх” гэдэг үгийг сонсоод юуны тухай бодож байна? Бууж өгөх, дагах, захирагдах, өргөх гэдэг зүйлүүдийг Бурхан хүсдэг учраас эдгээр үгнүүд танд дарамтыг мэдрүүлж байна уу? Танай пастор эсвэл библийн багш нар бууж өгөх, дагах, захирагдах, өргөх гэдэг нь өөрийн хүчээр ТА өөрөө хийх зүйл гэж хэлж байсныг сонсож байсан удаа байгаа юу? Хэрэв тийм бол бууж өгч, дагах гэдэг шаардлагуудыг хүчээр та ТОГТМОЛ үйлдэж чадах уу? 1 Тесалоник 5:16-19-г хар:

“**Үргэлж баяртай бай. Тасралтгүй залбир. Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. Сүнсийг бүү бөхөө.** ” 1 Тесалоник 5:16-19

Энэхүү ишлэлд өгөгдсөн тушаалыг хараарай. Эдгээр тушаалыг та тогтмол үргэлжлүүлэн дагаж чадах уу? Захианд Бурхан эдгээр тушаалыг биелүүлж байхыг хүссэн байдаг. Гэхдээ түлхүүр нь энд байна:

Түлхүүр үнэн:

Бурханы тушаалын АЛИЙГ нь ч ТА тогтмол биелүүлэх ЧАДАМЖГҮЙ.

Би олон жилийн туршид эдгээр тушаалуудыг өөрийн хүчээр сахих гэж зүдэрсэн. Эдгээр тушаалуудыг сахихад Бурханы тусламжийг ч гуйж байлаа. Гэвч, эдгээр тушаалуудыг сахих хүсэл маань унтарч хичээсээр залхсан юм. Та ч мөн адил нөхцөл байдалд байгаа юм биш биз? Хэрэв та бууж өгч, дагаж, захирагдах Эх сурвалжаа Христээс авч амьдрахгүй бол эцэст нь бүтэлгүйтэх болно гэдгийг Бурхан мэддэг. Тэгэхээр бидний ойлгох хэрэгтэй чухал зүйл бол бууж өгч, дагах гэх мэт хүслүүдийг гүйцэлдүүлэхээс өмнө Бурхан Өөрөө ажлаа хийхийг хүлээх хэрэгтэй болно. Филиппой 2:13-г хар.

“Учир нь Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд та нарын дотор ажиллаж буй нь Бурхан юм.” Филиппой 2:13

Зөвхөн Бурхан хүслийг өгч, та Түүний хүч дотор алхах үед л бууж өгч, дагах үйлдэл хийж, тэр дотроо байх боломжтой. Хэрэв Бурхан танд хүслийг өгөхөөр ажиллахгүй бол та Бурханд тогтмол бууж өгч, дагаж, захирагдаж, өргөж чадахгүй. Миний хүслийг шинэчлэхийг Бурханд би зөвшөөрснөөр Түүний тушаалыг сахиж, Түүнд бууж өгөх хүсэлтэй болж эхэлсэн. Үндсэн ялгаа нь өмнө нь өөрийн хүчээр, хуульчлалын дор хийдэг байсан дуулгаварлал маань Бурханы бий болгож өгсөн хүчээр хийдэг болсон гэсэн үг.

Бурхан л таны хүслийг ШИНЭЧЛЭХГҮЙ БОЛ та бууж өгч, дагаж, захирагдаж, өргөх гэж ЗҮДЭРСЭЭР сүүлдээ бууж өгөх болно.

Хүсэл зоригоороо Бурханы хүслийг гүйцэлдүүлэх нь

“Тэр тэднээс жаахан цаашаа яваад, нүүрээрээ унаж,-Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог гэж залбирлаа. ” Матай 26:39

Над руу маш олон хүн холбогдож тэдний амьдрал дахь Бурханы хүсэл юу болохыг хэлж өгөхийг гуйдаг байсан нь гайхалтай. Би тэдний төлөөх Бурханы хүслийг хэлж өгч чаддаг байсан ч болоосой. Гэвч Тэр надад үүнийг хэлж өгдөггүй л дээ. Гэхдээ үүнээс ч илүү том тавих хэрэгтэй асуулт нь “Та өөрийн хүсэл зоригийг Түүний хүсэлд даатгахыг хүсч байна уу?” гэдэг нь юм. Бурханд хүсэл зориг, зорилго, таны амьдралын төлөөх төлөвлөгөө, бүр төгс төлөвлөгөө байдаг гэдгийг санаарай.

Асуудал нь итгэлийн алхааны эхэн үед бид Бурханы арга замын эсрэг өөрийн арга замыг хэрэгжүүлэхийг хүсдэг. Бурхан Өөрийн нигүүлслээ өгч өөрийнхөө хүсэл зоригоор үйлдээд үзэхийг зөвшөөрдөг нь үүний үр дүнгүй, өөрчлөлт авчирдаггүй байдлыг харуулахын тулд юм. Хэрэв Бурхан хэмжээлшгүй эрхэт юм бол Тэр бол сайн гэсэн үг бөгөөд зүрх сэтгэл нь таны төлөө байх тул яагаад та хүслээ Түүний хүсэлд даатгаж өгч болохгүй гэж?

Бид өөрийгөө Түүний хүсэлд даатгадаггүй хэд хэдэн шалтгаануудыг харууллаа:



1. Бурханы хүслийн эсрэг бидний махан бие өөрийн хүслийг биелүүлэхийг хүсдэг нь бодит үнэн
2. Бид ер бусын өөрчлөлтийг амсаж мэдрэх хүртлээ хангалттай урт хугацаанд итгэлээр алхаж үзээгүй байдаг байдал
3. Бид өөртөө итгэх итгэлээс илүүтэй Христэд итгэх хангалттай итгэлийг хөгжүүлж амжаагүй байдаг
4. Бурханы бидэнд хандсан төлөвлөгөөний эрх чадалтай, сайн сайхан, хайр зэрэгт ятгагдаагүй байдаг
5. Бид өөрийн хүслийг Бурханы хүсэлд даатгачихвал зовлон туулна гэж айдаг
6. Бид өөрсдийгөө Бурханаас ухаантай гэж боддог. Түүнээс ч илүү төлөвлөгөө надад байгаа гэж бид боддог.


Хамгийн сүүлчийн шалтгааны тухайд бид хэзээ ч амаараа өөрийгөө Бурханаас ухаантай гэж хэлдэггүй. Гэвч бидний үйл хөдлөл яг үүнийг баглахуйц байдаг. Үүнийг нэг бодоод үзээрэй. Хорвоо ертөнцийн Бурхан бол хэмжээлшгүй эрхтэй бөгөөд мөнхийн мэргэн ухаан ойлголт дотор бидний шийдвэрүүдийн талаар бүх л боломжуудыг мэддэг боловч бид Түүний төлөвлөгөөнөөс илүү өөрийн зорилго, төлөвлөгөөг дагадаг.

Сайхан мэдээ нь итгэлээр тогтмол алхсанаар Христэд итгэлтэй байдлыг хөгжүүлж Бурханы хүсэлд өөрийнхийг даатгахад илүү амар болж эхэлнэ. (Түүнд үнэхээр л илүү дээр төлөвлөгөө байдаг)

ХОЁР ДАХЬ ӨДӨР

Таны хүсэл зоригийн шинэчлэл ба “шугам”


Диаграмаар таны хүсэл зориг эхэндээ бие даасан, дуулгаваргүй байдгийг харуулжээ. Харин Бурханаас хамаарч эхлэх үед хүсэл зориггүй, бие даасан хүслийн маань үхмэл байдлыг Бурхан илчилж өгдөг. Тэрхүү “үхмэл” байдал хэрхэн харагддаг вэ? Бидний бие даасан байдлын үр дүнд бий болсон хандлага, махан биеийн зан авир зэрэг нь “үхмэл” байдал юм. Бидний бие даасан, хүсэлгүй хүсэл зориг үхсэнээр Бурхан бидэнд хамааралтай, хүсэл зоригтой байдлыг өгдөг.



Бурхан биднийг чиглүүлдэг талбаруудын заримаас харуулбал:

- Бурхан амласнаа биелүүлдэг бөгөөд Өөрийнхөө талаар хэлсэн бүхэн нь үнэн Бурхан гэдэгт итгэх хүсэл
- Өөртөө итгэхээс илүү Бурхан дотор итгэлээр алхах хүсэл
- Бурхантай цаг өнгөрүүлж, Түүний үгийг бясалгаж залбирах хүсэл
- Худал хуурмаг итгэл үнэмшлээс илүү Христ доторх үнэн мөн чанараараа алхах хүсэл
- Бурханы нигүүлсэл, сайн сайхан, хайрыг хүлээж авч, итгэх хүсэл
- Махан бие дотор алхахын эсрэг Ариун Сүнс дотор алхах хүсэл

Дараагийн диаграмаар итгэлийн алхааны эхэн үед Бурханы хүсэлд дуулгаваргүй байх байдал дуулгавартай байхаас илүү байдаг бодит байдлыг харууллаа. Гэвч, итгэлийн алхам хийснээр дуулгаварлах хүсэл маань дуулгаваргүй байдал багасахын хирээр өсдөг болохыг харууллаа.



Сүнс



Асуулт: Хүсэлгүй байхын эсрэг хүсэлтэй байхад учирдаг зөрчлүүд тань юу вэ?

Чухал санаа:

Бидний ихэнхид бие даан, хүсэл зориггүй амьдардаг махан биеийн ОЛОН талбарууд байдаг учир тэдгээр талбар БҮРТ Түүнээс хамаарах хүслийг Бурхан өгөх хэрэгтэй болдог.

Хүсэл зориггүй байдалтай тэмцсэн нэгний түүх

Эхнэртээ зохисгүй ханддаг нэгэн эрийг би дагалдуулж байлаа. Энэхүү зохисгүй хандлага нь гэрлэлтийг нь “үхүүлж” байгааг Бурхан нэгэн цагт илчилсэн юм. Түүний хандлага гэрлэлтийг нь алж байгааг ухамсарласнаар эхнэрээ шүүмжлэхийн оронд хайрлах хүслийг өгөхийг тэр эр Бурханаас гуйсан билээ. Тэр эрийн өөрчлөлтийг харуулсан диаграмыг доор харуулья.



Хүсэл зориггүй байдлаас хүсэл зоригтой болохын тулд Бурхантай харилцах нь

Өмнө жагсаан хэлэлцсэн талбаруудыг хүсэлгүй байдлаас хүсэл зоригтой болгож өөрчлөхөд Бурханы оролцоог гуйгаарай. Энэхүү үйл явцад дараахь зарчмыг ашиглаарай:

1. Хүсэл зоригтой байхад зөрчилддөг талбаруудаа Бурханы өмнө ХҮЛЭЭН ЗӨВШӨӨР

Хүсэл зориггүй байдалтай зөрчилддөг талбар бүрийг тань Бурхан аль хэдийн таниас ч өмнө мөнхөд мэдэж байсан. Тиймээс нэн тэргүүний өөрчлөлтийн алхам бол эдгээр талбаруудаа Бурханд хүлээн зөвшөөрөх юм.

Бурхантай харилцах нь: Хүсэл зориггүй байдаг хувийн талбаруудаа эхэлж олоод, Бурханы хүсэлд өгөхгүй байгаа зөрүүд байдлаа хүлээн зөвшөөр.

2. Таны дотоод хүнд хүсэл зориггүй байдал “үхмэл” байдлыг бий болгож байгааг ИЛЧЛЭХИЙГ Бурханаас гуй

Бидний зөрүүд хүслүүдээс болж ямар гамшиг учирч байгааг бид сайн мэднэ. Гэвч, зарим талбаруудад гамшиг дотроо байсаар дасчихсан учраас бид түүнээсээ зуурчихсан байдаг. Тиймээс бид хүсэл зориггүй байдлаас үүдэлтэй гамшиг дунд урт удаан амьдарсан гэдгийг илчлэх Ариун Сүнсний тусламж хэрэгтэй.

Бурхантай харилцах нь: Хүсэл зориггүй байдлын тань учруулж байгаа үхмэл байдлыг илчилж өгөхийг Бурханаас гуйгаарай.

3. Хүсэл зоригтой байх ХҮСЛИЙГ өгөхийг Бурханаас гуй

Бурхан л танд хүсэл зоригийг өгч чадах тул таны хүсэл зориггүй байдалтай талбаруудыг нурааж өгөхийг Түүнээс гуйгаарай.

Бурхантай харилцах нь: Бурханы хүслийг эсэргүүцдэг байдлыг хүсэлтэй байдлаар сольж өгөхийг Бурханаас гуйгаарай.

Та Бурханыг эсэргүүцэж өөрийн зам руу эргэх юм бол өөрөөсөө үүдэлтэй хоосон, гамшиг болсон, зовлон зүдүүртэй ГАХАЙН ШАВАРТАА ахин шигдах болно гэдгийг санаарай.

Таны хүсэл зоригийг Бурхан шинэчлэх тал дээр та ямар хүлээлттэй байх хэрэгтэй вэ?

Оюун бодол болон сэтгэл хөдлөлтэй адил хүсэл зоригийн өөрчлөлт ч үйл явцтай. Таны хүсэл зоригийг шинэчлэх тал дээр Бурханыг эрэн хайхад Тэр хийж буй өөрчлөлтүүдээ танд бататган харуулах болно. Таны хүсэл зоригийг өөрчлөн шинэчлэх үйл явцад Бурхантай харилцах харилцаанд гарах зарим үр дүнг доор харууллаа:

- Бурханаас хамааралтай амьдрахын эсрэг махан биеийн дагуу амьдрахаар эсэргүүцдэг байдал **багасаж** эхэлнэ
- Таны хүсэл зоригийг өөрчлөх Бурханы өмнө ирэх **хүсэл** илүү ихэснэ
- Өмнө нь хүсэлгүй байсан талбарууддаа Бурханаас хамааралтай амьдрах **хүсэлтэй** болно
- Бие дааж, хүсэл зориггүй байх үед учруулах махан биеийн үхлийг илүү **соргог харж** чадна
- Христийн бий болгодог хүсэл зориг нь эрх чөлөө, баяр хөөр, амралт өгдөг болохыг **ухамсарлана**

Түүнээс хамааралтай байж, Түүнд дуулгаварлах агуу хүслийг Бурхан танд өгснөөр таны дотор буй Бурхан зүрхний тань хүслийг мэддээг бөгөөд танд хайртай гэдгийг тодорхой харж эхэлнэ.

ГУРАВ ДАХЬ ӨДӨР

ЭМТЭРСЭН БАЙДАЛ

Оршил



Бурханаар шинэчлүүлэх хүсэл зоригтой тань адил зарим талбарт өөрчлөгдөхийг хүсэхгүй байх байдал танд байх болно. Таны хүсэл зоригийг гэртэй тань зүйрлэе. Зарим өрөөндөө та бусдыг оруулахад нээлттэй боловч заримд нь оруулах хүсэлгүй л байдаг. Тэгвэл Бурханыг оруулах тал дээр яг үүнтэй адил байдаг. Зарим талбарт Бурханыг оруулж ажиллахад дургүйцэж, хүсэлгүй байдаг тохиолдол байдаг. Гэвч, Бурхан таныг хүсэлтэй болгохын тулд нөхцөл байдлуудыг ашиглахуйц танд хайртай билээ. Би үүнийг “юүлүүр”-ийн онолыг ашиглан тайлбарлая.

Юүлүүрийн онол - Хүсэлгүй байх үед

Ром 8:28 ишлэлд хэлдэгчлэн Бурхан “бүх юмс”-ыг та Түүнд хамааралтай байх хүслээр солихын тулд ажиллуулах болно. Доорх диаграмыг харна уу.

ЮУЛУУРИЙН ОНОЛ

Таныг хүсэл зоригтой
болгохын тулд
Бурхан
“бүх юмс”-ыг
ажиллуулдаг



Хүсэл зориггүй

Бид итгэлээр амьдрах ХҮСЭЛГҮЙ байх үед Бурханы ятгах үйл явц юу вэ?

Бурхан Өөрийн үнэнээр биднийг ятгах үйл явцыг бид эсэргүүцдэг талбар байдаг. Тэдгээр талбаруудад Бурхан биднийг чөлөөлөхийг хүсдэг боловч бид Түүний хүчин чармайлтыг эсэргүүцдэг. Яагаад? Бидний бие даасан махан бие тэдгээр талбаруудад хүчирхэг байдаг тул Бурхан ажиллахыг зөвшөөрдөггүй. Бид махан биеийнхээ талаар чухал үнэнийг мэдэх хэрэгтэй.

Таны амьдрал дахь Бурханы өөрчлөлтийн ажлыг махан бие ҮРГЭЛЖ эсэргүүцэх болно.

Тиймээс Ром 7:18 ном дээр Паул ингэж хэлсэн:



*“Учир нь миний дотор буюу миний **махан биед** ямар ч сайн зүйл байдаггүйг би мэддэг. Учир нь хүсэл нь миний дотор байвч, харин сайныг хийх нь үгүй.”*

Бидний махан бие Бурханы ажлыг эсэргүүцэх үед Бурхан Өөрөөс нь хамааралтай байлгахаар өөр үйл явцаар ятгаж эхэлдэг. Энэ нь махан биеийг маань үхмэл (сэтгэл санааны эмгэг) гэдгийг илчилж, Бурханыг эсэргүүцэх чадварыг нь устгадаг. Ингэснээр үр дүнд нь бид махан биеэсээ эргэж Бурханыг Эх сурвалжаа болгодог. Энэ үйл явцыг **эмтэрсэн байдал** гэж нэрлэдэг.

Асуулт: Та зарим талбарт Ром 7:18 дээр Паулын хэлсэн шиг зүйлийг мэдэрдэг үү? Таны хувийн амьдралын талбарт Бурханыг эсэргүүцэж байгаа махан биеийн хэлбэрүүдийг жагсааж бичнэ үү? Энэ нь таны сэтгэл санаанд ямар хямралыг үүсгэж байна вэ?

Бясалгал: “Хүсэл нь миний дотор байвч” гэсэн Ром 7:18 ишлэлийн хоёр дахь хэсгийг бясалга. Таны дотор буй хүсэл нь үнэндээ Христийн хүсэл зориг гэдгийг бодож үзээрэй. Тэр үргэлж таны дотор байсан бөгөөд үргэлж танд боломжийг өгч байдаг.

Бурхантай харилцах нь: Таны амьдралд Бурхан ажиллахыг эсэргүүцэж байгаа талбаруудыг илчилж өгөхийг Бурханаас асуугаарай. Тэдгээр талбаруудад хүсэлгүй байдлаас хүсдэг байдалд шилжүүлж өгөхийг Бурханаас асуугаарай.

Эмтэрсэн байдал гэж юу вэ?

“Хэн өөрийн амийг хадгалахыг хичээнэ (өөрийгөө), тэр хүн түүнийгээ алдана. Хэн амиа алдана (өөрийгөө), тэр хүн түүнийгээ аварна. (Христийн амь)” Лук 17:33, Мат 16:25, Марк 8:35, Лук 9:24, Иохан 12:25

“Амьд байгаа бид Есүсийн төлөө үхэлд (махан биеийн) байнга тушаагддаг. Ингэвэл Есүсийн амь мөн бидний үхлийн махан бие дотор илэрхийлэгдэх болно.” 2 Коринт 4:11

“Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв улаан буудайн үр газар унаад үхэхгүй бол тэр ганцаараа үлдэнэ. Харин хэрвээ тэр үхвэл олон үр бий болгоно.” Иохан 12:24



Энэ ишлэлийн түлхүүр үг нь “үхэл” юм. 2 Коринт 4:11 ишлэлд Паул махан биеийн үхэл чухал гэжээ. Махан биеийн үхэл гэдэг нь махан биеэс “эргэх” гэсэн утгатай. Ингэж эргэж, үхэхгүй бол Есүсийн амь бидний амьдралд илэрхийлэгдэхгүй. Иохан 12:24 дээр мөн л адил зүйлийг илэрхийлжээ. Бид махан биеэсээ эргэж үхэхгүй бол Ариун Сүнсний үр жимс амьдралд маань ургахгүй байх болно. Тиймээс Христийн амийг мэдрэхийн тулд “үхлийн үйл явц” явагдах хэрэгтэй нь эмтэрсэн байдал юм. Эмтэрсэн байдлын тодорхойлолтыг цааш харцгаая.

ЭМТЭРСЭН БАЙДАЛ:

Өөрийгөө болгох амьдралын хандлага, асуудлаа шийдэх гэсэн оролдлого, өөрийнхөө хэрэгцээнд хүрэх гэсэн махан биеэс эргүүлж Бурханыг Эх сурвалжаа болгоход хандуулах Бурханы үйл явц.

Товчхондоо Бурхан махан биеийн үхлийг чинь танд тодорхой болгосноор та Түүн рүү эргэж Түүний амь таны дотор, таниар дамжин гарахыг зөвшөөрөх үйл явцыг эмтэрсэн байдал гэнэ. (Таны махан биеийн тарьсан сэтгэл санааны үхлийг махан биеийн үхэл гэнэ) Эмтэрсэн байдлыг өөрөөр харвал Бурхан таныг зөөлөн, уян хатан болгосноор Түүний үнэнийг хүлээн авч тэр үнэнээр өөрчлөгдөхийг хэлнэ.

Санамж: Махан бие өөрөө үхдэггүй. Мэдээж бид энэ дэлхийг орхих хүртэл бидэнтэй цуг байх болно. Харин бид энэнээс эргэж махан биеийн хандлагууддаа үхсэнээр түүнийг хариу үйлдэл үзүүлэх чадварыг үгүй хийдэг.

Бясалгал: 2 Коринт 4:11 ишлэлийг бясалгаад “Яагаад Паул “байнга” гэдэг үгийг ашигласныг өөрөөсөө асууж үзээрэй. Энэ нь магадгүй эмтэрсэн байдал гэдэг нь нэг удаагийн л үйлдэл биш харин үйл явц гэдгийг ойлгуулах гэж оролдсон байж болох уу?

Бурхантай харилцах нь: Өмнөх дасгалаар жагсаан бичсэн махан биеийн талбаруудын тухайд тэдгээр махан биеийн үйлсүүддээ үхэж, тэдгээрээс эргэх хүслийг өгөхийг Бурханаас гуйгаарай. Итгэлийн алхам нь магадгүй доорхтой адил харагдаж болох юм:

“Эзэн минь, би махан биеийн талбарууддаа Таны ажлыг эсэргүүцэж байгаагаа мэдэж байна. Эдгээр талбаруудад махан бие маань надад учруулж буй үхмэл байдлуудыг илчилж өгөөч. Энэ байдлаас эргэж Таныг Эх сурвалжаа болгохоор эргэхэд туслаач”

Эмтэрсэн байдал нь нэг удаагийн үйл явдал биш үйл явц юм

Маш олон Христитгэгчид надад би хугарч, нугарч, эмтэрсэн гэж хэлж байхыг сонсож байлаа. Хэрэв та тэгж хэлдэг хүмүүсийн нэг бол яг үнэндээ бүрэн хугарч нугараагүй байна гэсэн үг. Яагаад? Бид махан бие дотор оршиж, гэмийн хүч бидний дотор ноёлж (биднийг үхэн үхтэл сэтгэл санаанд минь оршсоор байдаг) байгаа цагт бидэнд үргэлж л хугарч, нугарах хэрэгтэй талбар байсаар л байх болно. Эмтэрсэн байдал бол бидний ма-


хан биеийн үхмэл байдлыг илчилж, амийнхаа төлөө Бурхан руу хандах амьдралын турш явагдах үйл явц юм. Эмтэрсэн байдал бол биднийг үргэлжлүүлэн ариусгах Бурханы хэрэгсэл юм.

Эмтэрсэн байдал бол бидний махан биеийн үхмэл байдлыг илчилж амийнхаа төлөө Бурхан руу хандуулах АМЬДРАЛЫН ТУРШ ЯВАГДАХ үйл явц юм

“Шугам” ба эмтэрсэн байдал

Жишээлбэл таны бардам зан өөрчлөн шинэчлэгдэх хүсэлгүй байна гэж бодъё. Гэтэл Бурханы хүсэл нь таныг даруусал дотор амьдруулах байлаа. Тиймээс Бурхан таны амьдрал дахь “бүх юмс”-ыг буюу эрүүл мэнд, ажлаас халагдах, санхүүгийн зөрчил, шархлуулсан харилцаа гэх мэтийг даруусах боломж болгон өгчээ. Энэ бүх шаналал, цөхрөл, зөрчил, гамшиг нь танд хангалттай шаналал үүсгэх тул та “шугам”-аас дээш гарч бардам зан танд авчирч буй үхмэл байдлыг илчлэх Бурханы илчлэл рүү очих юм. Энэ нь таныг эмтэлж, хугална. Тэгээд таны хүсэл бардам зангаас биш дарууслаар амьдрах хүсэл зоригтой болно. Дараагийн диаграмд үүнийг дүрсэлжээ.

ЭМТРЭХ ҮЙЛ ЯВЦ



Эмтрэх үйл явц заавал зовлон дунд явагдах АЛБАГҮЙ

Бурхан биднийг хугалж, нугалж, эмтлэхийн тулд заавал зовлонтой үйл явдал өгдөг гэж олон хүн итгэдэг. Олонхи тохиолдолд мэдээж тэгдэг. Гэхдээ Бурхан миний хувийн амьдралын эерэг нөхцөл байдлаар дамжуулан худал хуурмаг итгэл үнэмшлийг маань хугалж, нугалсан тохиолдлыг хуваалцъя.

Би Христитгэгч болсон ч Бурхан бол сайн гэдэгт итгэдэггүй үе байсан юм. Теологийн хувьд Бурхан сайн гэдгийг мэдэж байсан ч зүрхний гүндээ итгэдэггүй байлаа. Би энэ үйлчлэлээ эхлэх үед Бурхан энэ худал хуурмагаас намайг хугалж, нугалах замыг бэлтгэсэн. Бурхан хугалах үйл явцаа үйлчлэлийн элбэг хангалуун байдлыг өгснөөр хийсэн билээ. Тэрээр үйлчлэлийг минь өсгөж Христитгэгчдийн амьдралыг гайхалтайгаар өөрчилж эхэллээ. Энэ нь Бурхан Өөрийн сайн гэдгийг надад батлах үйл явц гэдэг нь тодорхой болсон юм. Энэ бүхэн миний орой руу орсон өдрийг би тод санадаг. Би татгалзахын аргагүй сайн сайхнаар Бурхан намайг бялхаасан тэр өдөр миний худал хуурмаг итгэл үнэмшил хугарч унасан юм. Тиймээс эмтэрсэн байдал нь бидний амьдралд эерэг болон сөрөг үйл явдлын аль алианаар нь өгөгдөх боломжтой.

Таны амьдралд тохиолдох ЭЕРЭГ эсвэл сөрөг нөхцөл байдлаар дамжуулан Бурхан биднийг эмтэлж, хугалж, нугалж чаддаг.

Үүнийг бодоод үзээрэй: Бурханы үнэний талаарх илчлэл авах бүртээ худал хуурмагаас эргэх нь эмтэрсэн байдал юм. Энэ нь заавал зовлонтой байдал дотор тохиолдох албагүй.

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

Биднийг эмтэрсэн байдалд авч ирэхийн тулд Бурхан юуг ашигладаг вэ?

Нөхцөл байдал

Махан биеийн дагуу байх нь илүү зөрчил, тэмцлийг л авчирна гэдгийг ойлгуулахын тулд Бурхан ажил, эрүүл мэнд, санхүүгийн талбарт асуудлуудыг зөвшөөрдөг. Энэхүү үйл явдлуудаар дамжуулан Бурхан биднийг махан биеэсээ татгалзаж Түүнийг Эх сурвалжаа болгохоор эргэхэд хүргэдэг.



Жишээлбэл: Та ажлаасаа халагдсан тул байраа алдахад хүрчээ. Хэрэв та махан биеийн дагуу байвал уурлаж, сэтгэл түгшиж, айх болно. Энэ нь таны сэтгэл санаанд эмгэг үүсгэхээс өөрийг хийхгүй. Харин Бурхан уур бухимдал, сэтгэл түгших, айх зэрэг нь махан биеийн дагуу зүйл гэдгийг ойлгуулах үед асуудлын гарцыг эрэлхийлэхээр Түүн рүү хандахыг ятгах болно.

Бурхантай харилцах нь: Та ямар нэг хүндрэлтэй асуудал дундуур явж байгаа талаараа бодоод үзээрэй. Тэдгээр зүйлс нь танд махан биеийн хандлагыг бий болгож байна уу? Энэ зүйлээр дамжуулан Бурхан таны амьдралд буй зүйлийг шийдвэрлэж өгөх гэж байж болох ч та Түүнийг эсэргүүцэж байгаа мэдрэмж төрж байна уу? Хэрэв тийм бол тэдгээр махан биеийн хандлагуудыг үхүүлж, Түүний ажиллах замыг эсэргүүцэх байдлыг болиулж өгөхийг Бурханаас гуйгаарай. Энэхүү итгэлийн үйлдэл нь дараахь байдлаар харагдах боломжтой:

“Эзэн минь, энэ санхүүгийн асуудал надад маш их санаа зовнил, түгшүүрийг бий болгож байна. Тиймээс би Танд энэ асуудлыг **даатгаж** байна. Махан биеийн маань эсэргүүцлийг та зайлуулж Таны амралт руу орж асуудлын шийдэл танд байгаа гэдгийг ухамсарлахад туслаач гэж гуйж байна”

Харилцаанууд

Бурхан зөрчилтэй, шархлуулсан харилцааг ашиглан тэрхүү харилцааны асуудлыг махан биеийн дагуу шийдэх гэдэг байдлаас хугалж, нугалдаг. Тэдгээр харилцаануудыг эдгээж, сэргээхийн тулд Бурхан руу очих хэрэгцээг харуулдаг.



Жишээлбэл: Таныг хамгийн их эсэргүүцдэг нэг хүнийг бодоод үзээрэй. Хэрэв та махан бие дотроо байвал хормын дотор л бухимдаж, уцаарлан, үл уучлал буцалж, хорсож эхлэх болно. Гэвч энэ харилцааг ашиглан Бурхан танд махан биеийн уур бухимдал, үл уучла-

лын хандлагыг тань илчлэн харуулж байх боломжтой юу? Бурханы хүсэл нь та өөрийн махан биеийн учруулж буй үхлийг олж хараад Түүн рүү хандах нь юм. Ингэж махан биеийн хандлагаар амьдрахын оронд Бурхан таныг өөрчилснөөр та тухайн хүнийг уучилж, хайрлах боломжийг Бурхан өгч байх боломжтой юу? Дашрамд дурдахад, таны үзэн яддаг хүний чинь хэрэгцээ юу вэ? Таны махан биеийн хандлага уу эсвэл Бурханы нөхцөлгүй хайр уу?

Бурхантай харилцах нь: Та зөрчилтэй байгаа харилцаандаа ямар төрлийн махан биеийн хандлагыг гаргаж байна вэ? Таны харилцаанд болон таны дотор тарьж буй махан биеийн тэрхүү хандлагын үхлийг харах “сүнслэг” харааг өгөхийг Бурханаас гуйгаарай. Бурхан таны махан биеийн хандлагыг нурааж таниар дамжуулан Бурхан тэр хүнийг нөхцөлгүй хайрлах боломжийг өгөхийг Бурханаас гуйгаарай. Энэ итгэлийн алхам дараахь байдалтай харагдах боломжтой.

“Эзэн минь, энэ хүний эсрэг буй үл уучлал, уур, бухимдлын надад учруулж буй үхлийг та харуулаач. Гэмшлийн зүрх сэтгэлийг надад өгч Таны уучлалаар энэ үл уучлал солигдох болтугай.”

Дотоод зөрчил

Худал хуурмаг итгэл үнэмшил, гэмтсэн сэтгэл хөдлөл, шарх, хүлээснээс үүдэлтэй дотоод зөрчлүүдийг хүртэл биднийг хугалж нугалахад Бурхан ашигласнаар Түүнд цаг мөч тутам найдах хэрэгцээг харуулдаг. Бидний хүн нэг бүрт махан биеийн хүлээстэй, Бурхан руу хашгирахад хүргэдэг дотоод зөрчлүүд байдаг. Бурхан эдгээр зөрчлүүдийг ашиглан бидний махан бие болон Бурханы ажлыг эсэргүүцдэг байдлыг илчилдэг. Энэхүү зөрчлөө Бурханд өгөхийг Тэр хүсдэг.



Жишээлбэл: Та шүүмжлэмтгий, өөнтөгч махан биеийн дагуух байдалтай зөрчилддөг гэж бодъё. Энэ талбарт таны махан бие хугарч нугарах хүсэлгүй байжээ. Таны махан бие нөгөөх өөнтөгч байдлыг чинь сэрээх үед Бурхан таны өөнтөгч байдлын учруулж байгаа үхлийг танд илчилж, тухайн өөнтөглөж байгаа хүн рүү тань хандуулахыг хүсдэг. Энэхүү эвгүй байдлаар дамжуулан Бурхан таны махан биеийн эсэргүүцлийг нурааж, Өөрийн хайраар шинэчилэх болно.

Бурхантай харилцах нь: Та дотоод зөрчилтэй холбоотой ямар төрлийн махан биеийн хандлага, зан авиртай тэмцэж байна вэ? Бурхан танд тэдгээр хандлага болон эсэргүүцлийг илчилснээр Христтэй адил хандлагаар шинэчлэгдэж, хугарч нугарахын төлөө Бурханаас гуйгаарай. (Христтэй адил хандлагын талаар удахгүй суралцах болно). Энэхүү итгэлийн алхам нь дараахь байдлаар харагдах боломжтой:

“Эзэн минь, би хангалтгүй гэдэг худал хуурмагтай зөрчилдөж байна. Үүний улмаас би бусдад таалагдах гэж хичээдэг болчихжээ. Эзэн минь, энэ махан биеийн дагуух байдлын үхмэл гэдгийг харуулж Таны дотор би бүрэн хангалттай гэдэг үнэнээр намайг ятгаач”

Харилцаа, нөхцөл байдал, дотоод зөрчил бүрийг ашиглан Бурхан бидний махан биеийн үхмэл байдлыг ИЛРҮҮЛЖ, АМИЙНХАА төлөө Түүнрүү эргэхэд хүргэдэг.

ТАВ ДАХЬ ӨДӨР

Биднийг эмтэрсэн байдалд авчрахад Бурханыг юу хөдөлгөдөг вэ?

Бурхан биднийг эмтэрсэн байдалд хөтлөхөд хүргэдэг хүч нь Түүний ХАЙР юм.

Үүнийг ойлгоход бэрх байх. Учир нь олон хүн “Хайрын Бурхан яагаад миний амьдралд ийм их зовлон шаналал, толгойн өвчин болох зүйлсийг зөвшөөрч чадаж байна аа?” гэж асуудаг. Энэ үнэнийг заах нь надад хамгийн хэцүү байдаг.

Тиймээс би өөрийн үнэнээр гэрчлэл болгодог. Би амьдралдаа их зовлон, шарх, гологдлыг мэдэрсэн. Гэвч Бурхан энэ бүх зүйлийг миний амьдралд зөвшөөрч махан биеийн тусгаар байдлаас намайг салгаж Өөрлүү нь амийнхаа төлөө эргүүлэхүйц хайртай учраас ингэсэн гэж ятгасан. Энэ бүхэн Түүний агуу хайрын ажил байсан нь махан биеийн үхмэл байдалдаа гацаж хоцрохыг Тэр харахыг хүсээгүй учраас гэдгийг би ухаарсан. Энэ асуудлууд миний амьдралд болон эргэн тойрны хүмүүсийн маань амьдралд хүчтэй зовлон шаналал өгснийг харсан учраас тэр юм.

Тиймээс Түүний хайрын улмаас миний амьдралд тохиох зовлон бүрийг намайг хугалж, нугалан Өөртөө эргүүлэх хөшүүрэг болгон ашигласан юм. Би амьдралаа эргээд харахдаа чин сэтгэлээсээ Бурханд хандан “Миний амьдралд тохиосон зовлон гуниг болон шархлуулам үйл явдлуудаар дамжуулан амьдралыг маань устгаж байсан махан биеийн эсэргүүцлийг устгаж амьдралыг маань эрс өөрчилсөнд Танд баярлалаа” гэж талархдаг. Та яг одоо өнгөрсөн амьдралынхаа төлөө Бурханд талархах тэнхэлгүй байж болно. Гэхдээ Эзэн нэг л өдөр “нугарч, хугалахуйц” үйл явдал бүрийн ард Түүний хайр байсныг ойлгож Түүнд талархах тэр цэгт таныг хүргэнэ гэдэгт итгэлтэй байна.

Бурхантай харилцах нь: Таны амьдралд Бурханы хайранд эргэлзэж, өөрийнхөө талаар санаа зовохуйц зовлон шаналал, хүчирхийлэл, шарх тохиож байв уу? Эдгээр үйл явдлууд Бурханы талаар ямар мэдрэмжийг өгч байсан бэ? Хэрэв тэдгээр нь Бурханы талаарх сөрөг сэтгэгдлийг өгч байсан бол амьдралд тохиосон үйл явдал бүрийнхээ төлөө Түүнд талархаж чадахуйц цэгт хүргэж, зүрх сэтгэлийг чинь өөрчлөхийг Түүнээс гуйгаарай. Энэхүү итгэлийн алхам дараахь байдалтай харагдаж болно:

“Эзэн минь, намайг хугалж, нугалж байгаа энэ зовлонт үйл явдлын улмаас Таны хайр энэ бүхнийг тохиолдохыг зөвшөөрдөг гэж итгэхэд надад хэцүү байна. Энэ зовлон шаналалын дунд ч Таны хайранд итгэхийг ятгаж өгөхийг гуйж байна”

Эмтэрсэн болон эмтрээгүй байдлын ялгаа

Бүгдээрээ эмтэрсэн Христитгэгч болон эмтрээгүй нэгний ялгааг харцгаая.

Эмтрээгүй байдал

Тусламж эрэлхийлдэг
Махан биеийн гарц хайдаг
Бие даасан
Махан биеийн эрх ярьдаг
Өөртөө итгэлтэй
Өөрийгөө хамгаалсан
Бардам, биеэ тоосон
Бурханд эргэлздэг

Эмтэрсэн байдал

Бурханыг эрэлхийлдэг
Бурханаас гарц хайдаг
Хамааралтай
Махан биеийн эрхээ бууж өгсөн
Христэд итгэлтэй
Илэн далангуй, нээлттэй
Христийн даруу байдал дотор алхдаг
Бурханд итгэдэг

Дасгал: Та эмтрээгүй гэж боддог таны амьдралын нэг талбарыг харцгаая. Тэрхүү эмтрээгүй талбарыг тань дээрх шинж чанарын аль нь тодорхойлж байгааг бичиж үзэцгээе.

Бурхантай харилцах нь: Эдгээр талбаруудад Бурхан таныг эмтэлж өгөхийг гуйгаарай. Итгэлийн алхам нь доорхтой адил харагдаж болно.

“Эзэн минь, намайг доромжилсон энэ хүнийг үл уучлах сэдэл бүхий махан биеийн эрх маань мэдрэгдсээр байна. Би өөрийн үл уучлалыг Танд өргөж байна. Энэ хүнийг уучлахыг хүсэхгүй байгаа махан биеийн эрхээсээ татгалзаж тэр цэгт намайг аваачиж өгөөч”

Эмтэрсэн байдлын нөгөө талд юу байдаг вэ?

“Бид биедээ Есүсийн **үхлийг** үргэлж тээж явдаг. Ингэвэл Есүсийн **амь** мөн бидний бие дотор **илэрхийлэгдэх** юм. **Амьд байгаа** бид Есүсийн төлөө үхэлд байнга тушаагддаг. Ингэвэл Есүсийн **амь** мөн бидний үхлийн махан бие дотор **илэрхийлэгдэх болно.** ” 2 Коринт 4:10-11

Сайхан мэдээ! 2 Коринт 4:10-11-д бид өөрсдийгөө үхүүлдэг эмтэрсэн байдал нь Есүсийн амийг бидний дотор илэрхийлдэг гэсэн гайхалтай илчлэлийг өгчээ. Эмтэрсэн байдлын үр дүнд Есүсийн амь бидний дотор илэрхийлэгддэг ямар жишээнүүд байна?

1. Эмтэрсэн байдлын үр дүнд та **Бурханы хязгааргүй хайрыг харах болно.**
2. Бурханд **бүрэн дүүрэн найдах хэрэгцээгээ харах болно.**
3. Таны сэтгэл санааны **эдгэрэл ба сэргэлт**
4. Таны амьдралд хийж буй үйлсэд нь **Христэд итгэх итгэл бий болно.**
5. Махан биеийн бий болгодог цөхрөлийн оронд **Бурханы амар тайван ба амралтыг мэдэрнэ.**
6. **Махан биеийн хандлагууд** Христтэй адил хандлагуудаар **шинэчлэгдэнэ.**
7. Бурхантай **хувьчилсан, дотно харилцааг таашааж эхэлнэ.**

САНАМЖ:

Та эмтэрсэн байдалд ирэх хүртэл амьдрал дахь ХАЛУУХАН АСУУДЛУУДЫГ ихэсгээсээр байхуйцаар Бурхан танд хайртай. Учир шалтгаан нь эмтрээгүй байдалаас үүдэлтэй сэтгэл санааны эмгэг дотроо ахиад цаг алдахыг чинь Бурхан хүсдэггүй.


Дүгнэлт

Бурханы нэн тэргүүний хүсэл бол та өөрийн хүслийг Түүний хүсэлд дуулгавартай болгох явдал юм. Та Түүний хүсэлд дуулгавартай, захирагдаж, хамааралтайгаар алхвал таны хүсч буй үр дүн ирнэ гэдгийг Тэр мэддэг. Тиймээс Бурхан таны бодол болон сэтгэл хөдлөлийг шинэчилж үнэн дээр суурилсан сонголт хийхийг чинь хүсдэг. Бурханы ажлыг зөвшөөрөхгүй байхын хирээр таны амьдралд эмтлэх үйл явцыг эхлүүлэхүйц Бурхан танд хайртай. Мэдээж ихэнхи мөчид би Бурханы эмтлэх үйл явцыг таашаагаагүй. Гэвч эргээд харахад эмтэрсэн байдлын үр жимсний төлөө Бурханд би талархдаг. Та ч мөн адил зүйл хийнэ гэж би итгэж байна.

Дүгнэлт

Яг энэ мөчид ариусгалын үйл явцын талаар илүү дээр ойлголттой болсон гэж итгэж байна. Та өөрчлөгдөн шинэчлэгдэж байхад таны сэтгэл санаанд юу болж байдаг талаар дахин хуваалцахыг хүсч байна.

Таны сэтгэл санаа өөрчлөгдөн шинэчлэгдсэнээр



Та эдгээр талбаруудад өөрчлөлтийг мэдэрч эхэлж байна уу? Энэ судлалын түлхүүр үнэнүүдийг нэгтгэн харцгаая.

- Оюун бодлын шинэчлэл нь Бурханы үнэнээс суралцаж, Ариун Сүнстэй харилцсанаар “сүнслэг” шүүлтүүрийг бий болгож худал хуурмаг итгэл үнэмшлээ үнэнээр шинэчлэхээс эхэлдэг.
- Та үнэнд итгэж, түүгээр амьдарч эхэлснээр Бурхан таны хүлээсүүдийг нураах болно.
- Таны оюун бодолд тасралтгүй тулаан болж байдаг. Хэрэв энэ тулаанд Бурханыг оролцуулахгүй бол ялахгүй.
- Сатан таны Христ доторх алхааг сатааруулахын тулд тасралтгүй худал хуурмаг бодлыг тарьж байх стратегитай байдаг. Дайсны хамгийн том айдас нь үнэн гэдгийг санаж яваарай.
- Ариун Сүнс таны оюун бодлыг үнэнээр шинэчилснээр худал хуурмаг итгэл үнэмшилтэй нягт зууралдсан гэмтсэн сэтгэл хөдлөл болон шархыг тань эдгээх болно.
- Таны оюун бодол шинэчлэгдэж, гэмтсэн сэтгэл хөдлөл эдгэрснээр таны сонголт Бурханы үнэнтэй нийцэх болно.
- Бурхан амьдралд тохиох бүх зүйлсийг таныг эмтлэхэд ашигласнаар таны үнэнээр амьдрах хүсэл тань өсөх тэр байдалд авчирдаг.

Та өөрийн сэтгэл санааг агуу АМРАЛТ руу орсныг харах болно



“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг (ЧИНИЙ АМРАЛТ БАЙЯ) АМРААЯ.” Матай 11:28


Сэтгэл санаа шинэчлэгдсэнээр таны оюун бодол, сэтгэл хөдлөл агуу амралтыг мэдэрдэг. “Амралт” гэдгээр юуг илэрхийлж байна вэ? Энэ нь таныг уур бухимдал, айдас, санаа зоволтоор чилээдэг бодлууд цаашид байхгүй болно гэсэн үг. Таныг амралтгүй, уур бухимдалтай болгодог сэтгэл хөдлөлүүд таныг цаашид захирахаа болино гэсэн

үг. Хийх сонголтууд тань Бурханы үнэнтэй нийцэж Христэд итгэх итгэл өсөх болно. Бурханы үйлсийн эсрэг эсэргүүцэл намжиж илүү амар амгалан амралтыг мэдэрнэ. Эдгээр бүх зүйлс таны сэтгэл санаанд “ер бусын амралт”-ыг өгөх болно.

Энэ бүхний цаана юу байгаа вэ?

Христ дотор Өөрчлөгдсөн амьдралаар амьдрах нь хэмээх дөрвөн бүлэг дагалдагч бэлтгэх сургалтын гурав дахь номыг та дуусгалаа. Энэхүү цувралын дөрөв дэх ном нь *Христийн бялхам байдлаар амьдрах нь* нэртэй. Та дараагийн цувралыг судлахыг хүсвэл үйлчлэлийн вэбсайт руу www.christislifeministries.com нэвтэрч **Store** гэсэн хэсгээс энэхүү судлалыг олж аваарай.

Христ дотор Өөрчлөгдсөн амьдралаар амьдрах нь цувралын доор *Христийн бялхам байдлаар амьдрах нь curriculum* гэсэн хэсэг харагдах болно. Та хэвлэмэл хувилбарыг онлайн аар худалдаж авах эсвэл доорх и-мэйл хаягаар худалдаж авах боломжтой. Мөн цахим хувилбарыг үнэгүй татан авч өөрийн хүссэн хэмжээгээр олшруулах боломжтой.



Христийн бялхам байдлаар амьдрах нь ном дараахь үндсэн агуулга дээр төвлөрнө. Үүнд:

- *Христтэй адил хандлагыг бий болгогч Бурханы үйл явц*
- *Бурханаар бий болсон дотоод өөрчлөн шинэчлэл нь таны хувийн амьдрал, ажлын талбар, гэрлэлт, гэр бүлд хэрхэн бялхаж урсдаг вэ?*
- *Гэр бүл дотор, чуулганд, ажлын талбарт Христээр бялхаж амьдрах үйлчлэл хэрхэн харагдах вэ?*